

НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВИЙН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 10

Улаанбаатар хот

9.1.1 НЭГДҮГЭЭР БҮЛЭГ “БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН”

Монгол Улсын Стандартчилал хэмжил зүйн Үндэсний төвийн 2018 оны 05 сарын 31-ны 09 тогтоолоор Түргэн тусламжийн үйл ажиллагааны стандарт MNS6717:2018 стандартыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын ажлын хэсэг тус төвийн хамтарсан 2 жилийн хугацаанд боловсруулан батлуулан мөрдлөг болгож байна.

Эмнэлгийн Түргэн тусламж үйлчилгээний журмыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар болон ЭМЯ-ны Яаралтай тусламжийн мэргэжлийн салбар зөвлөлтэй хамтран боловсруулан Эрүүл мэндийн сайдын 2018 оны 11 сарын 30-ны өдрийн А/487 тоот “Ажлын хэсэг байгуулах” тухай тушаалаар тус төвийн 4 мэргэжилтэн оролцож батлуулахаар явуулсан.

а/ “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”

Зорилт 2: Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна.

1. 2018 оны байдлаар 129 удаа тохиолдож эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. Үүнээс гэрийн төрөлтөнд тусламж үзүүлж, амаржих газар тээвэрлэсэн эхийн эндэгдэлтэй холбоотой хамтарсан конференц хуралд оролцож, үүний дагуу гэрийн төрөлтөд очсон эмч нарын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, аргачлал зөвлөмж гарган ажиллаж байна.

2. 0-5 хүртэлх насны эмнэлгийн бус, гэрийн эндэгдэл: 2018 онд 0-5 насны хүүхдийн 57 тохиолдол байсан бол 2017 оны мөн үед 62 тохиолдол бүртгэгдсэн, 5 буюу 8.06%-иар буурсан байна. Эндэгдлийн байдлаас үзэхэд 2018 оны 57 эндэгдлээс 39 нь өвчлөл, 18 шалтгаан тодорхойгүй, ослын шалтгаантай байна. Үүний дагуу олон нийтэд тулгуурласан ХӨЦМ-ын сургагч багшийн сургалтад 3 эмч мэргэжилтэн бэлтгэж сургасан.

ХӨЦМ-ийн шинэчилсэн эмнэлзүйн 288 цагийн сургалтад нийт 172 эмч, сувилагч нарыг бүрэн хамруулсан ба ХӨЦМ-ийн үндэсний сургагч багш нараар удирдуулан зохион байгуулсан.

3. Нялхсын эндэгдэл 0-28 хоногтой нярайн эндэгдэл 2017 онд 5 байсан бол 2018 онд 6 гарсан байна.

б/ Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого /2017-2026 он/

Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоолд тусгагдсан зорилго

1. Эмнэлгийн яаралтай тусламжийн төвлөрлийг сааруулах, түргэн тусламжийн дуудлагын хугацааг багасгах, алслагдсан болон газар зүйн саад

бэрхшээлтэй нутагт оршин сууж байгаа иргэдэд үзүүлэх яаралтай тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд Нийслэлийн хэмжээнд хийгдсэн ажлууд:

2018 оны дуудлагын хүлээгдлийн үзүүлэлт

Үзүүлэлт		2017 он		2018 он		Харьцуулалт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Нийт дуудлага		275537	100%	279838	100%	4301	5.2%
Хүлээгдлийн МИНУТ	0-20 минут	96929	33.9%	105540	37.7%	8611	3.8%
	21-40 минут	82519	29.9%	86529	30.9%	4010	1.0%
	41-60 минут	49385	17.9%	48886	17.5%	499	-0.4%
	61-с дээш минут	46704	17.0%	38883	13.9%	7821	-3.1%

2018 оны дуудлагын хүлээгдлийг өмнөх онтой харьцуулахад 41-60 минутын хүлээгдэл 0.4%, 61-с дээг минутын хүлээгдэл 3.1%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



НТТТөвийн үндсэн үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт



Д/Д	Үндсэн үзүүлэлт	2017 он		2018 он		Харьцуулалт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
A	Нийт дуудлага	289139	100%	303275	100%	14136	4.6%
Үүнээс	Насанд хүрэгчдийн дуудлага	255021	88.2%	267928	88.3%	12907	0.1%
	Хүүхдийн дуудлага	34118	11.8%	35347	11.7%	1229	0.1%
Насанд хүрэгчдийн дуудлага	Үр дүнгүй дуудлага	10371	4.1%	13906	5.2%	3535	1.1%
	Төрөх	19300	7.6%	19789	7.4%	489	-0.2%
	Осол гэмтэл	46414	18.2%	48310	18.0%	1896	-0.2%
	Өвчлөл	178936	70.2%	185923	69.4%	6987	-0.8%
B	Яаралтай дуудлага	193177	75.7%	208213	77.7%	15036	2.0%
20 минутын очилт		160916	83.3%	180206	86.5%	19290	3.2%
C	Гэрийн төрөлт	116	0.6%	129	0.7%	13	0.1%
D	Нас баралт /нийт/	2562	1.0%	2712	1.0%	150	0.0%
Зүрхний шигдээс		3670	2.1%	3631	2.0%	-39	-0.1%
Тархины цус харвах		600	0.3%	498	0.3%	-102	0.0%
Даралт ихдэх		33173	18.5%	32044	17.2%	-1129	-1.3%
Хоол шингээх эрхтний бусад		7334	4.1%	7576	4.1%	242	0.0%
Умайн цус алдалт		338	0.2%	247	0.1%	-91	-0.1%

Амьсгалын замын цочмог халдвар	11924	6.7%	11034	5.9%	-890	-0.8%
Бөөр шээсний замын бусад	9679	5.4%	9292	5.0%	-387	-0.4%
Халдварт өвчин	789	0.4%	846	0.5%	57	0.1%
Хорт хавдар	5438	3.0%	5114	2.7%	-324	-0.3%
Сэтгэцийн өвчлөл	968	0.5%	1063	0.6%	95	0.1%
Бусад	105023	58.8%	114578	61.6%	9555	2.8%

2018 онд нийт дуудлага 14136 буюу 4.6%-иар өссөн байна. Мөн яаралтай дуудлага 2.0%-иар нэмэгдэж, яаралтай дуудлагын 20 минутын очилт 3.2%-иар өссөн байна. Гэрийн төрөлт, нас баралт тус тус 0.1%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Өвчлөлийн үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад хоол боловсруулах замын өвчин, халдварт өвчин, сэтгэцийн өвчин тус тус өссөн үзүүлэлттэй байна.








ТТТөвийн 2018 оны жилийн эцсийн эмнэлгийн тусламж үйлчилгээний өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт

Эмнэлгийн тусламж үйлчилгээ		2017 он		2018 он		Харьцуулалт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Нийт дуудлага		255021	100%	303275	100%	48254	15.9%
A	Осол гэмтлийн дуудлага	46414	18.2%	48310	15.9%	1896	-2.3%
Шархны анхны цэгцэлгээ		3828	8.2%	4012	8.3%	184	0.1%
Боолт		4775	10.3%	4808	10.0%	33	-0.3%
Чиг		636	1.4%	723	1.5%	87	0.1%
Новокайны хориг		197	0.4%	331	0.7%	134	0.3%
B	Зүрх судас болон мэдрэлийн хурц эмгэг	37443	14.7%	36173	11.9%	-1270	-2.8%
ЭКГ		178	0.5%	83	0.2%	-95	-0.3%
ЗСА сэхээн амьдруулалт		160	0.4%	128	0.4%	-32	0.0%
Хүчилтөрөгч өгсөн		4011	10.7%	4642	12.8%	631	2.1%
Шингэн залгасан		769	2.1%	607	1.7%	-162	-0.4%

С	Бусад өвчлөл	171164	67.1%	218792	72.1%	47628	5.0%
	Судас тариа	20850	12.2%	18591	8.5%	-2259	-3.7%
	Бусад тариа	16928	9.9%	18566	8.5%	1638	-1.4%
	Эмнэлэгт хүргэсэн	45581	26.6%	40487	18.5%	-5094	-8.1%
	Бусад хэлбэрийн	198449	115.9%	197740	90.4%	-709	-25.5%



Осол гэмтлийн үед газар дээр нь үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг өмнөх онтой харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна.





д/д	Үндсэн үзүүлэлт	2017 он		2018 он		Харьцуулалт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
A	Салбаруудын нийт хүүхдийн дуудлага	35963	100%	35405	100%	-558	-7.5%
Үүнээс	Явж үзсэн дуудлага	35905	99.8%	35347	99.9%	-558	0.1%
	Амбулатори	58	0.2%	58	0.1%	0	-0.1%
	Утсаар зөвлөгөө өгсөн	211752		216709		4957	58.5%
	Яаралтай дуудлага	6307	17.5%	6937	19.7%	630	2.2%
	20 минутын очилт	5538	87.8%	6395	92.9%	857	5.1%
B	Өвчлөл	35905	91.8%	35347	96.0%	-558	4.2%
Үүнээс	Нярайн эмгэг	2063	6.3%	1735	4.9%	69	-1.4%
	Мэдрэлийн эмгэг	2743	8.3%	3154	8.9%	411	0.6%
	Амьсгалын замын эмгэг	19510	59.2%	19479	55.1%	-31	-4.1%
	Хоол боловсруулах замын эмгэг	3518	10.7%	3457	9.8%	-61	-0.9%
	Мэс заслын эмгэг	491	1.5%	369	1.0%	64	0.2%
	Халдварт өвчин	644	2.0%	499	1.4%	109	0.3%
	Бусад өвчин	6936	12.1%	6654	18.8%	1864	8.7%

Хүүхдийн дуудлага өмнөх онтой харьцуулахад 558 буюу 01%-иар буурсан үзүүлэлттэй байгаа боловч утсаар зөвлөгөө авах иргэдийн тоо нэмэгдсэн байна. Хүүхдийн яаралтай дуудлагын тоо 2,2%-иар нэмэгдсэн бөгөөд 20 минутын очилт 5,1%-иар өссөн үзүүлэлттэй байна.



- Автобааз нийт 115 жолооч 81 автомашинтайгаар эмнэлэг үйлчилгээний байнгын бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Өдөрт 42 автомашин үйлчилгээнд ажиллаж техникийн бэлэн байдлын коэффициентийг 98 хувь буюу 7 хувиар нэмэгдсэн нь автомашины техник үйлчилгээ, засварыг хуваарийн дагуу чанартай хийлгэж автомашины сул зогсолтын цагийг түргэн шуурхай болгосонтой холбоотой юм. Парк ашиглалтын коэффициент 3 хувиар нэмэгдэж 57 хувь болсон нь дуудлагын тоотой уялдаж өдөрт үйлчлэх автомашины тоог нэмэгдүүлсэнтэй холбоотой.



- Нийслэлийн хүн амд төрийн үйлчилгээг хүргэх, байгууллагын стратеги хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн байгууллагын дүрмээр хүлээсэн үүргийн бодлого, зохицуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор Авто баазын вэбсайт <http://autobaaz-ambulance.mn/> хийлгэн диспетчерын дотоод сүлжээний программ болон жолооч нарын мэдээлэл, хууль тогтоомж зэрэг блогуудыг бүрдүүлэн ажиллаж байна.
- Түргэн тусламжийн төвлөрлийг сааруулах талаар Нийслэлийн хойд чиглэлийн иргэдэд шуурхай, хүртээмжтэй үзүүлэх зорилгоор “Түргэн тусламжийн Дамба цэг”



2018 оны 05 сараас 10 сарын хооронд Нийслэлийн хойд чиглэлийн иргэдэд өдөрт 2-3 эмч, автомашин үйлчилж түргэн тусламжийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэж хүлээгдэл буурсан.

в/ Нийгэм эдийн засгийн зорилтууд

- 4.2.12. Дүүргийн түргэн тусламжийн төвүүдийн үйл ажиллагааг бэхжүүлэн, автомашины парк шинэчлэлт хийж, дуудлагын 20 минутын доторх очилтыг нэмэгдүүлнэ.
- 4.4.3. “Улаанбаатар Марафон” Олон улсын гүйлтийн тэмцээн, Нийслэлийн иргэдийн спортын наадмыг олон төрлөөр жил бүр өргөн хүрээнд зохион байгуулах
- 4.2.7. Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.
- 4.1.16. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжил боловсролоо дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажил зохион байгуулах
- 4.4.5. Идэвхтэй хөдөлгөөнд суурилсан олон талт арга хэмжээнүүд зохион байгуулах
- 2.4.23. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ болон төлөвлөгөөнд тодотгол хийх
- 3.3. Хот тохижилт ногоон байгууламжийн талаар

2018 оны байдлаар Нийгэм эдийн засгийн 19 үйл ажиллагаа хэрэгжүүлсэн ба гүйцэтгэл 97.8 хувьтай байна. Үүнд:

1. Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн автомашины парк шинэчлэлтийг нэмэгдүүлнэ.
2. Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн автомашинд GPS төхөөрөмж суулгана.
3. Эмнэлгийн эрүүл ахуй хепатит В,С вирусийн урьдчилан сэргийлэлт, эмнэлгийн тоног төхөөрөмжийн ариутгал, халдваргүйтгэлийн чиглэлээр ХБНГУ-ын Эссэн хоттой хамтран ажиллана.

4. Дуудлагын программ хангамж мэдээ мэдээллийн үзүүлэлтийг боловсронгуй болгох.
 5. Автомашины техникийн бэлэн байдлын хувийг нэмэгдүүлэх.
 6. Яаралтай дуудлагын 20 минутын очилтыг нэмэгдүүлнэ.
 7. “Улаанбаатар Марафон 2018” олон улсын гүйлтийг зохион байгуулна.
 8. “Мөнгөн Улаанбаатар” өвлийн наадмыг жил бүр зохион байгуулна.
 9. Идэвхтэй хөдөлгөөнд суурилсан явган болон дугуйн аялал, алхалт, иог, фитнессээр хичээллэх иргэдийн орчин нөхцөлийг бүрдүүлнэ.
 10. Байгууллагын төв болон салбарын хяналтын камерын тоог нэмэгдүүлж, ажиллагааг тогтмолжуулна.
 11. Эмийн зарцуулалтын программ салбаруудад хэрэгжүүлэх
 12. Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх үе шаттай сургалтуудыг зохион байгуулах.
 13. Ажилтан, ажиллагсдыг сургалтын хөтөлбөр боловсруулан батлуулж, тасралтгүй сургана.
 14. Гадаад дотоодын ижил төст байгууллагуудтай хамтран ажиллах
 15. Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх олон талт арга хэмжээ зохион байгуулах
 16. Ажилтан, ажиллагсдын ёс зүйн харьцаа хандлагыг сайжруулах, олон талт ажил зохион байгуулах
 17. Гамшгийн үеийн төлөвлөгөөг шинэчлэн мөрдлөг болгоно.
 18. Байгууллагын спортын арга хэмжээ зохион байгуулах
 19. Орчны ногоон байгууламжийн хувийг нэмэгдүүлнэ.
- г/ Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн Чингэлтэй дүүргийн 14-р хороо 702 мкв газрыг чөлөөлөн СБ болон ЧД-ийн 14-25 хорооны иргэдэд түргэн тусламжийн үйлчилгээг шуурхай, хүлээгдэлгүй, чанартай үзүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан барилгын ажлыг “Комп трейд ” ХХК, 75 хувийн гүйцэтгэлтэй байна.



д/ Нийгэм эдийн засаг, нийгмийн хөгжүүлэх үндсэн чиглэлийн дагуу 2018 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган ажилласан.

4.2.12. Дүүргийн түргэн тусламжийн төвүүдийн үйл ажиллагааг бэхжүүлэн, автомашины парк шинэчлэлт хийж, дуудлагын 20 минутын доторх очилтыг нэмэгдүүлнэ.

1. Түргэн тусламжийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх хяналт шинжилгээ үнэлгээг тогтмолжуулах зорилгоор Нийслэлийн хөрөнгө оруулалтаар

GPS системийг суурилуулахаар “Benqtech” компани шалгарсан ба Google map дээр суурилагдсан байрлал тодорхойлох системийг тус төвийн E1N программ хангамжтай тохируулан 2018 оны 11 сараас бүрэн ашиглаж эхэлсэн.

2. Дуудлагын хуудсыг программыг шинэчлэн боловсруулах олон улсын өвчлөлийн 10-р ангиллаар бүртгэн бэлтгэл ажлыг ханган зохих шатны байгууллагын эрх зүйн тушаал, зааврыг үндэслэн үйл ажиллагааг явуулахаар болсон.

2. Автомашины нөхөн хангалтын талаар холбогдох байгууллагад санал хүргүүлэх хүрээнд автомашины нөхөн хангалт, түргэн тусламжийн зориулалтын автомашины судалгааг гарган зохих шатны байгууллагад хүргүүлсэн ба 2018 оны 12 сарын 07 Нийслэлийн хөрөнгө



оруулалтаар 3 ширхэг автомашин хүлээлгэн өгсөн.

3. Автомашины парк ашиглалтын коэффициентийг нэмэгдүүлэх хүрээнд парк ашиглалтын коэффициент өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.0 хувиар нэмэгдсэн нь дуудлагын ачаалал, хүлээгдлийг багасгах зорилгоор автомашины өдөрт гарах тоог нэмэгдүүлсэнтэй холбоотой.

4. Мэргэшсэн жолооч нарын сургалтыг үе шаттайгаар явуулж, жолооч нарын ур чадварыг нэмэгдүүлэх хүрээнд шинээр ажилд орсон нийт 6 жолоочийн мэргэшсэн жолоочийн 21 хоногийн сургалтад хамруулж, В ангиллын мэргэшсэн жолоочийн үнэмлэх олгож ур чадварыг нэмэгдүүлсэн. Жолоочийн ур чадвар нэмэгдсэн нь зам тээврийн ослын тоо өнгөрсөн оны мөн үеэс 1 тохиолдлоор буурсан.

5. Автомашины эмнэлгийн хэрэгслийн аюулгүй ажиллагаа, хяналтыг тогтмолжуулах хүрээнд автомашинд суурилагдсан эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа болон ажиллагааны бэлэн байдлын хяналт шалгалтыг төлөвлөгөөт үзлэг үйлчилгээний дагуу 7 хоногт 1 удаа хийж тогтмолжуулсан. Хяналт, аюулгүй ажиллагааг үнэлэн, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэн ажилласнаар цаг тухай бүрд нь тоног төхөөрөмжийн оношилгоог хийж засварлан тоног төхөөрөмжийн найдвартай үйл ажиллагааг ханган ажилласан. Ингэснээр эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа уртсан доголдолгүй болсон.

6. Амилуулах суурь болон лавшруулсан сургалтыг тогтмолжуулан үр дүнг тооцох хүрээнд 2018 онд Нийслэлийн эрүүл мэндийн харьяа 14 байгууллагын эмч, сувилагч, эрүүл мэндийг ажилтан нарт давхардсан тоогоор 41 удаагийн 256 цагийн сургалтыг хийсэн ба нийт сургалтад оролцсон эмч, сувилагч, эрүүл мэндийг ажилтны тоо 2340 өмнөх оноос 201 эмч, сувилагч, эрүүл мэндийг ажилтнаар өссөн байна. Сургалтын ур чадварыг 25 асуулттай сорилоор оролцогч болгоныг дүгнэсэн ба сургалтын өмнөх сорил 42,3% байсан бол сургалтын дараа 66,5%-тай болж 24,2%-тай болж өссөн. Нийт сургалтад оролцсон ажилтны тоо 3360 өмнөх 2016 оныхоо 310 ажилтнаар өссөн байна. Сургалтын ур чадварыг 20 асуулттай сорилоор оролцогч болгоны дүгнэсэн ба сургалтын өмнөх сорил 55,3% байсан

сургалтын дараа 72,5%-тай болж ахиц 17,2%-тай болж өссөн сургалт үр дүнтэй болсныг харуулж байна.

7. Чанарын өдөрлөг, аян чанаржуулах ажлуудыг зохион байгуулах хүрээнд чанарын өдөрлөг:


1. “Халдварт өвчлөлөөс сэргийлье” өдөрлөгийг Хан-Уул дүүргийн 12 дугаар цэцэрлэгт явуулсан. Өдөрлөгийн хүрээнд: Томуу томуу төст өвчнөөс сэргийлье, Салхин цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлье” сэдэвт хичээл зааж, сурталчилгааны материал 50 ширхгийг тараасан.



2. Олон улсын эмч нарын өдрийг угтан чанарын албанаас “Чанарын өдөрлөг” зохион байгуулж 2018 оны 03 дугаар сарын 30-ны Олон улсын эмч нарын өдрийг тохиолдуулан хүндэтгэлийн үйл ажиллагаанд Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн удирдлагын зөвлөл, авто баазын төлөөлөл, дуудлагын 90 эмч оролцлоо. Тус төвийн шинээр ажилд орсон 25 их эмч нар тангараг өргөх ёслол болж эмч мэргэжлээрээ бахархах, эмчийн ёс зүй, харьцаа хандлага сайжирч, ажилдаа идэвх зүтгэлтэй ажиллах урам зориг өгсөн үйл ажиллагаа болж өнгөрлөө.



3. Идэвхтэй хөдөлгөөн эрүүл амьдралын төлөө цэвэр агаарт амралтаа зөв боловсон өнгөрөөх, нийтийн биеийн тамир, сонирхогчийн спортыг хөгжүүлэх зорилгоор "Цасны баяр-2018" өвлийн өдөрлөг 2018 оны 02 дугаар сарын 24-ны өдөр "Мөнгөн Улаанбаатар" оролцож Нийслэлийн "Шилдэг биеийн тамирын баг" цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулсан.



4. Чанарын албанаас зохион байгуулсан “Эмнэлгийн орчин-автомашин” сэдэвт өдөрлөг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр авто баазын гадна талбайд нийт 68 жолоочид дуудлагад үйлчлэх жолоочийн хувцаслалт, автомашины тоног төхөөрөмжийн эмх цэгцийг автомашины марк тус бүрээр цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг хоёр хувингийн арга болон органик бохирдол цэвэрлэх цомогтой хэрхэн ажиллах зааварчилгааг өглөө.



5. 2018 оны 4 дүгээр сарын 13-нд Амгалан амаржих газартай хамтран “Нярайн тусламжийн хожимдлоос сэргийлье” сэдэвт чанарын өдөрлөг зохион байгуулж сургалтад хамрагдсан. Эмч, сувилагч нарын нярайн тусламж үйлчилгээний мэдлэг, ур чадвар сайжирсан.

6. 2018 оны 05 дугаар сарын 05-ны өдөр “Дэлхийн гар угаах” өдрийг тохиолдуулан эмч нар гар угаах өдөрлөг хийсэн. Тус төвийн салбаруудын 90 гаруй эмч, сувилагч, жолооч нарын гар угаалтын түвшин тогтоож давтан сургалт явуулснаар тухайн түвшин дээшилж цаашид хяналтыг үргэлжлүүлж ажиллаж байна.



8. Олон улсын сувилагчийн эрхийг хамгаалах өдөрт зориулан “Үйлс гэгээн сувилагч таны алдрыг бахдан дуулъя” өдөрлөгийг тэмдэглэснээр сувилагч нарын ажиллах идэвх урам зоригийг дэмжсэн үйл ажиллагаа боллоо.
9. 2018 оны 6 дугаар сарын 09-ний бямба гаригт зохион байгуулагдсан “Өөрт хэрэггүй зүйлээ хэрэгтэй нэгэндээ өгцгөөе” уриатай хуучин эд зүйлсээ худалдах, солилцох, үнэгүй өгөх “Өгөөмөр өдөр” өдөрлөгт амжилттай оролцлоо. Салбарын нийт 45 эмч, ажилтан оролцож, ажилчдаас цуглуулсан хуучин эд зүйлсийг Хан-Уул дүүргийн 4-р хорооны 9-р хэсгийн ахлагч Г.Саранд хүлээлгэн өгч хамтран ажиллаа.
10. 2018 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр “Эрүүл мэнд эрхэм баялаг”, “Антибиотикын зохистой хэрэглээ” сэдэвт нээлттэй өдөрлөгийг “Цахиур төмөр эм ханган нийлүүлэх” байгууллагатай хамтран 1, 2-р ээлжийн 10 эмч, сувилагч нар зохион байгууллаа. Өдөрлөгийн хүрээнд 60 иргэнд АД үзэх, ЭКГ хийх, цусан дахь сахрын хэмжээ, Танита аппаратаар биеийн өөхний хэмжээг тодорхойлж, сурталчилгааны материал 250 ширхгийг тараасан.
11. 2018 оны 8-р сард СХД-ын 22-р хорооны засаг дарга, нийгмийн ажилтан, өрхийн эмнэлэгтэй хамтран иргэдэд “Осол гэмтлийн үед үзүүлэх яаралтай тусламж”, “Хүүхдийн амь тэнссэн үед үзүүлэх суурь тусламж” сэдвээр өдөрлөг, үзүүлэх сургалтыг 15 их эмч, сувилагч нар зохион байгуулж нийт 60 иргэдэд зохион байгуулсан.

Чанарын аян

1. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 23-ны А/06 тушаал “Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлье”, “Миний гэр аюулгүй орчин” аяны талаар мэдээллийг нийт эмч ажилчдад танилцуулж, удирдамж гарган төлөвлөгөө боловсруулж батлуулж дараах ажлуудыг хийсэн.
- 2018 оны 01 дүгээр сарын 31-нд “Гэмтлийн үеийн яаралтай тусламж”, “Амилуулах суурь тусламж” сэдвээр Б.Тэгшбаяр нийт 130 эмч нарт дээрх сургалт явуулснаар осол гэмтлийн газар дээрх яаралтай тусламж үзүүлэх талаар мэдээлэл өглөө. Осол гэмтлийн газар дээрх тусламж үйлчилгээ сайжирна.



- Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн 2-р курсийн оюутнуудад “Ухаангүй буюу ухаан алдсан хүнд үзүүлэх анхны тусламж”, “Тогонд түлэгдсэн болон цохиулсан хүнд үзүүлэх анхны тусламж”, “Хахсан үед үзүүлэх анхны тусламж”, “Шарханд боолт хийх арга техник” сэдвээр сургалт мэдээллийг өгсөн.

- 2018 оны 02 дугаар сарын 27-нд БЗД-ийн 21 дүгээр хорооны ӨЭМТ-тэй хамтран “Ахуйн ослоос урьдчилан сэргийлэх” авах арга хэмжээний талаар ӨЭМТ-ийн дарга Т.Аварга болон чанарын албаны дарга Х.Алтанцэцэг бусад эмнэлгийн мэргэжилтэн нартай хамтран сургалтыг зохион байгуулсан.

- a) Ахуйн ослоос урьдчилсан сэргийлэх авах арга хэмжээний талаар сургалт ӨЭМТ-тэй хамтран зохион байгуулах:
- b) Ард иргэдэд осол гэмтэл, гэнэтийн өвчин эмгэгийн үед эмнэлгийн тусламж иртэл гар доорх материалыг ашиглан өөртөө болон найз нөхөд, гэр бүлдээ үзүүлэх тусламжийн талаар сургалт зохион байгуулсан.



- Хан-Уул дүүргийн харьяа нутаг дэвсгэрийн сургууль болох 52 дугаар сургуулийн эмч н.Наранцэцэгтэй хамтран ажиллаж 7-р ангийн 3-н бүлгийн сурагчдад болзошгүй осол, гэмтэл, хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэх талаар сэрэмжлүүлэг мэдээлэл өгсөн. Эцэг, эх, сургуулийн өмнөх

хүүхдүүдэд “Миний гэр аюулгүй орчин”, “Бага насны хүүхдийг гэнэтийн аюул ослоос хамгаалъя” 12 дугаар цэцэрлэгийн 24 багш болон 25 хүүхдэд сургалт, сурталчилгаа явуулж, 50 ширхэг зөвлөмж тараасан.

- Сонгинохайрхан дүүргийн 62 дугаар 150 сурагчдад “Хахалтын үеийн яаралтай тусламж”, 12 дугаар хорооны сургуулийн 35 хүүхдэд “Түлэгдэлтийн үеийн яаралтай тусламж” сэдвээр сургалт явуулсан. Чанарын албанаас ахуйн осол гэмтэл, өвчлөлөөс хэрхэн сэргийлэх талаар шууд нэвтрүүлгээр иргэдэд 2 дугаар сарын 12, 19, 26, 3 дугаар сарын 01-нд MJL-102.5 радиогоор Даваа, Баасан гаригуудын 14:25 минутад ярилцлага өгөв. Ингэснээр сурагчдын эрүүл мэндийн боловсрол дээшилсэн.




2. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын тушаал 2/127 “Мененгококк болон бусад халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх” аян 2 дугаар сарын 12-оос 04 дүгээр сарын 01-ыг хүртэл удирдамж, 15 зүйлтэй төлөвлөгөө гарган ажиллаж, доорх ажлуудыг хийсэн.
 - 2018 оны 02 дугаар сарын 14-нд ХӨСҮТ-ийн “Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчний тасаг”-ийн их эмч н.Даваахүү “Менингококк-н халдварын эмнэл зүй, оношилгоо, эмчилгээ” сэдвээр нийт 122 эмч сувилагч нарт 50 минутын сургалт явагдаж эмч нарын мэдлэг, ур чадвар сайжирсан. Үүний үр дүнд ард иргэд, сургуулийн ахлах ангийн сурагчид осол гэмтлийн үед үзүүлэх анхан шатны мэдлэгтэй болсон.



- Салбаруудад “Менингококк-н халдвар”-ын хавтас нээж эмч нарын ажлын байрны өрөөнд байршуулан уншуулж танилцуулж байна. “Тууралтад халдварт өвчний ялган оношилгоо” хүснэгтийг хэвлэж эмч нарын ажлын байранд болон хүүхдийн дуудлага хүлээн авагч эмч нарын ширээн дээр байршуулан ажил үйлчилгээндээ хэрэглэж байна. Ингэснээр дуудлагын их эмч нарын ялган оношилгооны мэдлэг сайжирсан.



- “Менингококкт халдвар өвчин”-өөс сэргийлэх авах арга хэмжээний талаар зөвлөмж гаргаж салбаруудад тарааж, байршуулсан.
- Байгууллагын вэб сайтад иргэдэд менингококкт халдвараас сэргийлэх зурган зөвлөмж байршуулсан.
- Чанарын албанаас “Менингококкт халдвараас сэргийлэх” талаар зөвлөмж шууд нэвтрүүлгээр иргэдэд 2-р сарын 19, 26, 3-р сарын 01-нд, 05-нд, 09-нд, 16,19,23,26-ны өдрүүдэд тус тус MJL-102.5 радиогоор Даваа, Баасан гаригуудын 14:25 минутад 77011941 дугаарт өгсөн.



“Менингококкт халдвараас урьдчилан сэргийлье”, “Салхин цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлье”, “Эрүүл амьдрах дадалд сургах, томуу томуу төст өвчнөөс хэрхэн сэргийлэх, авах арга хэмжээний талаар 12-р цэцэрлэгийн 24 багш болон 25 хүүхдэд сургалт, сурталчилгаа явуулж, 50 ширхэг зөвлөмж тараасан.



Сонгинохайрхан дүүргийн 113 дугаар цэцэрлэгт Менингококкт халдвартай тэмцэх, сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай сургалт зохион байгууллаа. Сургалтад нийт 30 багш ажилчид хамрагдав.



2018 оны 03 дугаар сарын 06-нд Сонгинохайрхан дүүргийн 62 дугаар дунд сургуулийн 88 хүүхдэд их эмч назофарингитийн үзлэг хийснээс назофарингиттай 56 хүүхдийн 63% нь өвчтэй, 37% нь эрүүл байлаа. Үзлэг хоолой залгиурын зайлах аргачлалыг ярьж танилцуулав. Тухайн сургуулийн мэдээллийн самбарт менингококк-т халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж тавив. Тус дүүргийн 110

дугаар цэцэрлэг дээр 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдөр “Менингококкт халдвараас сэргийлье” сэдвээр нийт 20 багш, ажилчдад сургалт орж, идэвхтэй оролцлоо 20 ширхэг тараах материал, Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн Х.Алтантуяа багштай үсчний II дамжааны 20-н оюутан сурагчдад “Амьсгалын замын халдварт өвчнөөс хэрхэн сэргийлэх” сургалт орсон.

Ингэснээр тухайн сургуулийн сурагчид, цэцэрлэгийн багш ажилчид тухайн өвчний талаар мэдлэг сайжирсан.

Аяны хүрээнд хүүхдийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, газар дээрх болон эмнэлэг хүртэлх хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулах, дуудлага хүлээн авах, зөвлөгөөний дэвтэр болон карт бичилтийг чанаржуулах зорилготойгоор дараах ажлуудыг төлөвлөн хийж байна. Үүнд: Хүүхдийн дуудлагын хуудсыг шалгаж зөрчлийг газар дээр нь арилгуулах, зөвлөгөөний дэвтрүүдийг шинэчилж, хүүхдийн зовуурь болон зөвлөгөөг дэлгэрэнгүй бичүүлэх зэрэг ажлуудыг хийсэн.

3. “Сувилагчийн нэг өдөр” аяныг 2018 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр сувилахуйн тусламж үйлчилгээг иргэд үйлчлүүлэгчдэд сурталчлах, таниулах, сувилахуйн тусламж үйлчилгээний мөн чанарыг ойлгуулах, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, нийгмийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх, байгууллага хамт олны оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалъя” уриан дор Хүүхэд хамгаалах түр байр байгууллага дээр зохион байгуулсан.

Зохион байгуулсан үйл ажиллагаанд тус байгууллагын 12 багш, нийгмийн ажилтан, Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн 13 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн хамрагдсан. Тус төвд гэр бүлийн болон янз бүрийн хүчирхийлэлд өртсөн эрүүл мэндийн болон сэтгэлзүйн туслалцаа хэрэгтэй 0-16 насны 15 хүүхэд амьдарч байна. Нийт 120.500 төгрөгийн ахуйн хэрэглээ /живх, угаалгын нунтаг, саван, хүүхэд бүрийн тоогоор гарын алчуур, шампунь, 00 цаас г.м/ хандивласан.



Чанарын сургалт

1. 2018 оны 03 дугаар сарын 15-нд “Ларингитын үеийн эмчилгээний зарчим”, “Артерийн даралт ихсэлт зүрхний өвчний үеийн эмийн эмчилгээний стандарт” сургалт зохион байгуулав.



2. 2018 оны 5 дугаар сарын 09-ний өдөр Нийслэлийн Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн н.Энхжаргал, чанарын алба, 3 дугаар ээлжийн 42

эмч оролцож, эмнэлзүйн тохиолдлын тухай танилцуулж шүүмж хийж, арга зүйн зааварчилгаа өгч цаашид алдаа гарахаас яаж сэргийлэх, тухай дуудлагын эмч нартай харилцан ярилцав.

3. 2018 оны 4 дүгээр сарын 14-21-ний хооронд Герман улсын Эссэн хотын Анагаахын их сургуулийн доктор Walter Popp тус төвийн 32 эмч, сувилагч, жолооч нарыг багаар газар дээрх яаралтай тусламж хэрхэн үзүүлэх талаар сургалт явуулснаар сургалтад хамрагдсанаар гардан үйлдлийн ур чадвар нэмэгдсэн.



4. 2018 оны Нийт 85 жолоочид автомашинд суурилагдсан эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын сургалт явуулж, шалгалт авч дүгнэсэн.



Дээрх сургалтын үр дүнд тоног төхөөрөмжийн ашиглалтад жолооч нар эмчдээ тусалж багаар ажиллах чадвар нэмэгдсэн.

Судалгаа:

2018 оны 03 дугаар сарын 01-ны 2/189 Илтгэл ирүүлэх тухай Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 80 жилийн ойг угтан “Чанарыг сайжруулъя” онол практикийн хурлыг зохион байгуулж тус байгууллагын хэмжээнд 12 илтгэл оролцлоо. Үүний үр дүнд эмч нарын судалгаа хийх, илтгэл тавих чадвар нэмэгдсэн.



Үзүүлэх сургууль

1. 2018 оны 04 дүгээр сарын 30-нд “Тархины цус харвалт, артерийн гипертензи, мухар олгойн цочмог үрэвсэл”-ийн тусламж үйлчилгээг сайжруулъя” сэдэвт үзүүлэх сургалт хийж аргачлал, зөвлөмж гаргав.



2. 2018 оны 05 дугаар сарын 07-ны өдөр “Осол гэмтлийн үеийн эрэмбэлэн ангилалт, газар дээрх болон эмнэлэг хүртэлх тусламж, тээвэрлэлт” сэдвээр үзүүлэх сургалтыг зохион байгуулсан. Тус үзүүлэх сургалтад Чанарын албаны дарга Д.Мөнхцэцэг, салбарын эрхлэгч Д.Дариймаа, чанарын албаны менежер М.Наранбайгаль, II ээлжийн зохицуулагч Г.Гантуяа, III ээлжийн зохицуулагч Б.Эрхэмболд болон их эмч, сувилагч нарын нийт 28 хүн оролцсон. Ингэснээр осол гэмтлийн үед үзүүлэх тусламжийн зөвлөмж гаргалаа.

3.



4. Чанарын албанаас зохион байгуулсан “Эмнэлгийн орчин-автомашин” сэдэвт өдөрлөг 2018 оны 04-р сарын 26-ны өдөр авто баазын гадна талбайд нийт 68 жолоочид дуудлагад үйлчлэх жолоочийн хувцаслалт, автомашины тоног төхөөрөмжийн эмх цэгцийг автомашины марк тус бүрээр цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг хоёр хувингийн арга болон органик бохирдол цэвэрлэх цомогтой хэрхэн ажиллах зааварчилгааны үзүүлэх сургалт боллоо.





Үүний үр дүнд дуудлагын авто машины халдваргүйтгэх, угаах журам шинэчлэгдсэн.


Клиник хэлэлцүүлэг

- 2018 оны 3-р сарын 10-ны өдөр чанарын албанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу их эмч О.Дөлгөөн их эмч А.Хулангуа нар эмнэлгийн тусламж үйлчилгээний тохиолдлоор 17 эмч нарын дунд хэлэлцүүлэг зохион байгуулсан. Үр дүнд нь эмч нарын мэдлэг ур чадвар, ялган оношилгооны чадвар сайжирсан.
- Хан-Уул салбар дээр 2018 оны 04 дүгээр сарын 19-ны өдөр “Осол гэмтлийн үеийн тусламж үйлчилгээг чанаржуулъя” сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг зохиож, үүний үр дүнд осол гэмтлийн тусламжийг газар дээр хэрхэн үнэлж эрэмбэлэх, эмнэлэг хүртэлх сэхээн амьдруулалтын тухай үзүүлэх сургалт явууллаа. Ингэснээр осол гэмтлийн үед үзүүлэх тусламжийн зөвлөмж гаргалаа.
 
- 2018 онд Мэргэшсэн жолоочийн сургалтын системчилсэн сургалтад 8 жолоочийг хамруулсан.
 - Замын хөдөлгөөний дүрэм, дадлага
 - Амилуулах тусламж
 - Автомашины ариутгал халдваргүйтгэл
 - Автомашины тоног төхөөрөмжийн ашиглалт зэрэг нийт 16 цагийн сургалт зохион байгуулсан. Мэргэшсэн жолоочийн орон тоо нэмэгдсэн.

4. 2018 оны 5 дугаар сарын 09-ний өдөр Нийслэлийн Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн н.Энхжаргал, чанарын алба, 3 дугаар ээлжийн 42 эмч оролцож, эмнэлзүйн тохиолдлын тухай танилцуулж шүүмж хийж, арга зүйн зааварчилгаа өгч цаашид алдаа гарахаас яаж сэргийлэх, тухай дуудлагын эмч нартай харилцан ярилцав.



5. 2018 онд эмнэлгийн бус төрөлтөд очиж тусламж үзүүлсэн дуудлагын эмч нарын дуудлагын хуудсанд 5 дугаар сарын 22, 23, 24-нд хэлэлцүүлэг хийсэн. Тус хэлэлцүүлэгт төрөх үеийн тусламжийг эх барихын удирдамжийн дагуу үзүүлэх, дуудлагын хүлээгдэлгүй үйлчлэх, төрөлтийг удирдах гардан тусламжийн талаар 3 ээлжийн нийт 45 эмч нар хамрагдсан. Үүний үр дүнд эмнэлгийн бус төрөлтөд очиж тусламж үзүүлэх үед үйлчлүүлэгчээс зовуурь, өвчний түүх цуглуулах, бодит үзлэг, хэвийн төрлөгийн үед төрлөг удирдах үеийн гардан үйлдлийн талаар мэдээлэл өгч, дуудлагын хуудас бичих аргачлал, шалгуур үзүүлэлтийн хуудас гаргалаа.
6. 2018 оны 07 дугаар сарын 3, 4, 5-нд 20 хүүхдийн дуудлагын оператор их эмч, сувилагч нартай гомдлын дагуу хэлэлцүүлэг хийсэн. Хэлэлцүүлэгт харилцаа болон зөвлөгөө өгөх ур чадвар сэдвээр ярилцан тухайн гомдлоос сэргийлэх боломж, тулгамдсан асуудлаар ярилцаж, гомдлыг бууруулах үүрэг даалгавар өгсөн.
7. 2018 оны 09 дугаар сарын 25 өдөр Баянзүрх салбар гарсан алдаануудын дагуу чанарын албанаас хэлэлцүүлэг хийсэн. Тус хэлэлцүүлэгт нийт 15 их эмч “Тархины цус харвалт” сэдвээр дуудлагын эмч илтгэл тавьсан. Хүүхдийн тусламж үйлчилгээний дуудлагын хуудсанд үнэлгээ хийсэн талаар танилцуулж, шүүмж хийж алдааг бууруулах аян зохион байгуулах үүрэг даалгавар өгсөн. Тус салбар нь “Эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулъя” сэдэвт сарын аян зохион байгуулж алдаа буурсан.
8. 2018 оны 10 дугаар сарын 15-нд 20 хүүхдийн дуудлагын оператор эмч, сувилагч нартай гомдлын дагуу “Хүүхдийн дуудлагад хэрхэн эрэмбэлэн ангилалт хийх, дуудлага авах арга аргачлалыг сайжруулах” хэлэлцүүлэг хийж үүрэг даалгавар өгөв. Үүнд: Зөвлөгөө өгөх арга аргачлалыг сайжруулах, утсан харилцааны тухай судалж арга аргачлал боловсруулах, хүүхдийн дуудлагын хуудасны АШББХөтлөлтийг сайжруулах, стресс менежментийг эрчимжүүлэх талаар ярилцсан.
9. 2018 оны 11 дүгээр сарын 21-нд 4 дүгээр улирлын гомдлоор нийт 90 эмч нарт танилцуулж, хэлэлцүүлэг хийсэн. Чанарын албанаас гомдлын алдаа бүр дээр



шүүмж хийж эмч нарт анхааруулж, гомдол гаргасан эмч нарт үүрэг даалгавар өгч ажилласан.

10.2018 оны 11 дүгээр сарын 23-нд чанарын албанаас салбарын эрхлэгч нар болон ээлжийн ахлагч, зохицуулагч нар, хүүхдийн оператор их эмч, сувилагч нийт 15 ажилтан оролцсон “Хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулах” хэлэлцүүлэг уулзалт хийсэн. Тус хэлэлцүүлэгт хүүхдийн дуудлагын оператор нарт өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангалтгүй байгаа болон гомдлыг хэрхэн бууруулах талаар ярилцсан. Хүүхдийн тусламж үйлчилгээний журмыг шинэчлэх, зөвлөмж гаргах үүрэг даалгавар өгсөн.

11.2018 оны 11 дүгээр сарын 26, 27-нд “Ижил мэргэжилтний үзлэг хийх аргачлал” сэдвээр 1,2 дугаар ээлжийн нийт 20 их эмч нар оролцсон хэлэлцүүлэг хийсэн. Эмч нартай дотрын өвчлөлийн төрлөөр 20 дуудлагын хуудас дээр ижил мэргэжилтний үзлэг хийж үнэлгээг нэгтгэн дүгнэж хэлэлцсэн.

- Эмнэлгийн тусламж үйлчилгээг стандарт, удирдамжийн дагуу чанар хүртээмжтэй үзүүлэх, ур чадварыг сайжруулах зорилготой явагдсан. Тус төвд 3 хүртэл жил ажиллаж байгаа болон шинээр ажилд орсон их эмч, жолооч нараас мэргэжлийн ур чадварын үнэлгээг хийсэн. 2018 оны 10 дугаар сарын 17-- 24-ний хооронд хуваарийн дагуу 75 их эмч, 52 жолооч нараас үнэлгээг амжилттай хийж өндөрлөлөө. Дуудлагын их эмч нараас 7-н өртөөгөөр, дуудлагын жолооч нарыг 5-н өртөөгөөр ур чадварын үнэлгээг хийсэн.

Мэргэжлийн ур чадварын үнэлгээнд орох дуудлагын их эмч нараас өвчтэй 1, ээлжийн амралттай 1, чөлөөтэй 1 буюу 72 эмч буюу 96% оролцсон.

Дуудлагын их эмч нарын ур чадварын үнэлгээг :

1. Эмнэл зүйн өртөө нь эмчилгээ оношилгооны стандарт болон эмнэлэг үйлчилгээний удирдамжийн дагуу оношлох, эмчлэх, эмнэлэг хүртэлх тусламж үзүүлж байгаа үнэлгээ өгөх
2. Хүүхдийн яаралтай тусламж үйлчилгээний өртөө нь ХӨЦМ-2015, хүүхдийн зонхилон тохиолдох өвчин эмгэг, хүүхдийн эрэмбэлэн ангилалт яаралтай тусламжаар хүүхдийг үнэлж, оношлох, эмчлэх, эмнэлэг хүртэлх тусламжийг үзүүлж байгаад үнэлгээ өгөх
3. Осол гэмтэл, амилуулах суурь тусламжийн өртөө нь газар дээрх яаралтай тусламж болон эмнэлэг хүртэлх тусламжийг стандарт, удирдамжийн дагуу үзүүлж байгаа эсэх
4. Түгээмэл үйлдлийн өртөө нь MNS4621:2008 стандартын дагуу хийж гүйцэтгэж байгаа эсэх
5. Яаралтай тусламжийн эм тарианы өртөө нь ЭМСайдын 297 дугаар тушаалын дагуу эм тарианы үйлдэл, хэрэглээ, гаж нөлөө, жор бичилтэд үнэлгээ өгөх
6. Тоног төхөөрөмжийн өртөө нь дуудлагын автомашинд байрласан тоног төхөөрөмжийг яаралтай тусламж үзүүлэх үед ашиглаж ажиллуулж байгаа эсэх
7. Халдвар хамгааллын өртөө нь ЭМС-ийн 186, 187 тушаалын хавсралт 169-ийн дагуу гар угаах, гарыг халдваргүйжүүлэх шалгуур хуудсын дагуу авсан. Ур чадварын шалгалтын үнэлгээг А, В, С, D, F гэж тооцож D/60 оноо/ тэнцүүлсэн.

- Эмнэл зүйн өртөөний үнэлгээний дундаж 65,96%
- Хүүхдийн тусламж үйлчилгээний өртөө үнэлгээний дундаж 65,30%
- Осол гэмтэл яаралтай тусламжийн өртөө үнэлгээний дундаж 61,58%
- Түгээмэл үйлдлийн өртөө үнэлгээний дундаж 55,63%
- Яаралтай тусламжийн эм тарианы өртөө үнэлгээний дундаж 59,60%
- Аппарат тоног төхөөрөмжийн өртөө үнэлгээний дундаж 60,05%
- Халдвар хамгааллын өртөө үнэлгээний дундаж 58,76% байна.

Нийт эмч нарт стандарт, удирдамжийн дагуу онол болон гардан үйлдлийн ур чадвараа сайжруулахыг анхааруулсан.

Ур чадварын жолооч нарын үнэлгээ:

- Осол гэмтэл яаралтай тусламжийн өртөө үнэлгээний дундаж 61,58%
- Замын хөдөлгөөний дүрэм 64,33%
- Хаяг олох 78,43%
- Аппарат тоног төхөөрөмжийн өртөө үнэлгээний дундаж 89,17%
- Халдвар хамгаалал 68,16%
- Машины ариун цэвэр 63,48%

Дүгнэлт: Ур чадварын үнэлгээнд 3 хүртэлх жил ажиллаж байгаа эмч, жолооч нар 100% хамрагдлаа. Цаашид дээрх мэргэжлийн ур чадварын үнэлгээ хийх ажлыг тогтмолжуулж, чадавхжуулах сургалтын төлөвлөгөө гаргаж, сургалт явуулж ур чадварын сургалтыг тогтмолжуулж дуудлагын их эмч нарыг тогтмол дадлагажуулж эмнэлгийн тусламжийг чанартай үзүүлэх юм. Ур чадварын үнэлгээ хийх явцад гарсан зөрчлийг арилгах зөвлөмж гарган ажиллах.

- Нийт эмч нарын дуудлагын хуудас бичилтэд 24 удаагийн үнэлгээ хийж ээлжийн ахлагч, зохицуулагч нар алдааг дуудлагын эмч нарт танилцуулж цаашид гарах алдаандаа сэргийлэн ажилласан.

-Тус төвийн гэрийн төрөлтөд хийсэн судалгааны дагуу үнэлгээ хийж, дуудлагын эмч нартай дуудлагын хуудсаар хэлэлцүүлэг хийж зөвлөж, аргачлал гаргасан.



-Давтан дуудлагад судалгаа хийж, судалгааг танилцуулж, тусламж үйлчилгээний алдааг хэлэлцүүлэг зохион байгуулж тус тус үнэлгээ хийж үр дүнг тооцож ажилласан. Үүний үр дүнд сургалт, өдөрлөг, хэлэлцүүлгийг явуулсны үр дүнд илэрсэн алдаа буурч, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой гомдол буурсан.

- Осол гэмтлийн дуудлагын хуудсанд дүгнэлт хийж үнэлгээ хийж эмнэлгийн тусламжийг сайжруулах аян, өдөрлөг, хэлэлцүүлэг хийж зөвлөмж гарган алдаа буурсан.

-Эмийн санд дотоод хяналтын үнэлгээг сард 1 удаа буюу давхардсан тоогоор 15 удаа хийж, алдааг газар дээр нь засаж ажиллаж байна.

- Дуудлагын авто тээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдал, стандартуудыг даган мөрдөх талаар сар бүр үнэлгээ хийж эмнэлэг үйлчилгээнд үйлчилдэг бүх автомашинуудад техникийн үзлэг хийж, шаардагдах сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээг хийсэн. Уг үзлэгээр 12 автомашины өнгө үзэмж сайжруулж, 8 автомашины явах эд ангид засвар хийж, 118 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхийг шалгуулсан.



-2018 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд автомашинуудын бэлэн байдлыг шалгаж дараах техник үйлчилгээнд үнэлгээ хийлээ. Бүх автомашины заалны болон салоны паарыг шалгаж, 90-84 УНТ улсын дугаартай автомашины паарыг шинээр сольсон.



Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр хийсэн бүтээлч шинэлэг ажлууд, үр дүн:

- Эмнэлгийн болон сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүд нийт 19 нэр төрлийн 1 907 700 ₮-ний бүтээлч шинэлэг ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үр дүн: Эмнэлгийн болон сувилахуйн тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжирч эрүүл аюулгүй орчин бүрдсэн.
- Түргэн тусламжийн автомашины байршлын GPS-г нэвтрүүлээ. GPS системийг суурилуулахаар “Benqtech” компани шалгарсан ба Google map дээр суурилагдсан байрлал тодорхойлох системийг тус төвийн EIN программ хангамжтай тохируулан ажиллах талаар хамтран ажиллаж байна. Автомашины хяналтын GPS программыг нийт 70

автомашинд суурилуулсан. Уг программыг 2018 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн автомашины гаралт, буултыг бүртгэж, автомашиныг хянаж эхэлсэн. Gps программыг нэвтрүүлснээр дотоод хяналт сайжирч, жолоочийн тооцоо, эмнэлэг үйлчилгээнд үйлчлэх автомашинуудын шуурхай байдал нэмэгдсэн. Мөн засвар үйлчилгээ хийлгэсэн дэлгэрэнгүй тайлан, автомашины хувийн хэрэгт хөтлөгдөх жолоочийн авсан шатахуун, явсан км, үйлчилсэн дуудлагын тоо, хийгдсэн бүхий л засвар үйлчилгээнүүд зэрэг жолооч болон автомашины дэлгэнгүй бүртгэлийг хялбараар гаргах боломжтой болсон юм.

- Эмнэлгээс шалтгаалах халдвар болон бусад халдварт өвчнийг бууруулах чиглэлээр цус цэвэрлэх цомгийг 69 дуудлагын автомашинд байрлуулсан. Тус цомгийн нэг бүрийн үнэ нь 19000 төг нийт 1,311,000 төгрөг зарцуулагдсан. Энэ ажлын хүрээнд цус цэвэрлэх явцад халдвар тарах болон халдвар авах эрсдэл буурна.



Эмнэлгийн болон сувилахуйн тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжирч эрүүл аюулгүй орчин бүрдсэн.

- Автобаазын засварын цехэд автомашин угаах ариутгалын цэг байгуулсан. Дуудлагын жолоочид ээлтэй орчин бүрдүүлж, халдвар хамгааллаас сэргийлэн ажиллаж байна.



- ЭМС-ын 2014.06.02-ны 187-р тушаалын дагуу ариун цэврийн өрөөний гар угаалтуур болон бусад гадаргууг арчих алчуурыг шараар, өрөөний тоног төхөөрөмж хэрэглэл, хана цонхыг арчих алчуурыг цэнхрээр ялган оёсон.
- Эрүүл мэндийн сайдын 187 тоот тушаалын дагуу автоклавын ариутгал халдваргүйтгэлд тогтмол химийн, биологийн, физикийн хяналтыг Bowie disk, биологийн индикатор, туузан индикаторуудыг ашиглан хийж байна. Хяналтын дүнд ариутгал, халдваргүйтгэлийн процесс хэвийн явагдаж байна.

Чигний уут: Угааж цэвэрлэхэд хялбар, чанартай бат бөх материалаар 8 ширхэг шинээр хийсэн.

Материалын зардал:

Лидрен материал 6 метр*5000=30000
ш*500=8000

Метр цахилгаан 10 метр*600=6000

Оёдлын зардал -25000


Цахилгаан толгой 16

Бүч 6 метр*500=3000

Нийт зардал: 72000 төгрөг



- Ажлын байрын эрсдэл бууруулах ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр: Хан –уул салбарын ариутгалын өрөөний цэвэр бохир өрөөнд засвар хийсэн. Нийт үнийн дүн -50500



- Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр: Ижил төстэй эм тариаг өнгөөр ялгаж хаягжуулсан.



- Сувилахуйн албанд сургалтад зориулж тусламж үйлчилгээний иж бүрэн цүнхийг оёж байршуулсан. Нийт үнийн дүн – 80 000₮



- Шахмал эмийг ширхэглэн хайчилж, он сарыг харахааргүй хадгалж болохгүй гэсэн зааврын дагуу хуурай эмийг зөв стандартын дагуу хадгалах эмийн сав шинээр санаачлан оёсон. Нийт тоо - 10
Эмийн уут $5000 \times 10 = 50000$ ₮ Хавтас – 5100₮
Нийт үнийн дүн - 55100₮




- Хүүхдийн өлгийний уут, Нийт =125.000 төгрөг
Нэг бүрийн үнэ $5000 \times 19 = 95.000$ төгрөг
- Дуслын уут: нэг бүрийн үнэ $2000 \times 15 = 30.000$ төгрөг



- Жолооч нарын дунд болзолт уралдаан зарлаж эмнэлэг үйлчилгээнд үйлчилж буй автомашинуудын ариун цэвэр эмх цэгц, хувийн ариун цэврийн булан, тоног төхөөрөмжийн хадгалалт хамгаалалт, хувийн бэлэн байдлыг дүгнэн ажилласан.
- Эмнэлгийн эрүүл ахуй халдвар хамгааллыг сайжруулах чиглэлээр эмнэлгийн тусламж үйлчилгээнд ашиглалдагддаг хөвөн бөмбөлөг, хамрын чихээс, салфетка зэргийг ариутгалын рулон уутанд хийж ариутган хэрэглэх болсон. Өмнө нь хэрэглэж байсан цаасан уут нь ариун байх шаардлага хангадаггүй, эдийн засгийн хувьд өртөг өндөр байсан.
- Хөвөн бөмбөлөг, хамрын чихээс багтах цаасан уут 1 ширхэг нь 130 төгрөг бол рулон уутных 1 ширхэг нь 19 төгрөг 6 дахин өртөг багатай байна. Салфетка багтах цаасан уут 1 ширхэг нь 150 төгрөг бол рулон уутных 1 ширхэг нь 37.5 төгрөг 4 дахин өртөг багатай байна.

Рулон уутны эдийн засгийн тооцоо:

	Рулоны үнэ	Уутны таслах хэмжээ	Гарах уутны тоо	Уут тус бүрийн үнэ
Рулон уут $7.5\text{см} \times 200\text{м}$ /20000см/	38000 төгрөг	Хөвөн бөмбөлөг, хамрын чихээс 10 см	2000 ширхэг уут	19 төгрөг
Рулон уут $10\text{см} \times 200\text{м}$ /20000см/	50000 төгрөг	Салфетка 15 см	1333 ширхэг уут	37.5 төгрөг



4.2.7. Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлнэ

1. “Цус бүлэгнэлтэд нөлөөлөх эм” сэдвээр Айвико ХХК эмч төлөөлөгч н.Одбаяр 4 удаагийн, 1 цагийн сургалтыг 85 дуудлагын их эмч, 20 сувилагч, 9 эмийн санч нарт орж нийт 114 хүн хамрагдсан. Сургалтад хамрагдсанаар цус бүлэгнэлт гэж юу болох, яаралтай үед эмийн тунг хэрхэн тохируулах мөн шинээр Эрүүл мэндийн газрын тендерт орсон “Транлок” тарианы мэдээллийг дуудлагын их эмч, сувилагч, эмийн санч нарт өгсөн.



2. Эмийн зарцуулалтын программыг салбаруудын эмийн санд суулгаж сар бүрийн эмийн тайлан мэдээ гаргахад хялбар болж, эмийн тендерийн биелэлтийг цаг тухай бүрд нь хянаж, эмийн орлого, зарлагыг дуудлагын эмч тус бүрээр хяналт тавьж ажиллаж байна.

4.1.16. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжил боловсролоо дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажил зохион байгуулах

1. Ажилтан, ажиллагсдыг нарийн мэргэжлийн сургалтад үе шаттай хамруулан дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд төрийн зардлаар БНСУлсын DAEJEON” хотын эрүүл мэнд технологийн их сургуулийн “Сувилахуйн яаралтай тусламжийг газар дээр нь үзүүлэх, эмнэлэг хүргэх тусламж” сэдэвт сургалт семинар 2018 оны 01-р сарын 22-ноос 28-ны хооронд зохион байгуулагдсан бөгөөд тус төвөөс Г.Болормаа сувилагч амжилттай оролцлоо. Энэхүү сургалтад хамрагдсанаар сувилахуйн тусламж үйлчилгээний үеийн тусламж чанар сайжирч бэлэн байдлын талаарх мэдлэг дээшилнэ. Мөн Нийслэлийн Өргөө амаржих газартай хамтран шинэ залуу

эмч нарийг туршлага солилцох, эх барихын тусламж үйлчилгээ, гардан үйлдлийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хуваарийн дагуу жижүүрт гаргаж байна.

Ажилтан, ажиллагсдыг сургалтын хөтөлбөр боловсруулан батлуулж, тасралтгүй сургах хүрээнд 2018 онд нийт 356 ажилчдад 89 удаагийн 210 цагийн сургалт зохион байгуулахаар төлөвлөгөө гарган ажилласан.

Эмч, сувилагч нарт 82 удаа сургалт зохион байгуулсан. Үүнд:



- Хууль эрх зүй, ёс зүй, харьцаа хандлагатай холбоотой 17 цаг
- хүүхдийн эрэмбэлэн ангилалт, ХӨЦМ, нярайн тусламж үйлчилгээтэй холбоотой 15 цаг
- Осол гэмтэл, хордлого 6 цаг
- амьсгалын замын өвчин 3 цаг
- артерийн гипертензи, зүрх судасны өвчлөлтэй холбоотой 5 цаг
- эх барих эмэгтэйчүүд 2 цаг
- халдварт өвчинүүд 6 цаг
- эмнэлэг үйлчилгээ, замын хөдөлгөөний дүрэмтэй холбоотой бусад сургалтууд 154 цагийн сургалт зохион байгуулсан.

Нийт 172 эмч, сувилагч нарыг дээрх сургалтад хамруулсан. Эмч,сувилагч нарыг тус сургалтад хамруулснаар газар дээрх болон эмнэлэг хүртэлх тусламж үзүүлэх мэдлэг чадвар дээшилж, улмаар эмнэлэг үйлчилгээ, харьцаа хандлагатай холбоотой алдаа зөрчил гарахаас сэргийлж, эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай, олон улсын түвшинд үзүүлсэн.


- Захиргааны нийт 40 ажилчдад 1 цагийн албан хэрэг хөтлөлтийн сургалт , хууль эрхзүйн 17 цагийн сургалтад, ЭМЯ болон ЭМХТөв, НЭМГ 28 удаагийн сургалтад хамруулсан.

- Жолооч, техникийн алба, инженерүүдэд 12 удаагийн 154 цагийн хөдөлмөр хамгаалал, хууль эрх зүй, автомашины тоног төхөөрөмжийн аюулгүй

ажиллагаа, замын хөдөлгөөний дүрэм зохион байгуулсан. Дээрх сургалтуудыг зохион байгуулснаар жолооч нарын тоног төхөөрөмж ашиглалт, тоног төхөөрөмжийн аюулгүй, бэлэн байдал сайжирч, газар дээрх болон эмнэлэг хүртэлх багаар тусламж үзүүлэх мэдлэг чадвар дээшилсэн

2. Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх олон талт арга хэмжээ зохион байгуулах, ажилчдын ажиллах урам зоригийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд
 - 318 ажилтанд 41497200 төгрөгийн өвөл зуны хувцас олгосон
 - 107 ажилтанд 1292600 төгрөгийн хөдөлмөрийн хэрэгсэл
 - 382 ажилтныг улирал тутамд 245104000 төгрөгийн цалингийн хувиар урамшуулсан
 - 1 ажилтныг 450000 төгрөгийн дотоодын сургалтын зардлаар сургасан
 - тэргүүлэх зэрэгтэй 5 эмчид 5288600 төгрөг
 - ахлах зэрэгтэй 11 эмчид 7950700 төгрөг
 - ахлах зэрэгтэй 10 сувилагчид 5895800 төгрөг
 - 121 жолоочид мэргэшсэн жолоочийн 91324000 төгрөгийн мэргэжлийн зэргийн нэмэгдэл
 - 1 ажилтанд гадаадын сургалтын 2428000 төгрөг
 - 3 ажилтанд 240000 төгрөгийн дотоод сургалтын
 - 138 ажилтанд 437000 төгрөгийн байгууллагын сургалтад хамруулсан.

Нийгмийн асуудал шийдвэрлэсэн байдал



Байгууллагын дотоод журмын дагуу:

- 207 ахмадад 12420000 төгрөгийн хүндэтгэл үзүүлсэн
- эх үрсийн баяраар 427 хүүхдэд 7035000 төгрөг - 21 ажилтанд 5835000 төгрөгийн цалинтай чөлөө - 11 ажилтанд 13755000 төгрөгийн тэтгэмж тусламж
- тэтгэвэрт гарч байгаа 7 ахмадад 4332000 төгрөгийн тусламж
- 1 ахмадад 66000 төгрөгийн орон нутагт ирж очсон унааны зардал тус тус олгосон.

Мөн эрүүл мэндийн тухай хуулийн

- 29.6-д заасан эрүүл мэндийн ажилтныг жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд төлбөргүй хамруулах заалтын дагуу 354 ажилтныг 42480000 төгрөгийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан
- 29.7-д заасан эрүүл мэндийн ажилтанд ажилласан 5 жил тутамд нь Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон ээлжийн амралтын үндсэн болон нэмэгдэл амралт дээр нь 1 өдрийн нэмэгдэл амралт олгох заалтын дагуу 276 ажилтанд 19742000 төгрөгийн нэмэгдэл олгосон.



3. Ажилтан, ажиллагсдын ёс зүйн харьцаа хандлагыг сайжруулах, олон талт ажил зохион байгуулах ёс зүйн хэсгийн хороо нь 9 заалт бүхий төлөвлөгөө гаргасан. 2018 оны 12 сарын 03-ны байдлаар иргэдээс 346 өргөдөл гомдол бүртгэгдсэнээс 98 нь талархал, хүсэлт 109, гомдол 37, санал 3 ирсэн.

Иргэдийн нийт хандалтын 28% нь эмч ажилчдад ирсэн талархал, 60.2% нь хүсэлт, 38% нь эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой гомдол байна.

Өргөдөл гомдлыг 3 хоног 22 цаг 20 минутын хугацаанд шийдвэрлэж, хуулийн хугацаанд нь иргэдэд хариуг өгсөн.

Ажилчдаас нийт 199 өргөдөл ирсэн. Үүнээс ажлаас гарах 87 өргөдөл, ажилд орохыг хүссэн 22, эхнэр амаржсантай холбоотой 5, тэтгэмж тусламж хүссэн 9, замын зардал хүссэн 1, бусад 75 өргөдөл ирсэн.

Нийт 5 салбарт талархлын самбар байрлуулсан иргэдээс 98 талархлыг байршуулж эмч, ажилчдыг алдаршуулж улирал тус бүрийн ажил дүгнэх үзүүлэлтэд оруулсан.



3. Гадаад дотоодын ижил төст байгууллагуудтай хамтран ажиллах хүрээнд ХБНГУ-ын Эссэн хот, УБ хотын хамтын ажиллагааны дагуу 2018 оны 04 дүгээр сарын 14-өөс-21-ны хооронд 5 удаагийн 40 цагийн сургалтыг Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн эмч, сувилагч, жолооч нарт эмнэлгийн анхан шатны тусламж, эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, халдваргүйтгэл, сэдвээр зохион байгуулсан.



Гамшиг, онцгой байдлын үеийн эмнэлгийн тусламж үзүүлэх үндэсний баг бэлтгэх сургалтын хөтөлбөрийн хүрээнд Япон улсын сургагч багш нар ирж 2018.04.23-04.26 хооронд ЭМЯам дээр 3 өдрийн сургалтыг зохион байгуулагдлаа. Тус сургалтад гамшгийн үед тусламж үзүүлэх эмнэлгийн багууд хамрагдсанаас нийслэлийн түргэн тусламжийн төвөөс 4 их эмч, 4 сувилагч хамрагдлаа.



Үр дүн: Энэхүү сургалт зохион байгуулснаар Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын гамшгийн үеийн тусламж үйлчилгээ болон хариу арга хэмжээ, гамшгийн үеийн түргэн тусламж, бэлэн байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлж, тусламж, үйлчилгээний чанар, чадавх дээшилнэ. Дэвшилтэд техник технологи, мэдээ мэдээллийг суралцаж, цаашдын яаралтай тусламжийн чиглэлийн харилцаа холбоотой ажиллахаар болсон.



АНУ-ын Колорадо мужийн "Dynamic Physical Therapy" эмнэлгийн захирал сэргээн заслын их эмч Эмад Яасса Нийслэлийн Түргэн тусламжийн эмч сувилагч нарт сургалт зохион байгууллаа. Сургалтад 96 их эмч 25 сувилагч болон захиргааны ажилчид хамрагдлаа.

1.4.5. Идэвхтэй хөдөлгөөнд суурилсан олон талт арга хэмжээнүүд зохион байгуулах

- Идэвхтэй хөдөлгөөн эрүүл амьдралын төлөө цэвэр агаарт амралтаа зөв боловсон өнгөрөөх, нийтийн биеийн тамир, сонирхогчийн спортыг хөгжүүлэх зорилгоор "Цасны баяр-2018" өвлийн өдөрлөг 2018 оны 02 дугаар сарын 24-ны өдөр "Мөнгөн Улаанбаатар" оролцож Нийслэлийн "Шилдэг биеийн тамирын баг" цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулсан.



- Олон улсын эмч нарын баярын өдрийг тохиолдуулан нийт ажилчдын авьяасыг нээх, хөгжүүлэх, хамт олны идэвх, хамтын оролцоог нэмэгдүүлэх, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, хамт олны бүтээлч, эерэг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор зохион байгуулсан “Урлагийн наадам”-ийг амжилттай зохион байгуулсан.



- Байгууллагын ажилчдын дунд хөл бөмбөгийн тэмцээн амжилттай зохион байгууллаа.



- Эрүүл мэндийн байгууллагуудын дунд болсон DENKCUP тэмцээнд амжилттай оролцож шөвгийн 8-д шалгарсан.



- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, эх үрсийн баярыг тохиолдуулан байгууллагын ажилчдын хүүхдүүдэд бэлэг гардуулан өгсөн. Мөн авто баазын хашаанд хүүхдийн тоглоомын талбай засаж, хүүхдүүдийн дунд уралдаан тэмцээн зохион байгуулж шагнаж урамшуулсан.



- Мэдээлэл шуурхай удирдлагын төвөөс зохион байгуулсан цэргийн баярын нэрэмжит буудлагын тэмцээнд манай байгууллагаас нийт 5 тамирчин

оролцсоноос эрэгтэй гар буу 25 м-т 1-р байр, эмэгтэй винтовоор 50 м 1-р байр эзэлж багаараа тэргүүн байранд шалгарлаа. Мөн эмч А.Алтанзагас 3-р байранд шалгарав.



- Спортын 4 төрлөөр зохион байгуулагдсан тэмцээнд нийт 100 гаруй ажилчид оролцлоо. Сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, шатар гэсэн 4 төрлөөр зохион байгуулагдсан тэмцээнд багийн дүнгээр 3-р ээлжийн эмч нарын баг түрүүлж, дэд байранд 2-р ээлжийн эмч нарын баг орлоо.



- “УЛААНБААТАР-МАРАФОН-2018” гүйлтийн тэмцээн: Нийслэлийн Засаг даргын 2017 оны “Тэмцээн зохион байгуулах тухай” А/147 дугаар захирамж болон Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2018 оны 05 сарын 11-ны А/66 тоот тушаал, тус төвийн А/23 тоот тушаалын дагуу 4 цэгт 4 их эмч, сувилагч, тоноглогдсон автомашин 2018 оны 05 сарын 19-ны 07:00-19:00 цаг хүртэл түргэн тусламжийн үйл ажиллагаа явуулсан.



- “Гамшигт тэсвэртэй Улаанбаатар” төслийн хүрээнд тус төвд эмнэлгийн яаралтай тусламжийн үеийн техник хэрэгсэл гардуулан өглөө. Дэлхийн зөн Монгол Олон Улсын байгууллага нь НҮБ-ын Гамшигийг бууруулах Олон Улсын стратегийн байгууллагаас санаачилсан “Гамшигт тэсвэртэй Хотуудыг бий болгоё” уриан дор хот, суурин газрын гамшигийн эрсдэлийг бууруулах, түүнийг даван туулах чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэх “Гамшигийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах” үндэсний хөтөлбөрт хувь нэмэр оруулах үүднээс “Гамшигт тэсвэртэй Улаанбаатар” төслийг 2 жилийн хугацаатай хэрэгжүүлж байна.



2.4.23. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ болон төлөвлөгөөнд тодотгол хийх

1. Түргэн тусламжийн эрсдэлийн үнэлгээг шинэчлэн гарган мөрдөх хүрээнд “Гамшигт тэсвэртэй Улаанбаатар” төслийн сургагч багшаар 2 ажилтан бэлтгэн гамшгийн үеийн эрсдэлийн үнэлгээг төлөвлөсөн.

2. Таван толгой цэргийн баазад нийслэлд үүсэж болох террорист халдлагын үеийн эмнэлэг хүртэлх нууцлалын зэрэглэлтэй сургуулилтад 2 баг/ эмч, сувилаг, жолооч/ оролцсоноор газар дээр нь үзүүлэх үй олныг хамарсан ослын үеийн эрэмбэлэн ангилалт, эмнэлгийн уялдаа мэдлэг дээшилсэн.

Монгол улсын Засгийн газрын 2010 оны “Гамшгийн аюулын тухай зарлан



мэдээллийн дохио дамжуулах журам” батлах тухай 339, “Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам”, “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам” батлах тухай 340, 2017 оны “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөртэй болгох тухай” 67 дугаар тогтоолын тус тус хэрэгжилт, Нийслэлийн Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн 2018 оны төлөвлөгөөнд заасны дагуу арга хэмжээг авч, дараах ажлуудыг гүйцэтгэв.

Үүнд: 2018 оны 03 сарын 27-ны өдөр Хангарьд ордонд 10:00-17:00 цаг хүртэл тус төвийн их эмч гамшгийн үеийн эрүүл мэндийн сургагч багш Б.Батзул “Ахуйн хэрэглээний бодисын хордлого” сэдвээр 45 минутын сургалтыг явуулсан. 2018 оны 03 сарын 28-ний өдөр төв болон авто баазын 47 ажилтан, ажиллагсдад тус төвийн дэд захирал С.Ариунболд газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар 60 минутын сургалт явуулсан. Мөн эмнэлгийн анхны тусламж үзүүлэх талаар Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвийн 92 их эмч, сувилагч болон Шүдний төвийн 60 ажилтныг нийт 540 цагийн сургалтад хамруулснаар яаралтай тусламжийн удирдамжийг хэрэгжүүлэн газар дээр нь үзүүлэх ур чадвар нэмэгдсэн.

“Гамшигт тэсвэртэй Улаанбаатар” төслийн хүрээнд бэлтгэгдсэн сургалтын ажилтан Б.Тэгшжаргал Сүхбаатар дүүргийн гал унтраах 34-р ангитай хамтран 58-р сургуулийн 86 сурагчдад 30 минутын сургалтыг хамтран хийснээр өөртөө болон

бусдад үзүүлэх анхан шатны мэдлэг, дадал бий болсон. 2018 оны 03 сарын 29-ны өдрийн 1600-1605 цагийн хооронд түргэн тусламжийн үйлчилгээнд ажиллаж буй 42 тоноглогдсон автомашин дуут дохиогоо Нийслэлийн хэмжээнд тасралтгүй дуугаргасан. Мөн төв болон салбар авто баазын тухайн өдөр ажиллаж байсан 132 ажилтан, ажиллагсад аюулгүй цэгт 8 минутын дотор цугларч штабын даргад мэдэгдсэн.

Болзошгүй гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр НЭМГ-ын даргын 2018 оны 04 сарын 23-ны өдрийн А/56 дугаар тоот “Үйл ажиллагааны нэгдсэн удирдамж батлах тухай” тушаалын дагуу 2018 оны 05 сарын 01-29 хүртэл 9 дүүргийн 86 өрхийн эмнэлгийн 658 эмч, ажилчдад эмч, ажилчдад 120 цагийн гамшгаас хамгаалах хууль болон гамшгийн эрсдэлийг бууруулах ерөнхий ойлголтын талаар сургалт явуулсан. Мөн гамшгийн үеийн эрэмбэлэн ангилалт, амилуулах суурь тусламжийн талаар онол, дадлага хосолсон сургалтыг тус төвийн үндэсний сургагч 6 багш удирдан явуулсан.

Гамшгийн нэн шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл болон хээрийн эмнэлэг осол гэмтлийн үеийн чиг, сургалтын манекен гэх мэт 19 төрлийн хэрэгслийг Дэлхийн зөн ТББ болон НЭМГ-ийн дэмжлэгтэйгээр нөөцийг бүрдүүлсэн нь болзошгүй гамшгийн үеийн бэлэн байдлын хангах үндэс болсон



3. Эрүүл мэндийн яамны 2018 оны 07 сарын 03-ны 2/2729 тоот “Албан шаардлага хүргүүлэх тухай” төлөвлөгөө гарган галын аюулгүй байдлын тухай хуулийн дагуу ажилласан.
4. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2018 оны 07 сарын 20-ны 2/699 тоот “Үер усны аюулаас сэргийлэх тухай” албан бичгийн хүрээнд төлөвлөгөө гарган дуудлагын эмч, жолооч нарт шаардлагатай усны гутал, цув, автомашины татлага зэргээр ханган шаардлагатай үед мэдээлэх тогтолцоогоор ажилласан.
5. Эрүүл мэндийн яамны 2018 оны 11 сарын 19-ны 8/4636 тоот “ мэдээлэл ирүүлэх тухай” онц яаралтай аргачлалын дагуу Нийслэлийн Эрүүл мэндийн газарт өөрийн хүн хүч, эм эмнэлгийн хэрэгсэл, автомашины судалгааг нэгтгэн гаргасан.
6. 2018 оны 11 сарын 22-ны өдрийн 15,00-17,00 цагийн хооронд “дулааны цахилгаан станц-4” ТӨХК-ийн байрлалд зохион байгуулагдах команд штабын үзүүлэх сургалтад түргэн тусламжийн 2 баг/ эмч, сувилагч, жолооч/ хамрагдаж үүргээ сайн биелүүлж батламж гардан авсан.
7. Нийслэлийн Онцгой комиссын “Үүрэг хүргүүлэх тухай” 66 тоот албан бичгийн хүрээнд цаг агаарын хүндрэл,хөлдөлтийн үед үзүүлэх хүн хүч , автомашины бэлэн байдлыг ханган ажиллах төлөвлөгөө гарган ажилласан.



8. - Гамшгийн үеийн бэлэн байдлын хүрээнд жолооч нарын хувийн бэлэн байдлыг шалгах зорилгоор 2018 оны 11 дүгээр сарын 17-ний 01 цагт Гамшиг, онцгой байдлын үед яаралтай буюу оператив цагаас 40'-90 минутын дотор цугларах бэлэн байдал зарлалаа. Бэлэн байдалд 2 дугаар ээлжийн 32 жолооч 96% ирцтэйгээр 10-40 минутад бүрэн цугларалт хийлээ. Нийслэлийн Түргэн Тусламжийн төвийн автобаазын бие бүрэлдэхүүн гамшиг ослын үед бүрэн бүрэлдэхүүнээр ажиллах боломжтой.



3.3. Хот тохижилт ногоон байгууламжийн талаар

Зүлэг мод тарих бэлтгэл ажлыг хангаж хөрс, шороог өөрсдийн хүчээр бэлдэж байгууллагын тохижилтыг сайжруулах ажлын хүрээнд жимсний 65 суулгац, бутыг суулган арчлалт, хамгаалалт тал дээр анхаарч ажиллаж байна.



9.1.2. ХОЁРДУГААР БҮЛЭГ ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН

Монгол улсын Засгийн газрын тогтоол-2

- 138 “Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай”
- 258 “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай”

Нийслэлийн Засаг даргын албан даалгавар-1

- 03 “Сахилга хариуцлага, дэг журмыг сайжруулах тухай”

Нийслэлийн Засаг даргын захирамж-6

- А/95 “Нийслэлийн өмчид барилга байгууламж бүртгэн авах тухай”
- 01 “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, үүрэг гүйцэтгэх тухай”
- 02/01 “Бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай”
- А/517 “Төлөвлөгөө батлах тухай”
- А/665 “Даншиг наадам-Хүрээ Цам”-ыг зохион байгуулах тухай
- 18/03-1 “Зарим арга хэмжээг эрчимжүүлэх тухай”

Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол-1

- 90 “Журам батлах тухай”

Эрүүл мэндийн сайдын албан даалгавар-5

- 02 “Эрүүл мэндийн ажилтнуудын нийгмийн баталгааны чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээг эрчимжүүлэх тухай”
- 06 “Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх тухай”
- 03 “Теле зохиомж байршуулах тухай”
- 04 “Осол гэмтлээс сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай”
- 05 “Нярай болон бага насны хүүхдийн эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах тухай”

Эрүүл мэндийн сайдын тушаал- 2

- А/224 “Хуваарь батлах тухай”
- А/334 “Эмнэлгийн мэргэжилтнүүдийг гепатитийн В вирусийн эсрэг дархлаажуулах тухай”

Эрүүл мэндийн яамны төрийн нарийн бичгийн даргын тушаал-2

- А/83 “Ажлын хэсэг байгуулах тухай”
- 2/2729 “Гамшгаас хамгаалах ба галын аюулгүй байдлын талаар хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг арилгах тухай”

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын тушаал-27

- А/02 “Өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг дэмжих жил болгох тухай”
- А/06 “Аян зохион байгуулах тухай”
- А/16 “Эмнэлгийн тусламж үйлчилгээг зохицуулах тухай”
- А/24 “Харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга нарын 2017 оны үр дүнгийн гэрээ болон түншлэлийн гэрээг дүгнэсэн тухай”
- А/25 “Харьяа эрүүл мэндийн байгууллагын 2017 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлсэн тухай”
- А/27 “Уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах тухай”
- А/35 “Хээрийн дадлага, сургуульд оролцох тухай”
- А/42 “Хачгаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай”
- А/49 “Харшлаас урьдчилан сэргийлэх, хөрс хамгаалах” аян зохион байгуулах тухай
- А/50 “Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлье” болзолт уралдаан зохион байгуулах тухай
- А/56 “Үйл ажиллагааны нэгдсэн удирдамж батлах тухай”
- А/57 “Олон улсын сувилагчийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай”
- А/59 “Амралтын хуваарь батлах тухай”
- А/66 “Тусламж үйлчилгээ үзүүлэх тухай”
- А/71 “Хяналт-шинжилгээ үнэлгээний журам шинэчлэн батлах тухай”
- А/83 “Гарын эрүүл ахуй, орчны бохидолтой холбоотой халдварт өвчнөөс сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай”
- А/89 “Урамшуулал олгох, хариуцлага тооцох тухай”
- А/96 “Эмнэлгийн тусламж үйлчилгээг зохицуулах тухай”
- А/99 “Харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга нарын 2018 оны эхний хагас жилийн үр дүнгийн гэрээг дүгнэсэн тухай”
- А/100 “Түр зохицуулалт хийх тухай”

- A/119 “Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн тандалт сэдэвт сургалт зохион байгуулах тухай”
- A/131 “Сайн туршлага 2018 арга хэмжээ зохион байгуулах тухай”
- A/141 “Сургалт зохион байгуулах тухай”
- A/156 “Эмнэлгийн тусламж үйлчилгээг зохицуулах тухай”
- A/158 “Тайлан хүлээн авах тухай”
- A/143 “GPS төхөөрөмж хүлээн авах комисс томилох тухай”
- A/170 “Нийслэлийн хүн амд үзүүлэх мэс заслын тусламж үйлчилгээг зохион байгуулах тухай”

Онцгой байдлын Ерөнхий газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу ажлын 16 зүйл бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэн ажиллаж хэрэгжилт 75%-тай байна. Нийт 17 нэр төрлийн 650,0 төгрөгийн тохижилт зохион байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэв.

д/д	БҮЛЭГ	ДЭД БҮЛЭГ		ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ	
1.	Галын эрсдэл	1.2.2	Галын эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө биелэлт	0	0
		1.2.3	Санхүүгийн удирдлагын төлөвлөгөө биелэлт	20%	1
II	Байгууллагын галын гамшгийн урьдчилан сэргийлэх бэлэн байдал үйл ажиллагаа	2,1	Галын гамшгийн эрсдэлийг тодорхойлох үнэлэх	0%	0
		2,2	Галаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах	20%	1
		2,3	Гамшгийн удирдлага штаб мэргэжлийн ангийн бэлэн бэлтгэл байдал	80%	4
		2,4	Гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилт	30%	1,5
			Ажилтнуудын сургалт бэлтгэл	20%	1
III	Байгууллагын галын гамшгийн эрсдэлийн санхүүжилт сэргээн босголтын нөөц	3.5.1	Байгууллагын галын гамшгийн эрсдэлийг бууруулах санхүүжилт	40%	2
		3.5.2	Сэргээн босголтын нөөц	40%	.2
IV	Байгууллагын дэд бүтэц, техник, технологийн чадавх	4	Инженерийн шугам сүлжээ	60%	3
		4	Мэдээлэл хамгааллын систем	80%	4

Галын эрсдэлийн үнэлгээ 40,3% гэж гарсан. Үүний дагуу төлөвлөгөө гаргаж ажиллаж 75%-тай байна.

Нийт эмч эмнэлгийн ажилчдын дунд гепатитын судалгаа явуулж үүнээс шинээр ажилд орсон 17 эмч, эмнэлгийн мэргэжилтэн болон өмнөх оны дархлаажуулалтад хамрагдаагүй 23 эмч эмнэлгийн мэргэжилтнийг дархлаажуулалтад хамрагдахаар вакцины судалгааг Нийслэлийн эрүүл мэндийн

газар хүргүүлсэн. Мөн дагалдан эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарт гепатитын шинжилгээнд хамрагдах болон вакцинд бүрэн хамрагдсан байдалд хяналт тавьж ажиллаж байна.

9.1.3.ГУРАВДУГААР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

а/ Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилттэй холбоотой:

- 1.Засгийн газрын 150 дугаар тогтоолын дагуу улирал тутам нийгмийн асуудлыг шийдвэрлэх уралдаан тэмцээн спорт, бусад аян араг хэмжээ, нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал, ахмад өндөр настанд үзүүлсэн хүндэтгэлийн зардал, ажилчдын үр дүнгийн урамшууллын зардал

Үүнд:

- 318 ажилтанд 41497200 төгрөгийн өвөл зуны хувцас олгосон
- 107 ажилтанд 1292600 төгрөгийн хөдөлмөрийн хэрэгсэл
- 382 ажилтныг улирал тутамд 245104000 төгрөгийн цалингийн хувиар урамшуулсан
- 1 ажилтныг 450000 төгрөгийн дотоодын сургалтын зардлаар сургасан
- тэргүүлэх зэрэгтэй 5 эмчид 5288600 төгрөг
- ахлах зэрэгтэй 11 эмчид 7950700 төгрөг
- ахлах зэрэгтэй 10 сувилагчид 5895800 төгрөг
- 121 жолоочид мэргэшсэн жолоочийн 91324000 төгрөгийн мэргэжлийн зэргийн нэмэгдэл
- 1 ажилтанд гадаадын сургалтын 2428000 төгрөг
- 3 ажилтанд 240000 төгрөгийн дотоод сургалтын
- 138 ажилтанд 437000 төгрөгийн байгууллагын сургалтад хамруулсан.

Байгууллагын дотоод журмын дагуу:

- 207 ахмадад 12420000 төгрөгийн хүндэтгэл үзүүлсэн
- эх үрсийн баяраар 427 хүүхдэд 7035000 төгрөг - 21 ажилтанд 5835000 төгрөгийн цалинтай чөлөө - 11 ажилтанд 13755000 төгрөгийн тэтгэмж тусламж
- тэтгэвэрт гарч байгаа 7 ахмадад 4332000 төгрөгийн тусламж
- 1 ахмадад 66000 төгрөгийн орон нутагт ирж очсон унааны зардал тус тус олгосон.

Мөн эрүүл мэндийн тухай хуулийн


- 29.6-д заасан Эрүүл мэндийн ажилтныг жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд төлбөргүй хамруулах заалтын дагуу 354 ажилтныг 42480000 төгрөгийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан

- 29.7-д заасан Эрүүл мэндийн ажилтанд ажилласан 5 жил тутамд нь Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон ээлжийн амралтын үндсэн болон нэмэгдэл амралт дээр нь 1 өдрийн нэмэгдэл амралт олгох заалтын дагуу 276 ажилтанд 19742000 төгрөгийн нэмэгдэл олгосон. 2 Эмч, эмнэлгийн ажиллагсдын сэтгэл ханамжийн судалгаанд сувилагч 21, эмч 145, жолооч 76, бусад ажилчид 59, нийт 301 хүн буюу нийт ажилчдын 75.6% хамрагдсан. Дэмжлэгт удирдлага, хүний нөөцийн хөгжих боломж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл, байгууллагын соёл, тусламж үйлчилгээний чанар, ажлын аюулгүй байдал, дэмжлэгт орчин гэсэн 6 бүлэг 62 асуултаар судалгаа авсан. Судалгаанд оролцогсдын 65.0% нь байгууллагаараа бахархдаг, ерөнхий сэтгэл ханамж 79% гэсэн эерэг үнэлгээг өгсөн байна. Ажилчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын ажилчдын дунд урлагийн наадам, спортын 4 төрөлтийн тэмцээн, эмч нарын баяр, сувилагч нарын баярын өдрүүдийг тэмдэглэсэн. Эмч, сувилагч нарын баяраар 45 эмч, 17 сувилагчийн ажлын үнэлж урамшуулал, НЭМГ,

ЭМЯ-ны жуух, тэргүүн, өргөмжлөл болон бусад байгууллагуудын мөнгөн шагнал зэргээр урамшуулсан. Үүний үр дүнд эмнэлгийн ажилчдын ажиллах идэвх, урам зориг дээшилсэн. Эмч ажилчдын өдрийн хоолны меню болон хоолны амт чанар сайжирсан, мөн авто баазын ажилчдын хувцас угаах угаалгын газар, авто машин угаах газруудыг тохижуулсан зэрэг нь ажиллах сэтгэл ханамжийг нэмэгдүүлсэн.

3. 2018 онд нийт 306478 дуудлага хүлээн авч үйлчилсэн нь өнгөрсөн оныхоос 5387 дуудлагаар өсөж иргэдэд хүрч үйлчлэх яаралтай тусламжийг хүргэсэн байна. Төв, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул салбараар үйлчлүүлж буй 120 үйлчлүүлэгчдээс байгууллагын соёл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, тэгш байдал, ашиг сонирхол гэсэн 4 бүлэг 22 асуултаар судалгаа авсан. Судалгаанд оролцогсдын 63% нь 28-50 насны үйлчлүүлэгчид, 58.9% нь манай байгууллагаар 2 түүнээс дээш удаа үйлчлүүлсэн байна. Байгууллагын соёл, үйл ажиллагааны талаарх иргэдийн бодол 69.2% сайн гэж судалгаанд оролцсон үйлчлүүлэгч үнэлсэн байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 24%-р дээшилсэн үзүүлэлттэй байна. Мөн Facebook-ээр мэдээ мэдээлэл байршуулан сурталчилж байна. Facebook-т сүүлийн үед их хандалттай байгаа Mr.Do пэйжийн админтай хамтарч “Түргэн тусламжийн автомашинд зам тавьж өгцгөө” сэдэвт видео шторк хийсэн нь маш олон хүний хандалт авсан.

Байгууллагын ерөнхий сэтгэл ханамж сайн 79.2% сайн гэсэн үнэлгээтэй үнэлэгдсэн байна. Өмнөх онтой харьцуулахад 25%-аар өссөн үзүүлэлттэй байгаа нь иргэдийн сэтгэл ханамж сайн байгааг харуулж байна.



4. Нийт жолооч нарын дунд амилуулах тусламж, автомашины ариутгал халдваргүйтгэл, автомашины тоног төхөөрөмжийн ашиглалт хадгалалт хамгаалал, хаяг болон замын хөдөлгөөний дүрмийн сургалт, ёс зүй, харьцаа хандлагын сургалтыг системчлэн байнга явуулж байна. 2018 онд 7 удаагийн нийт 154 цагийн сургалт зохион байгуулж үр дүнг дүгнэн ажилласан.

5. Түргэн тусламжийн байнгын бэлэн байдлыг хангах, ариутгал халдваргүйтгэлийн журмын дагуу авто баазын засварын цехэд автомашины ариутгал, халдваргүйтгэлийн цэг байгуулж автомашины ариутгалыг өдөр тутамд хийж хэвшсэн.

6. Mongolian Emergency Service Hospital Hygiene Project (MeshHp) төслийн хүрээнд 2018 оны 04 дүгээр сарын 14-өөс 21-ны өдрүүдэд ХБНГУ-ын Эссен хотын их сургуулийн эмнэлгийн доктор Валтер Попп, гал унтраах ангийн сургагч багш Jorg Spors, Volker, Nina Parohl нар уригдан ирж хамгийн сүүлийн үеийн

технологуудыг танилцуулж, эмнэлгийн эрүүл ахуй, халдваргүйтгэлийн стандартыг сайжруулах талаар зөвлөгөө өгч 5 хоногийн сургалт зохион байгууллаа. Тус сургалтаар эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ, халдваргүйтгэл ариутгал сэдвээр 5 хоногийн сургалт, практикт суурилсан дадлага ажлыг зохион байгуулж туршлага солилцов. Германы мэргэжилтэн автомашины ариутгал халдваргүйтгэл хийх 2 хувингийн аргачлалаар сургалт болон хэрхэн хийж хэвшсэн эсэхэд хяналт хийж хамтарч ажилсан. Маш сайн байна гэж үнэлсэн.

7. Шинэ болон сэргэж буй халдварт өвчин, менингококкцеми, хачгаар дамжих халдварт өвчин, тоосны шалтгаант харшлын өвчин сэдвээр мэргэжлийн эмч мэргэжилтнүүдийг урин лекц-д нийт давхардсан тоогоор 500 гаруй эмч эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Мөн Баянхонгор аймгийн 5 эмч эмнэлгийн мэргэжилтэн болон шинээр ажилд орж байгаа 8 эмчид халдвар хамгааллын дэглэм, хууль тогтоомжийн тухай сургалтыг зохион байгуулсан. 30 жолооч нарт автомашин ариутгах 2 хувингийн аргаар сургалт зохион байгуулсан.

9. Шилэн дансанд байршуулбал зохих тайлан, мэдээ, файлуудыг дараах байдлаар мэдээлсэн:

- Өмнөх оны бүтэн жилээр 6 тайлан, мэдээлэл оруулахаас 2-г PDF файл хэлбэрээр, 4-г зохих маягтаар

- Тухайн жилийн бүтэн жилээр 3 тайлан, мэдээллээс зохих маягтаар

- Улирлаар өмнөх оны 1, тухайн оны 1 мэдээллийг зохих маягтаар-2

- Сараар байршуулах 3 мэдээллийг өмнөх оны 3 удаа, тухайн оны 15 удаа мэдээллийг зохих маягтаар

- Тухай бүр тайлагнах 8 маягтаар өмнөх оны 8, тухайн оны 40 удаа мэдээллийг холбогдох тушаал, шийдвэр, байгуулсан гэрээ материалыг PDF хэлбэрээр хавсарган нийт 21 мэдээллийг 77 удаа толилуулсан.

10. Сар бүрийн батлагдсан төсвийн хуваарийн дагуу байгууллагын ажиллах хэвийн нөхцөлийг бүрдүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг зардлын бүлэг, зүйл ангийн зориулалтын дагуу зарцуулж сар бүрийн эхний ажлын өдөрт багтаан төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр авлагын 2 төрлийн мэдээ тайланг өмнөх оны 1, тухайн оны 5 сар дуустал хугацаанд нь тайлагнасан.

11. УСНББОУС-ын дагуу НББ-ийг хөтлөн санхүүгийн бүртгэл, тооцоог санхүүгийн тооцоолох программ хангамжид тасралтгүй бүртгэн явуулж байна.

12. Худалдан авах ажиллагааны газартай хамтран ажиллаж www.tender.gov.mn сайтаар цахим хэлбэрээр 2 бараа, ажил үйлчилгээ явуулахаар ерөнхий төлөвлөгөөг батлуулан 100 хувь хялбаршуулсан цахимаар нээлттэй тендер шалгаруулалтыг зохион явуулж "Харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх" тендерийн нээлтийг амжилттай зохион байгуулсан. Уг тендер үнэлэх хянах явцдаа явагдаж байна.

13. Эрүүл мэндийн хөгжлийн төв болон Нийслэлийн Эрүүл мэндийн газарт төрийн сангаар яаралтай тусламжийн чиглэлээр суралцах 2 сувилагчийг бүртгүүлсэн. Сувилахуйн ахлах зэрэг хамгаалах шалгалтад 2 сувилагч бэлтгэж байна. Эрүүл мэнд, яаралтай тусламжийн чанар сайжруулах чиглэлээр 1 сувилагч БНСУ-ын Deajoen хотын Эрүүл мэндийн их сургуульд мэргэжил дээшлүүлэх сургалтад амжилттай хамрагдаад ирсэн. Нээлтийг амжилттай зохион байгуулсан. Уг тендер үнэлэх хянах явцдаа явагдаж байна.

14. Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн жолооч нарын дундах ажлын байрны стрессийг илрүүлэх зорилготой судалгаа хийсэн.

Нийт 120 жолооч нарын дунд судалгаа явуулж дараах дүгнэлтийг гаргаж байна: Судалгаанд хамрагдсан жолооч нарын 80 гаруй хувь нь ажлын байрны стресст өртдөг тоон үзүүлэлт гарсан байна.

15. 2018 оны 2 дугаар сарын 05-06-ний өдрүүдэд НҮБ-ын Хүүхдийн сан, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын "ХӨЦМ"-ийн хэрэгжилтийн хүрээнд Эх хүүхдийн эрүүл мэндийн төв, Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төвийн хамтран зохион байгуулсан олон нийтэд түшиглэсэн ХӨЦМ-ийн сургагч багшийн сургалтад 2 их эмч, 1 сувилагч нийт 3 хүн хамрагдсан.

б/ Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын жилийн төлөвлөгөөнд тусган ажилласан.


Ажилтан, ажиллагсдыг сургалтын хөтөлбөр боловсруулан батлуулж, тасралтгүй сургах хүрээнд 2018 онд нийт 356 ажилчдад 89 удаагийн 210 цагийн сургалт зохион байгуулахаар төлөвлөгөө гарган ажилласан.

1. Эмч, сувилагч нарт 82 удаа сургалт зохион байгуулсан. Үүнд:
2. - Хууль эрх зүй, ёс зүй, харьцаа хандлагатай холбоотой 17 цаг
3. - хүүхдийн эрэмбэлэн ангилалт, ХӨЦМ, нярайн тусламж үйлчилгээтэй холбоотой 15 цаг
4. - Осол гэмтэл, хордлого 6 цаг
5. - амьсгалын замын өвчин 3 цаг
6. - артерийн гипертензи, зүрх судасны өвчлөлтэй холбоотой 5 цаг
7. - эх барих эмэгтэйчүүд 2 цаг
8. - халдварт өвчнүүд 6 цаг
9. - эмнэлэг үйлчилгээ, замын хөдөлгөөний дүрэмтэй холбоотой бусад сургалтууд 154 цагийн сургалт зохион байгуулсан.
10. Нийт 172 эмч, сувилагч нарыг дээрх сургалтад хамруулсан. Эмч,сувилагч нарыг тус сургалтад хамруулснаар газар дээрх болон эмнэлэг хүртэлх тусламж үзүүлэх мэдлэг чадвар дээшилж, улмаар эмнэлэг үйлчилгээ, харьцаа хандлагатай холбоотой алдаа зөрчил гарахаас сэргийлж, эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай, олон улсын түвшинд үзүүлсэн.
11. - Захиргааны нийт 40 ажилчдад 1 цагийн албан хэрэг хөтлөлтийн сургалт , хууль эрхзүйн 17 цагийн сургалтад, ЭМЯ болон ЭМХТөв, НЭМГ 28 удаагийн сургалтад хамруулсан.
12. - Жолооч, техникийн алба, инженерүүдэд 12 удаагийн 154 цагийн хөдөлмөр хамгаалал, хууль эрх зүй, автомашины тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, замын хөдөлгөөний дүрэм зохион байгуулсан. Дээрх сургалтуудыг зохион байгуулснаар жолооч нарын тоног төхөөрөмж ашиглалт, тоног төхөөрөмжийн аюулгүй, бэлэн байдал сайжирч, газар дээрх болон эмнэлэг хүртэлх багаар тусламж үзүүлэх мэдлэг чадвар дээшилсэн

12.1. Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх

а/ Шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо-261. Засгийн газрын 150 дугаар тогтоолын дагуу 64,603,700 мянган төгрөгийн цалингаар 235 ажилтныг

урамшуулсан. Мөн 26 ажилтан доор дурдсан шагналуудыг тус тус авсан. Шагналын дагалдах мөнгөн дүн нийт 1.640.000 төгрөг.



б/ Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв харгалзан нийт 355.563.100 төгрөгийн цалин урамшуулал олгосноос ур чадварын нэмэгдэл 382 ажилтанд, зэргийн нэмэгдэл 26 эмч сувилагч, мэргэшсэн 121 жолоочид олгосон.

б/ Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх- 405 ажилтанд өдөрт 2 удаа нэг, хоёр дугаар хоол өгдөг. Унааны мөнгө ажилдаа ирж буцах 1000 төгрөг олгодог ба 2018 онд 331.933.000 төгрөг зарцуулсан.

г/ 2018 оны 12 сарын 03-ны 2018 оны 12 сарын 03-ны байдлаар иргэдээс 346 өргөдөл гомдол бүртгэгдсэнээс 98 нь талархал, хүсэлт 109, гомдол 37, санал 3 ирсэн.

Иргэдийн нийт хандалтын 28% нь эмч ажилчдад ирсэн талархал, 60.2% нь хүсэлт, 38% нь эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой гомдол байна.

Өргөдөл гомдлыг 3 хоног 22 цаг 20 минутын хугацаанд шийдвэрлэж, хуулийн хугацаанд нь иргэдэд хариуг өгсөн.

Ажилчдаас нийт 199 өргөдөл ирсэн. Үүнээс ажлаас гарах 87 өргөдөл, ажилд орохыг хүссэн 22, эхнэр амаржсантай холбоотой 5, тэтгэмж тусламж хүссэн 9, замын зардал хүссэн 1, бусад 75 өргөдөл ирсэн.

Нийт 5 салбарт талархлын самбар байрлуулсан иргэдээс 98 талархлыг байршуулж эмч, ажилчдыг алдаршуулж улирал тус бүрийн ажил дүгнэх үзүүлэлтэд оруулсан.



2018 оны 3-р сарын 28-ны өдөр үйлдвэрчний эвлэлийн хорооноос зохион байгуулсан бүх ажилтны урлагийн наадам зохион байгуулсан ба хамт олонч уур амьсгалыг бүрдүүлэн авьяас чадварыг нээх алхам болсон.

д/ Нийслэлийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 24 өдрийн А/335 дугаар захирамж “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 9.1.3-ын д/ бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа, 9.1.4-ын а/ байгууллагын ил тод байдлыг үнэлэх ажлуудыг хийж гүйцэтгэсэн.


“Элэг бүтэн монгол” хөтөлбөрийн хүрээнд:

Вируст гепатит өвчин, түүний халдварлах замын тухай мэдээллийг www.103.ub.gov.mn сайтад байршуулж ард иргэдэд зөвлөмж мэдээллийг хүргэж байна.

Дэлхийн гар угаах өдөр буюу 5 дугаар сарын 05-ний өдрийг тэмдэглэхтэй холбогдуулан 05,06,07 өдрүүдэд салбар, төвийн нийт 170 эмч, эмнэлгийн мэргэжилтэн өдөрлөгт оролцож гар угаах заавар зөвлөмжийн дагуу гардан үйлдлүүдийг хийж гүйцэтгэсэн.



Нийт эмч эмнэлгийн ажилчдын дунд гепатитын судалгаа явуулж үүнээс шинээр ажилд орсон 17 эмч, эмнэлгийн мэргэжилтэн болон өмнөх оны дархлаажуулалтад хамрагдаагүй 23 эмч эмнэлгийн мэргэжилтнийг дархлаажуулалтад хамрагдахаар вакцины судалгааг Нийслэлийн Эрүүл мэндийн газар хүргүүлсэн. Мөн дагалдан эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарт гепатитын шинжилгээнд хамрагдах болон вакцинд бүрэн хамрагдсан байдалд хяналт тавьж ажиллаж байна.



Шинээр ажилд орсон болон өмнөх оны вакцинд хамрагдаагүй 60 эмч эмнэлгийн мэргэжилтнийг В гепатитын эхний болон хоёр дах тунд 100% хамруулж дархлаажуулалтын тайлан мэдээг Нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлсэн. Ирэх оны 04 сард гурав дахь тунд хамруулна.

- “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах”- үндэсний хөтөлбөрийн хүрээнд:

Халдварт өвчнийг тандах, сэргийлэх, дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээг уян хатан, чанартай, хүртээмжтэй, шуурхай зохион байгуулах чадавхыг бэхжүүлэхэд бусад салбарын оролцоог нэмэгдүүлэх, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүгийн тогтвортой байдлыг хангах замаар халдварт өвчний тархалтыг бууруулахад оршино.

Халдварт өвчинтэй холбоотой эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор 2018 он гарснаас хойш халдварт өвчний сэдвээр 6 сургалтыг холбогдох байгууллага болон мэргэжилтэнтэй хамтарч хийсэн.

Үүнд:

- 01 сарын 24-ний өдөр “Томуу томуу төст өвчин” сэдвээр хүүхдийн мэргэжилтэн 3.Энхцэцэг

- 02 сарын 14-ний өдөр “Цусан суулга” сэдвээр ХӨСҮТөвийн их эмч А.Бурмаа
- 02 сарын 14-ний өдөр “Менингококкцеми” сэдвээр ХӨСҮТөвийн их эмч Н.Даваахүү
- 03 сарын 21-ний өдөр “Салхин цэцэг, гар хөл амны өвчний ялган оношилгоо” сэдвээр ХӨСҮТөвийн их эмч Н.Ганцэцэг
- 04 сарын 26-ний өдөр “Хачгаар дамжих халдварт өвчин” сэдвээр ХӨСҮТөвийн их эмч Б.Оюунбилэг
- 5 сарын 24-ний өдөр “Тоосны шалтгаант харшлын тухай” тус тус сургалт хийсэн.

Нийт давтагдсан тоогоор 573 эмч, эмнэлгийн мэргэжилтэн сургалтад /лекц/ хамрагдсан. Уг сургалтад хамрагдсанаар эмч нарын мэдлэг чадвар дээшилсэн. Мөн халдварт өвчнөөс сэргийлэх зөвлөмжийг өвчлөл бүрээр тогтмол www.103.ub.gov.mn сайтдаа байршуулж, Нийслэлийн Эрүүл Мэндийн газраас гаргасан хачгийн тухай 400 боршур, тоосны харшлаас сэргийлэх 215 боршур болон өөрсдийн бэлтгэсэн халдварт өвчнөөс сэргийлэх зурагт хуудаснуудыг тарааж хүн амд халдварт өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх тухай мэдлэг мэдээлэл хүргэсэн. Энэ үйл ажиллагааны үр дүнд ард иргэд урьдчилан сэргийлэх арга замуудыг мэддэг болсон.



Шинээр ажилд орсон эмч, эмнэлгийн мэргэжилтэнд эрүүл мэндийн байгууллагын эрүүл ахуй халдвар хяналт сэргийлэлттэй холбоотой сургалтыг 5 дугаар сарын 28-5 эмчид, жолооч нарт түргэн тусламжийн автомашиныг ариутгах, халдваргүйтгэх 2 хувингийн аргачлалыг 1 сарын 30-ний өдөр 29 жолоочид, 3 сарын 2-ний өдөр 7 жолоочид сургалтад хамруулсан. Шинэ эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарыг тухай бүрд сургалтуудад хамруулснаар мэдлэг чадвартай мэргэжилтэн, ажилтан бэлтгэгдэнэ.



Нэгдсэн ариутгалын хэсэгт монгол улсад ашиглаж болох ариутгал, халдваргүйтгэлийн жагсаалтад орсон ECOLAB компанийн герман улсад үйлдвэрлэгдсэн бодисыг MedClean компанитай гэрээний дагуу авч ашиглаж байна.

Эрүүл мэндийн сайдын 187 тоот тушаалын дагуу автоклавын ариутгал халдваргүйтгэлд тогтмол химийн, биологийн, физикийн хяналтыг Bowie dick, биологийн индикатор, туузан индикаторуудыг ашиглан хийж байна. Хяналтын дүнд ариутгал, халдваргүйтгэлийн процесс хэвийн явагдаж байна.

Хан-Уул салбарт 15 м² талбайтай өндөр нь 2.5 метртэй эмнэлгийн хог хаягдал хадгалах шинээр барьж дуусах шатандаа орсон. Эмнэлгийн тусгай хог хаягдлын менежмент сайжирсан.



Эмнэлгээс шалтгаалах халдвар болон бусад халдварт өвчнийг бууруулах чиглэлээр цус цэвэрлэх цомгийг 69 дуудлагын автомашинд байрлуулсан. Тус цомгийн нэг бүрийн үнэ нь 19000 төг нийт 1,311,000 төгрөг зарцуулагдсан. Энэ ажлын хүрээнд цус цэвэрлэх явцад халдвар тарах болон авах эрсдэл буурна.



Бүх нийтийн их цэвэрлэгээг 2018 онд жилд 4 удаа хийсэн. 2018 оны 2 сарын 10,11,12-д гурван өдөр тус бүр 2 цаг “Сар шинийн бүх нийтийн их цэвэрлэгээ”-г зохион байгуулж гадна болон дотор талбайд цэвэрлэгээ хийсэн. 4 сарын 21- ний өдөр "Их хотын цэвэрлэгээ 90 минут" их цэвэрлэгээг 90 минутын турш гадна талбайн цэвэрлэгээ, хашаа хашлага угаах, гадна цонх, довжоо зэргийг угаах ажлуудыг хийсэн. Уг хоёр удаагийн их цэвэрлэгээнд төв болон салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, албан хаагчид давтагдсан тоогоор 915 хүн оролцсон. Нийт 1015 м² талбайг цэвэрлэж 41 м³ хогийг хот тохижилтын компанид ачуулж хамтран ажилласнаар хоггүй цэвэр орчныг бүрдүүлсэн.



Тарваган тахал өвчнөөс сэргийлэх мэдээлэл сурталчилгааг байгууллагын www.103.ub.gov.mn сайтад тавьж байршуулсан. Салбар бүр дээр тарваган тахал өвчнөөс сэрэмжлүүлэх 14 зурагт хуудас 45 ширхэг боршур материалыг тарааж байрлуулсан.

Эмнэлгийн нийт эмч, сувилагч, жолооч, үйлчилгээний ажилчдын дунд “Эмнэлгийн дотоод халдвараас урьдчилан сэргийлэх, гар угаах, халдваргүйжүүлэх, халдварын сэргийлэлтийн чанарыг сайжруулах аяныг 2017 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны хооронд зохион байгуулсан. Нийт 314 эмч, эмнэлгийн ажилчид оролцсон.

Аяныг зохион байгуулснаар гарын эрүүл ахуйн халдваргүйтгэл, гар угаах дадал хэвшил болж, халдвар хяналтын дэглэм сайжирсан тустай ажил болсон.

Ололттой тал:“Нэгдсэн ариутгалын хэсэг” Хан-Уул салбарт байгуулж үйл ажиллагаа жигдрэн ажиллаж байна. Ариутгалд орчин үеийн технологи туршлага нэвтрүүлэх, хяналтыг тогтмолжуулах /биологийн индикатор улиралд 1, bowie dick сард 1, хяналтын индикатор өдөр бүр/ үүднээс дээрх хяналтуудыг заасан хугацаанд нь тогтмол хийн ажиллаж байна. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын төв лабораторитой гэрээ байгуулан улирал бүр дотоод орчны шинжилгээнд хамруулж ажиллаж байна. Үр дүнд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар гаргаагүй ажиллаж байна.

9.1.5. ТАВДУГААР БҮЛЭГ - БУСАД МЭДЭЭЛЭЛ:

а/ Амилуулах суурь тусламжийн сургалтын талаар:

2018 оны сургалтын албаны эхний хагас жилийн тайланг дараах ажлуудыг зохион байгуулсан.

Амилуулах суурь тусламж болон гэмтлийн анхан шатны сургалтыг дотоодын сургалтад нийслэлийн түргэн тусламжийн төвийн дуудлагын их эмч, дагалдан эмч, сувилагч болон жолооч, дагалдаг жолооч нарт үе шаттай зохион байгуулсан.

Гадаад сургалтад дээрх сэдвийн хүрээнд Нийслэлийн эрүүл мэндийн харьяа газрын байгууллагууд Өргөө амаржих, Хүрээ амаржих, Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төв, Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн төв, Шүд эрүү нүүрний төвийн эмч, сувилагч нарт сургалтыг давтан зохион байгуулсан.

2018 оныг өрхийн эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд дүүргүүдийн өрхийн эмч, сувилагч нарт сургалт үе шаттай явуулсан.

Төрийн болон төрийн бус байгууллагуудад анхны тусламж сэдвээр сургалтуудыг явуулсан.

Үүнд: Эрүүл мэндийн хөгжлийн төв, Нийслэлийн замын цагдаагийн зохицуулагч нарт, эрүүл мэндийн хүрээлэнтэй хамтран орон нутгийн болон дүүргийн нийт 36 эмч нарыг Амилуулах суурь тусламжийн сургагч багшаар 4 өдрийн 32 цагийн сургалтыг зохион байгуулсан.


Дотоодын сургалтыг тус төвд шинээр орж буй дагалдан эмч нарын сургалтыг дээрх сэдвийн хүрээнд явуулсан.

2018 оны 01 сарын 10 -аас дагалдан их эмч нарт Амилуулах суурь болон лавшруулсан тусламж, эмнэлэг хүртэлх гэмтлийн лавшруулсан тусламж болон шархны анхдагч цэгцлэлт сэдвээр онол болон дадлага хослуулсан сургалт орсон. 2017 онд нийт 62 дагалдан эмч нарыг дээрх сургалтад хамруулж 20 удаагийн 168 цагийн сургалтыг явуулсан ба сургалт өмнөх сорил 53% байсан сургалтын дараах сорил тест 78% ахиц 35% байсан. 2018 онд дагалдан нийт 40 эмч нарт 15 удаагийн 120 цагийн сургалтыг зохиож үр дүнг удирдлагуудад танилцуулсан. Сургалтыг өмнөх сорил тест 46% байсан бол сургалтын дараах сорилын тест 75%-тай болж 29%-ийн ахиц гарсан.

2018 онд давхардсан тоогоор 82 эмч, сувилагч нарыг амилуулах болон лавшруулсан суурь тусламжийн сургалтад хамруулсан.

Хичээлийн агуулга:

- Гэмтлийн суурь тусламжийн ангилал ерөнхий ойлголт
- Эрэмбэлэн ангилах зарчим
- Хавсарсан хүнд гэмтлийн үнэлгээ
- Зөөлөн эдийн гэмтэл шархны үнэлгээ Gustilla Anderson ангилал
- Шарх, шархны тухай ерөнхий ойлголт
- Шарханд анхдагч цэгцлэлт хийх
- Амилуулах суурь тусламж
- Амилуулах лавшруулсан тусламж
- Нярайн сэхээн амьдруулах тусламж
- Эмнэлгийн аюултай хог хаягдал
- Гар халдваржуулах дадал



Халдвар судлаачтай хамтран шинээр ажилд орсон эмч, эмнэлгийн мэргэжилтэнд эрүүл мэндийн байгууллагын эрүүл ахуй халдвар хяналт сэргийлэлттэй холбоотой сургалтыг 5 дугаар сарын 28-нд 5 эмч, жолооч нарт түргэн тусламжийн автомашиныг ариутгах, халдваргүйтгэх 2 хувингийн аргачлалыг 1 сарын 30-ний өдөр 29 жолоочид, 3 сарын 2-ний өдөр 7 жолоочид сургалтад хамруулсан. Шинэ эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарыг тухай бүрд сургалтуудад хамруулснаар мэдлэг чадвартай мэргэжилтэн, ажилтан бэлтгэгдэнэ.

Сургалт алба болон тоног төхөөрөмжийн инженер, халдвар судлаачтай хамтран дараах сэдвээр онолын шалгалт авсан. Нийт 85 жолоочид автомашинд суурилагдсан эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын сургалт явуулсан.


- Амилуулах тусламж
- Автомашины ариутгал халдваргүйтгэл
- Автомашины тоног төхөөрөмжийн ашиглалт




НИЙСЛЭЛИЙН ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТАРСАН СУРГАЛТУУД

2018 оны 02 сарын 07-нд Гачуурт тосгоны эрүүл мэндийн төв болон Нийслэлийн Эрүүл мэндийн газартай хамтран дараах сэдвээр Гэмтлийн суурь тусламжийн ангилал ерөнхий ойлголт.

2018 оны 03 сарын 30, 31 нд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн удирдлага болон ажилчдад хоёр удаагийн 8 цагийн сургалт орсон ба нийт 62 оролцогч хамрагдсан дараах сэдвээр Амилуулах суурь тусламж болон гэмтлийн үеийн суурь тусламжаар онол дадлага хосолсон ажлын байрны сургалтыг орсон. Сургалтын өмнөх сорил тест 53% байсан ба сургалтын дараах сорил тест 79% ахиц 25% байсан.




2018 оныг Өрхийн эрүүл мэндийг дэмжих жил болгосонтой холбоотой 185 ӨЭМТ-ийн 3560 эмч, ажилчдад амилуулах суурь тусламжийн сургалтуудыг 2 сарын турш явуулснаар хамтын ажиллагаа нэмэгдэж уялдаа холбоо сайжирсан.




2018 оны 04 сарын 06 нд Наркологийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч нарт дээрх сэдвээр нийт 2 өдрийн 16 цагийн сургалт хамтран зохисон нийн 16 ажилтан хамрагдсан.


2018 оны 04 сарын 08-09 нд Шүд эрүү нүүрний эмнэлгийн 48 эмч, сувилагч эмнэлгийн ажилтанд 2 өдрийн 16 цагийн яаралтай тусламжийн сэдвээр сургалт орсон сургалтыг өмнөх сорил тест 53% байсан сургалтын дараах сорил тест 78% мэдлэг ур чадвар 25%-иар нэмэгдсэн.



2018 оны 04 сарын 11 нд Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн төв болон Нийслэлийн эрүүл мэндийн газартай хамтран дараах сэдвээр: Амилуулах лавшруулсан болон Гэмтлийн суурь тусламжийн ангилал ерөнхий ойлголт дээрх сэдвээр сургалт 2 өдрийн 16 цагийн сургалтыг явуулсан эмч, сувилагч нийт 86 ажилтан хамрагдсан. Сургалтын сорил 25,3%-иар нэмэгдсэн.



Нийслэлийн бүс нутагт амралтын болон сувиллын газруудын эмч, сувилагч нарт эмнэлгийн анхан шатны тусламжийн сургалтыг зохион байгуулсан. Энхсаран сувиллын нийт 18 эмч, сувилагч хамрагдсан сургалтын өмнөх сорил 58,5% байсан сургалтын дараах сорил 82,3% ахиц 23,8 сургалт амжилттай болсон.



2018 оныг өрхийн эмнэлгийн дэмжих жилийн хүрээнд 18 өрхийн 256 эмч, сувилагч



болон эрүүл мэндийн ажилтан нарт дээрх сэдвээр сургалтыг онол дадлага хосолсон ажлын байрны сургалтыг зохион байгуулсан өрхийн эмч сувилагч нарт үр дүнтэй болон.

2018 оны 05 сарын 05-нд Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн нэгдэлтэй хамтран Баянзүрх дүүргийн сувилагч нарын дунд алтан гарт сувилагч тэмцээн зохион байгуулсан. Тэмцээнд нийт 118 сувилагч нар 13 багт хуваагдан яаралтай тусламжийн ур чадвараар өрсөлдсөн.

2018 оны 01 сарын 15, 16, 25-ний өдрүүдэд Шүүх эмнэлгийн 136 алба хаагчдад Амилуулах болон Гэмтлийн үеийн суурь тусламжийг сургалтын алба болон хүний нөөцтэй хамтран сургалтыг зохион байгуулсан ба сургалт үр дүнтэй болсон.



Нийслэлийн түргэн тусламжийн сургалтын алба болон Шастны нэрэмжит 3 эмнэлгийн сургалтын алба хамтран тус эмнэлгийн эмч, сувилагч, үйлчилгээний ажилчдад Амилуулах суурь тусламж болон Эмнэлгийн халдвараар 2018 оны 02 сарын 13-аас 14 нд сургалт орсон.



Хилийн цэргийн 16 эмч, сувилагч нарт Амилуулах суурь болон Лавшруулсан суурь тусламжаар 2018 оны 03 сарын 06-аас 08 хүртэл онол болон дадлага олгох сургалтыг явуулсан. 2018 оны 2 сарын 29-нд төгсөлтийн дараах сургалт Яаралтай тусламжийн эмчийг бэлдэх хэлэлцүүлэг Японы AMDA болон Эрүүл мэндийн хөгжлийн төв хамтран зохион байгуулсан уулзалтад илтгэл тавьсан.



Нийслэлийн Эрүүл мэндийн хөгжлийн төв болон Цагдаагийн ерөнхий газартай хамтран нийслэлийн эрүүлжүүлэх байрны эмч, шуурхай мэдээллийн төвийн алба хаагч нарт 2018 оны 3 сарын 29-өөс 4 сарын 02 хүртэл 62 алба хаагч нарт сургалт орсон.



Хөдөлмөр аюулгүй байдлын сургалтыг мэргэжлийн сургалтын төвүүдтэй хамтран зохион байгуулсан ба 5 удаагийн 40 цагийн сургалтыг анхны тусламж сэдвийн хүрээнд 98 мэргэжилтэнд орсон.

ХБНГУ- ТАЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

Нийслэлийн түргэн тусламжийн төв болон ХБНГУ-ын Эссэн хот 2010 оноос өнөөг хүртэл хэрэгжиж буй Mongolian Emergency Service Hospital Hygiene Project (MeshHp) төслийн хүрээнд 2018 оны 04 дүгээр сарын 14-өөс 21-ны өдрүүдэд ХБНГУ-ын Эссен хотын их сургуулийн эмнэлгийн доктор Валтер Попп, гал унтраах ангийн сургагч багш Jorg Spors, Volker , Nina Parohl нар уригдан ирж хамгийн сүүлийн үеийн технологиудыг танилцуулж, эмнэлгийн эрүүл ахуй, халдваргүйтгэлийн стандартыг сайжруулах талаар зөвлөгөө өгч 5 хоногийн сургалт зохион байгууллаа. Тус сургалтад 15 жолооч, 10 их эмч, 20 сувилагч хамрагдаж эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ, халдваргүйтгэл ариутгал сэдвээр 5 хоногийн сургалт, практикт суурилсан дадлага ажлыг зохион байгуулж туршлага солилцов. Сургалтын үр дүнд эмч жолооч нарын хамтран ажиллах чадвар дээшилж, эмнэлэг хүртэлх тусламжийн чанар хүртээмж сайжирч, халдваргүйтгэлийн төлөвлөгөө гарган ажилласнаар машины эрүүл ахуй сайжирна.



ЯПОН УЛСТАЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

- Гамшиг, онцгой байдлын үеийн эмнэлгийн тусламж үзүүлэх үндэсний баг бэлтгэх сургалтын хөтөлбөрийн хүрээнд Япон улсын сургагч багш нар ирж 2018.04.23-04.26 хооронд ЭМЯам дээр 3 өдрийн сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад гамшгийн үед тусламж үзүүлэх эмнэлгийн багууд хамрагдсанаас нийслэлийн түргэн тусламжийн төвөөс 4 их эмч, 4 сувилагч хамрагдлаа.



Үр дүн: энэхүү сургалт зохион байгуулснаар Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын гамшгийн үеийн тусламж үйлчилгээ болон хариу арга хэмжээ, гамшгийн үеийн түргэн тусламж, бэлэн байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлж,

тусламж, үйлчилгээний чанар, чадавх дээшилнэ. Дэвшилтэд техник технологи, мэдээ мэдээллийг суралцаж, цаашдын яаралтай тусламжийн чиглэлийн харилцаа холбоотой ажиллахаар болсон.

- AMDA олон улсын байгууллагатай хамтран ажиллах талаар:



“АМДА” олон улсын байгууллага болон Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2018 оны 03-р сарын 23-ний өдөр AMDA International Mongolia-ийн монгол дахь төлөөлөгч болон AMDA Монголын зөвлөх Тае Namba нартай уулзалт зохион байгуулсан. Уулзалтын хүрээнд “Япон Монголын” эмнэлгийн үйл ажиллагааг дахин ажиллуулах болон 9 сард болох олон улсын хурал, 103 эмч нарт сургагч багш бэлдэх сургалт семинарын тухай хэлэлцүүлэг хийв. Гамшгийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, бэлэн байдлыг сайжруулах зорилгоор нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын гамшгийн штабын эмч мэргэжилтнүүдийг чадавхыг дээшлүүлэх шаардлагатай байна. Иймд АМДА олон улсын байгууллагын Азийн эмч нарын холбооны эмч Такуши Сатотой хамтран дээрх сургалтыг 2018 оны 09 дүгээр сарын 06-08-ний өдөр зохион байгуулна.

3.МАЛАЙЗ УЛС

AMDA-ийн олон улсын хурал 2018 оны 1-р сарын 26-аас 28-ны өдрүүдэд Малайзын Куала Лумбурд зохион байгуулагдсан олон улсын хуралд НТТТөвийн дэд захирал С.Ариунболд оролцож илтгэл тавилаа. Нийт азийн 32 орон тус хуралд хамрагдсан бөгөөд 18 улсын 103 илтгэл тавигдаж, итгэлийн хугацаа 10 минут үргэлжилсэн.



4.ИЗРИАЛ УЛСТАЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

2018 оны 03 дугаар сарын 05-ны өдөр тус төв дээр Израйл улсын Гамшгийн болон Түргэн тусламжийн төвийн удирдах газрын ерөнхий зохицуулагч Chaim Rafalowski болон Нийслэлийн түргэн тусламжийн төвийн дэд захирал С.Ариунболд нар уулзалт зохион байгуулж төвийн үйл ажиллагаатай танилцаж, цаашид хийгдэх ажлын талаар ярилцлаа.



5.АНУ УЛСТАЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:



2018 оны 05 дугаар сарын 30-ны өдөр тус төв дээр АНУ-ын Юта мужийн Salt Lake хотод байрлах University of Utah Health Sciences –анагаахын ухааны сургуулийн яаралтай тусламжийн тасгийн дарга Matthew Joseph Fuller, M.D, Shakira Bandolin M.D эмч нар болон Нийслэлийн түргэн тусламжийн төвийн захирал Ц.Пүрэвдаш, дэд захирал С.Ариунболд тус төвийн үйл ажиллагаатай танилцан цаашдын хамтын ажиллагааны талаар уулзалт хийж, 4 чиглэлээр сургалт зохион байгуулахаар боллоо. Үүнд: Лавшруулсан суурь тусламж, эрэмбэлэн ангилалт, зүрх судас, гамшгийн үеийн түргэн тусламж гэсэн сэдвийн хүрээнд сургалт, сургагч багш бэлдэх чиглэлээр хамтран ажиллана.

6.БНСОЛОНГОС УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

БНСолонгос улсын DAEJEON” хотын эрүүл мэнд технологийн их сургуулийн “Сувилахуйн яаралтай тусламжийг газар дээр нь үзүүлэх, эмнэлэг хүргэх тусламж” сэдэвт сургалт семинар 2018 оны 01-р сарын 22-ноос 28-ны хооронд зохион байгуулагдсан бөгөөд тус төвөөс Г.Болормаа сувиллагч амжилттай оролцлоо. Энэхүү сургалтад хамрагдсанаар сувилахуйн тусламж үйлчилгээний үеийн тусламж чанар сайжирч шинэ арга барилыг нэвтрүүлнэ.



7.НҮБ-ЫН ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГАА



Бүгд Найрамдах Судан Улсын Дарфур мужид явагдаж буй Африкийн холбоо, НҮБ-ын хамтарсан UNAMID ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй Монгол Улсын цэргийн хээрийн II шатны эмнэлгийн VIII ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүн 2016 оны 09 дугаар сарын 07-ны өдрөөс 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийг хүртэл 16 сарын хугацаанд хамгийн урт энхийг сахиулах тус ажиллагаанд Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн их эмч Б.Халиунаа, Л.Түвшинбаяр, А.Алтанзагас, Н.Алтансар, Б.Саруул тус тус энхийг дэмжих ажиллагаанд амжилттай үүрэг гүйцэтгэсэн.

8. ЯПОН УЛС



одоо дэлхийн 30 гаран оронд салбар

AMDA- The Association of medical doctors of Asia- Азийн эмч нарын нийгэмлэг нь анх 1984 онд Япон улсын Окаяма мужид анх байгуулагдсан бөгөөд

байгууллагатай. Тус байгууллага нь дэлхий дахинд тохиолдож буй байгалийн гамшиг өлсгөлөн гэх мэт хүн ам олны хамарсан гамшгийн үед тусламж үзүүлдэг хүмүүнлэгийн байгууллага юм.

Нийслэлийн Түргэн тусламжийн төв нь тус байгууллагатай 2012 оноос хойш одоог хамтран ажиллаж байгаа билээ. Хамтын ажиллагааны дагуу 2013 оны 11 сарын 08-нд Филиппин улсад болсон “YOLANDA” хэмээх хар шуурганы улмаас нэрвэгдсэн хотуудад хүмүүнлэгийн болон эмнэлгийн тусламж үзүүлэх үед түргэн тусламжийн төвөөс 2 их эмч оролцсон. Харин энэ онд Япон улсад өнгөрсөн 07 сарын 08-нд хүчтэй аадар бороо орсны улмаас сүүлийн 30 жилд тохиолдоогүй байгалийн гамшигт нэрвэгдэж тус улсын 11 бүс нутаг үерийн усанд, хөрсний нуралтад автсаны улмаас 200 гаруй хүн нас барж, 60 хүн ор сураггүй алга болж, хоёр сая иргэнийг нүүлгэн шилжүүлсэн тоо баримттай байна. Иймд “АМДА” олон улсын байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн их эмч А.Алтанзагас 2018.08.05-ны өдрийн 07:45 минутад “МИАТ” компанийн ОМ-501 дугаартай нислэгээр Япон улсын “NARITA” олон улсын нисэх онгоцны буудалд 14:35 минутад газардаж HIKARI-461 дугаартай Шинкасан хурдны гал тэргээр Окаяма мужийн Сожа, Kurashika хотод гамшигт өртсөн ард иргэдэд туслахаар очлоо. АМДА-ийн гүйцэтгэх захирал Тае Namba, Сожа хотын захирагч Маауа, Minami эмнэлгийн захирал Kongo, нар хүлээн аван уулзалт хийж цаашид хамтран хийх ажлын талаар хэлэлцлээ. Байгалийн гамшиг Япон орны баруун хэсгийг хамарсан бөгөөд хамгийн их өртсөн хот Сожа, Курашика хот байсан бөгөөд хэдий байгалийн хүчтэй аадар бороо зогссон байсан ч нүүлгэн шилжүүлсэн иргэдийн биеийн байдал, сэтгэл санааны хувьд хүнд байлаа. Тухайн гамшгийн газар өдөртөө цаг агаар +40-өөс дээш байсан учир өндөр настай хүмүүс наранд цохиулах, даралт ихсэх үзэгдэл их байлаа. Сожа хотод байрлах сургууль, цэцэрлэгийн том зааланд нүүлгэн шилжүүлсэн иргэдийн хамт АМДА-ийн тусламжийн баг ажиллаж байлаа. Сожа хотын Окада сургуульд байрлах АМДА-ийн багтай 2018.08.06-2018.08.12-ны хооронд өглөөний 09:30 минутаас оройн 06:00 хүртэл байгалийн гамшигт өртсөн ард иргэдэд тусламж үзүүлж, олон улсын



эмч, мэргэжилтнүүдтэй хамтран гамшигт өртөж гэр оронгүй болсон, нүүлгэн шилжүүлж ирсэн иргэдэд үзлэг оношилгоо хийж, хоол хүнс болон эм тариа тараах зэрэг эмнэлгийн болон сэтгэлзүйн тусламж үзүүллээ. Уг ажиллагааны турш нийт 120 хүнд тусламж үзүүлсэн бөгөөд өвчтөнүүдийн ихэнх хувийг зүрх судасны өвчлөл, даралт ихсэлт, ходоод гэдэсний хямрал эзэлж

байлаа. Гамшгийн үед ажиллаж байх талаар Нийслэлийн Эрүүл мэндийн газар, GoGo news.mn, мэдээлсэн байлаа. Энэхүү ажлын дараа хоёр улсын хамтын ажиллагаа сайжрах, цаашид хийгдэх ажлын чиглэл нэмэгдэх үр дүнтэй билээ.

9. ABROAD PROJECTS

2018 онд Нийслэлийн Түргэн тусламжийн төв болон Projects Abroad байгууллагын хамтын ажиллагааны гэрээний дагуу олон улсын ангаахын сургуулийн 1-р курсийн оюутнууд Монгол улсад 14 хоногийн сурч танилцах дадлага хийх чиглэлээр тус төв дээр олон орны нийт 45 оюутан хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдаж, дадлага хийв. БНСУ, Тайван, улсын 7 оюутан хамрагдсан. Гадны оюутнуудтай харилцан туршлага мэдлэг солилцох, эмч нарын англи хэлний



мэдлэг дээшилнэ.

10. ЯПОН УЛСЫН ЗҮҮН АЗИЙН ИХ СУРГУУЛИЙН ПРОФЕССОР ТАКИШИ САТО БАГШИЙН СУРГАЛТ

AMDA- The Association of medical doctors of Asia- Азийн эмч нарын нийгэмлэг нь анх 1984 онд Япон улсын Окаяма мужид анх байгуулагдсан бөгөөд одоо дэлхийн 30 гаран оронд салбар байгууллагатай. Тус байгууллага нь тус төвтэй 3 чиглэлээр хамтран ажиллаад 6 жил болж байна. 2017 оноос Зүүн Азийн их сургуулийн Профессор Такиши Сато багш нийслэлийн түргэн тусламжийн эмч нарт сургалт явуулж байна.

Энэ удаагийн сургалтаар:

- Үнхэлцэгт хатгалт хийх
- Ясанд хатгалт хийх , шингэн сэлбэх
- Амьсгалын зам чөлөөлөх, цагаан мөгөөрсөн хоолойг нээх мэс ажилбар
- Түргэний машинд дадлага хийх гэсэн сургалтын хөтөлбөрөөр 2 хоногийн сургалт хийгдлээ.



Мөн Проф. Сато багш Монгол –Германы хамтарсан эмнэлгийн халдваргүйтгэл, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сэдэвт олон улсын хуралд “ Гамшгийн үед гарах халдварт өвчний эрсдэл, сэргийлэлт ба эмчилгээ” сэдвээр илтгэл тавилаа. АМДА байгууллагын гүйцэтгэх захирал Тае Намба урилгаар хүрэлцэн ирж хуралд

мэндчилгээний үг хэлж хүнд хэцүү гамшгийн үед тусалсан Нийслэлийн Түргэн тусламжийн төвд талархсанаа илэрхийлж өргөмжлөл гардууллаа.



сайжирна.

Энэхүү сургалт нь сүүлийн 2 жил нийслэлийн түргэн тусламжийн эмч нарт зохиогдож байгаа бөгөөд сургалтын үр дүнд гадны өндөр хөгжилтэй орны эмчилгээний аргыг нэвтрүүлэх, гамшгийн үеийн бэлэн байдлын тусламж үйлчилгээ

11. “ЭМНЭЛГИЙН ХАЛДВАРЫН ХЯНАЛТ БА СЭРГИЙЛЭЛТ” ГЕРМАН-МОНГОЛЫН ХАМТАРСАН СИМПОЗИУМ

Нийслэлийн Түргэн тусламжийн төв болон ХБНГУ-ын Эссэн хот 2010 оноос өнөөг хүртэл хэрэгжиж буй Mongolian Emergency Service Hospital Hygiene Project (MeshHp) төслийн хүрээнд 7 дах удаагаа “Эмнэлгийн халдварын хяналт ба сэргийлэлт” Герман-Монголын хамтарсан симпозиумыг зохион байгуулж байна. 2018 оны 09 сарын 19-20-ны өдрүүдэд зохиогдлоо. Эмнэлгийн халдвар хамгааллын зөвлөгөөн олон улсын халдвар хамгааллын стандарт болон эмнэлгийн хог хаягдлын талаар хэрхэн устгах, гээд олон зүйлийг эмнэлгийн тусламж үйлчилгээ, халдвар хамгаалалд нэвтрүүлэх олон санааг олж авна.



12. JICA ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА:

ЖАЙКА нь Ази, Африк, Өмнөд Америк, Австрали, Ойрхи Дорнод, Зүүн Европын 155 оронд хамтын ажиллагаагаа хэрэгжүүлдэг олон улсын байгууллага билээ. Shinichi Kitaoka President, the Japan International Cooperation Agency /JICA/ байдаг бөгөөд Японоос төслийн 4 ажилтан манай байгууллага дээр үйл ажиллагаатай танилцан цаашид хамтран ажиллах, хийгдэх ажлын талаар хэлэлцүүлэг хийлээ.

13. ХБНГУ-д ТУРШЛАГА СУДЛАХ




Монгол улс, ХБНГУ хоорондын найрсаг харилцаа гэрээний дагуу MeshHp төслийн хүрээнд эмнэлгийн халдвар хамгаалал, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх парамедик сургалтын талаар туршлага судлах, холбогдох эмнэлгүүдтэй танилцахаар Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн захирал Ц.Пүрэвдаш ХБНГУ-ын Эссэн хотод 2018 оны 11

дүгээр сарын 24-өөс 12 дугаар сарын 02-ны хооронд ажиллаад ирсэн. Энэхүү айлчлалын үр дүнд өндөр хөгжилтэй орны эмнэлэг үйлчилгээг нэвтрүүлэх, хамтын ажиллагаа өргөжин тэлнэ.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАН АЖИЛСАН ТАЛААР:

Тус төвийн цахим хуудсанд байх шаардлагатай мэдээ мэдээлэл стандарт, шалгуур үзүүлэлтийн дагуу хийгдэж байна. Байгууллагын ил тод байдлын мэдээ мэдээлэл, иргэд үйлчлүүлэгчдэд хандсан нийгмийн эрүүл мэндийн мэдээ, мэдээлэл, байгууллагын дотоодод болж буй мэдээлэл, чанарын булан, гадаад харилцаа, дуудлагын статистик мэдээлэл, сургалт сурталчилгаа, эрүүл мэнд, анхан шатны тусламжийн зөвлөгөө, сэрэмжлүүлэг, үйл ажиллагаагаа сурталчлах зорилгоор өөрийн байгууллагын танилцуулга, бүтэц зохион байгуулалт, үүсэл хөгжил гэх мэт мэдээллээр баяжуулан ажиллаж байна.



- Нэг өдрийн дундаж хандалт – 350 хүн
- Сарын дундаж хандалт – 10500 хүн

Цахим хуудасны хандалтыг ихэсгэх зорилгоор шинэ мэдээ мэдээллийг тогтмол оруулж байх, мөн байгууллагын фейсбүүк хуудсаар дамжуулан мэдээлж байна.

Байгууллагын фейсбүүк хуудсаар нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, байгууллагын мэдээлэл, статистик мэдээлэл, зөвлөгөө, талархал, олон нийтийн ажил гэх мэт 263 мэдээлэл оруулан ажиллаж байна.

Ил тод байдлыг шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан ба цахим хуудсанд байх шаардлагатай мэдээ, мэдээлэл багтсан.

- 2018 онд Монголын үндэсний радиод “Дэлхийн Монгол”-ын радио MJL 102.5 Даваа, Баасан гариг бүрд Томуу томуу төст өвчин, бусад өвчлөлийн талаар мэдээлэл чанарын албанаас тогтмол өгч байна.
- “Томуу, томуу төст өвчний халдвараас сэргийлье” зөвлөмж болон томуу, томуу төст өвчний үед ажилласан тухай мэдээллийг тогтмол хүргэх мэдээллийг ХӨСҮТ-д Eop@nccd.gov.mn тогтмол өгдөг.
- 01-р сарын 12-нд МҮ-ний Радиогийн айл гэрийн “аюулгүй байдлын дүрэм” 30 минутын шууд ярилцлагад оролцсон.

- 03-р сарын 13-нд хүүхдийн осол гэмтэл, түүнээс урьдчилан сэргийлэх талаар МУ-ний Радиогийн хүүхдийн нэвтрүүлгээр 30 минутын шууд ярилцлагад оролцсон.
- Баасан гаригуудад 77011941 дугаарт мэдээ мэдээлэл тогтмол өгч байна
- 2018 оны 02.14-02.15 Цагаан сарын үеэр хордлого, гэмтэл, түлэгдэлтийн чиглэлээр сэрэмжлүүлэг сэдвээр Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга С.Ариунболд С1, NTV, UBS, Эх орон телевиз тус тус ярилцлага зөвлөгөө өгсөн.
- 2018 оны 02.23 “Эрүүл мэндийн боловсрол ба Нийслэлийн Түргэн Тусламжийн төвийн өнөөгийн байдал” сэдвээр Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга С.Ариунболд “Eagle” телевизийн “Ийглийн мэдээ” мэдээллийн хөтөлбөр / 30 минут / оролцлоо.
- 3 дугаар сарын 13-нд Монголын үндэсний радиод “Аюулгүй байдлын дүрэм” айл бүрд 30 минутын шууд ярилцлагад хүүхдийн мэргэжилтэн оролцсон.
- 05 дугаар сарын 22-нд Монголын үндэсний радиод “Хүүхдийн осол гэмтэл, түүнээс урьдчилан сэргийлэх” 30 минутын шууд ярилцлагад хүүхдийн мэргэжилтэн оролцсон. Ингэснээрээ иргэдийн гэнэтийн осолд өртөхгүй байх урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө өгсөн.
- MJL-Дэлхийн Монгол 102.5 радиод даваа, баасан гаригуудад 77111941 утсаар шууд 2-5 минутын хугацаанд иргэдэд эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор мэдээллийг тогтмол өгч ажиллаж байна. MJL-Дэлхийн Монгол 102.5FM Томуу томуу төст өвчлөлийн үед, менингококкт халдвар, тууралтад халдвар, салхин цэцэг, улаан бурхан, гар хөл амны өвчин, гараа угаахын ач тус, хоолой ам зайлах энгийн аргууд зэргээр мэдээлэл тогтмол өгсөн.
- Үүнд:
 1. 06:08 Эбола болон хачигт халдварт өвчний мэдээлэл, урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл
 2. 06:11-нд Наршилт, нарны хордлогоос урьдчилан сэргийлье
 3. 06:15-нд Артерийн даралт ихсэлтээс сэргийлье
 4. 06:18-нд Харшлын талаар үүн дотроо шарилжийн харшил, анафилаксийн шокны талаар мэдээлэл
 5. 06:22-нд МҮРТВ-д хүүхдийн осол гэмтлийн талаар ярилцлага өгсөн.
 6. 06:25-нд үер усны аюулаас сэргийлье
 7. 06.29-нд хоолны хордлого, гэдэсний халдвараас сэргийлэх зөвлөмж
 8. 07:02-нд эрүүл амьдралын 12 зөв дадал хэвшил
 9. 06:08 Эбола болон хачигт халдварт өвчний мэдээлэл, урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл
 10. 06:11-нд Наршилт, нарны хордлогоос урьдчилан сэргийлье
 11. 06:15-нд Артерийн даралт ихсэлтээс сэргийлье
 12. 06:18-нд Харшлын талаар үүн дотроо шарилжийн харшил, анафилаксийн шокийн талаар мэдээлэл
 13. 06:22-нд МҮРТВ-д хүүхдийн осол гэмтлийн талаар ярилцлага өгсөн.
 14. 06:25-нд үер усны аюулаас сэргийлье
 15. 06.29-нд хоолны хордлого, гэдэсний халдвараас сэргийлэх зөвлөмж

16. 07:02-нд эрүүл амьдралын 12 зөв дадал хэвшил
 17. Наранбайгальд шилжүүлэв. Ээлжийн амралт 07-р сарын 06-аас амарсантай холбоотой.
 18. 08:16-нд ажилдаа орж 08:20-нд орчны агаарын бохирдол сэдвээр гэр хорооллын бие засах газрын эрүүл ахуйн стандартын талаар, ариутгалын халдваргүйтгэлээр
 19. 08-27-нд дотоод орчны агаарын бохирдол эрүүл мэндэд нөлөөлөх нь, түүнээс урьдчилан сэргийлэх нь
 20. 08-31- Амьсгалын замын өвчлөлөөс сэргийлэхэд орчны эрүүл ахуй, агаарын бохирдол нөлөөлөх, түүний эх үүсвэр, иргэн өөрийн оролцоо нь
 21. 09-р сарын 03-нд 14:25 хүүхдийн болзошгүй эрсдэлээс сэргийлье сэдвээр ярилцлага өгсөн.
 22. 09-р сарын 03-нд 14:25 Гадаад орчны эрүүл ахуй
 23. 09-р сарын 07-нд 14.25 Гэдэсний халдвар
 24. 09-р сарын 10-нд Тархинд цус харвахаас сэргийлье
 25. 09-р сарын 17-нд Халууралт гэж юу вэ, анхаарах зүйл, авах арга хэмжээ
 26. 09-р сарын 21-нд Ханиад шуухнаа, АЗЦХ-аас сэргийлэх аргууд
 27. 09-р сарын 24-нд Ам хоолой зайлах, хамар цэвэрлэхийн ач тус, өвчнөөс сэргийлэх нь
 28. 10-р сарын 1-нд арьсны халдвар болон дуут машинд зам тавьж өгөх уриалга
 29. 10-р сарын 08-нд сүрьеэгээс сэргийлье.
 30. 11-р сарын 13-нд томуугийн урьдчилан сэргийлэлт зэрэг дээрх мэдээллийг тус радиод өгснөөр иргэдийн эрүүл мэндийн мэдлэг сайжирч байна.
- 2018 оны 04 сарын 07-нд дэлхийн эрүүл мэндийн баярын өдөртэй холбоотой эрүүл амьдрал сэдвээр иргэдэд мэдээлэл өгсөн.
 - 2018.08.15 Монгол эмч япон улсад гамшигт өртсөн иргэдэд тусламж үзүүлж байна гарчгаар онцлох мэдээгээр [Gogo.mn](http://news.gogo.mn/r/229010) <http://news.gogo.mn/r/229010> мэдээлэл тавигдсан.
 - 2018.08.12 Нийслэлийн түргэн тусламжийн эмч япон улсад гамшигт өртсөн иргэдэд тусламж үзүүлж байна. Мэдээ мэдээлэл булангаар НЭМГазрын сайтад [/index.php/2014-11-11-08-12-08/1805-2018-08-09-02-53-42](http://www.103.ub.gov.mn/index.php/2013-12-03-04-17-15/2013-12-04-01-12-56/926-2018-10-30-02-52-09) мэдээлэл өгсөн.
 - 2018.10.30 Хүний төлөө хурд мэдэн довтолгогч Мэдээлэл Facebook page-ээр <http://www.103.ub.gov.mn/index.php/2013-12-03-04-17-15/2013-12-04-01-12-56/926-2018-10-30-02-52-09> линкээр түргэний машин замын түгжрэлд хэрхэн ажилладгийн Mr.Do мэдээлэл тавьсан.
 - 2018 оны 04 сарын 14-нд HD МОНГОЛ телевизийн өглөөний зочин нэвтрүүлэгт анхны тусламжийг иргэд хэрхэн зөв үзүүлэх талаар сургалтын хэрэглэл ашиглан иргэдэд мэдээлэл өгч Нийслэлийн түргэн тусламжийн төвийн үйл ажиллагааг иргэдэд сурталчилсан.
 - 2018 оны 05 сарын 03 нд LIKE TV д эрүүл



мэндийн зөвлөгөө мэдээлэл өгсөн.

- 2018 оны 06 сарын 17 нд UBS телевизийн эрүүл мэнд эрхэм баян нэвтрүүлэгт осол гэмтлийн үеийн яаралтай тусламж сэдвээр 2 цагийн цуврал нэвтрүүлэг хийж зөвлөгөө өгсөн нь ард иргэдэд таалагдсан ба улсын баяр наадамд зориулагдан давтан дамжуулагдсан.



- 2018 оны 10 дугаар сарын 03 нд Монголын үндэсний телевизийн “Өглөө хөтөлбөрийн зочин”-оор Нийслэлийн Түргэн тусламжийн гадаад харилцааны ажилтан А.Алтанзагас оролцсон. 8 сард Япон улсад болсон гамшгийн үед Хойд Судан улсад энхийн сахиулах, 2013 онд

Филлипин улсад ажилласан талаар ярилцлага өглөө.

20 б/ Байгууллагын харьяа нэгжүүдийн үндсэн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан тухай мэдээлэл.

Нийслэлийн түргэн тусламжийн төв нь 2018 онд Эрүүл мэндийн сайдын 2014 оны 01 сарын 13-ны өдрийн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны аргачлал батлах тухай 13 тоот тушаалын дагуу НТТТ-ийн эмч, эмнэлгийн ажиллагсад 301, үйлчлүүлэгчдээс 120 хэрэглэгчийг хамруулан сэтгэл ханамжийн судалгаа авч, статистик боловсруулалтыг Excel программыг ашиглан хийв.

1. ЭМЧ, ЭМНЭЛГИЙН АЖИЛЛАГСДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА


Эмч, эмнэлгийн ажиллагсдын сэтгэл ханамжийн судалгаанд сувилагч 21, эмч 145, жолооч 76, бусад ажилчид 59, нийт 301 хүн хамрагдсан. Дэмжлэгт удирдлага, хүний нөөцийн хөгжих боломж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл, байгууллагын соёл, тусламж үйлчилгээний чанар, ажлын аюулгүй байдал, дэмжлэгт орчин гэсэн 6 бүлэг 62 асуултаар судалгаа авсан. Судалгаанд оролцогсдын 65.0% нь байгууллагаараа бахархаж байна гэж эерэг үнэлгээ өгсөн байна.

Дэмжлэгт удирдлага гэсэн бүлэгт байгууллагын дарга нарын удирдах арга барил 2018 онд 59.2% ,ёс зүй 55.2 % сайн гэсэн эерэг үзүүлэлттэй байна.


Өнгөрсөн онтой харьцуулахад 7.0%-аар өссөн нь удирдах албан тушаалтны багын ажиллагаа сайн байгааг харуулж байна.

Мөн 2018 онд байгууллагын онцлогт тохируулан тасаг нэгжийн удирдах арга барил асуултыг ээлжийн ахлагч, зохицуулагч нараар өөрчлөн хийсэн бөгөөд удирдах арга барил 68.1% хангалттай гэж үнэлсэн байна. Энэ 24 цагаар эмч, жолооч,

сувилагч нартаа ажилладаг тул уялдаа холбоо, багаар сайн ажилладаг нь харагдаж байна.




Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг 24 цагаар хамтдаа ажилладаг эмч-зохицуулагч, эмч-жолооч, эмч-сувилагч гэж асуултыг гаргасан бөгөөд тус судалгаагаар ёс зүй 70-аас дээш хувьтай байгаа нь багаар ажиллах, нэг нэгнээ хүндэтгэх, мэндлэх, найрсаг харилцаа сайн байгааг харуулж байна.



Эмч эмнэлгийн мэргэжилтний хувийн соёл, энгэрийн тэмдэг, хувцаслалт 66.7 % эерэг сайн үнэлгээ өгсөн байгаа нь хувь хүмүүсийн соёл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн сургалт 4 удаа явагдсаны үр дүн харагдаж байна. Хамт олны эв нэгдэл, хоорондын харилцаа 68.3 % сайн гэж хариулсан нь хамт олны дунд найрсаг харилцаа тогтоох спорт, урлагийн тэмцээн уралдаан зохион байгуулах, ажилчидтай холбогдох баяр наадмаар шагнал урамшуулал олгох зэрэг нь хамт олны найрсаг харилцаатайг харуулж байна.

Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдалд судалгаанд оролцогсдын 52.7% сайн гэж үнэлсэн байна. Ажлын хариуцлага, шуурхай байдал өмнөх онтой харьцуулахад 10.2%-аар өссөн эерэг үзүүлэлттэй байгаа нь эмч, жолооч нарын ажлын ур чадвар сайн байгааг харуулж байна.



Тусламж үйлчилгээний стандарт мөрдөж ажиллах, чанар аюулгүй байдлыг хангаж ажилласан байдал 56.7% өмнөх онтой харьцуулахад 2.6% -аар дээшилсэн байгааг нь эмч нарт ур чадварын сургалт болоод стандарт удирдамжаар тогтмол ажил зохион байгуулсны үр дүн харагдаж байна.

2. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ДҮН

2018 онд нийт 306.478 дуудлага хүлээн авч үйлчилсэн нь өнгөрсөн оныхоос 5387 дуудлагаар өсөж иргэдэд хүрч үйлчлэх яаралтай тусламжийг хүргэсэн байна.

Төв, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул салбараар үйлчлүүлж буй 120 үйлчлүүлэгчдээс байгууллагын соёл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, тэгш байдал, ашиг сонирхол гэсэн 4 бүлэг 22 асуултаар судалгаа авсан.

Судалгаанд оролцогсдын 63% нь 28-50 насны үйлчлүүлэгчид, 58.9% нь манай байгууллагаар 2 түүнээс дээш удаа үйлчлүүлсэн байна.

Байгууллагын соёл, үйл ажиллагааны талаарх иргэдийн бодол 69.2% сайн гэж судалгаанд оролцсон үйлчлүүлэгч үнэлсэн байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 24%-р дээшилсэн үзүүлэлттэй байна. Мөн Facebook-ээр мэдээ мэдээлэл байршуулан сурталчилж байна.

Facebook-т сүүлийн үед их хандалттай байгаа Mr.Do пэйжийн админтай хамтарч “Түргэн тусламжийн автомашинд зам тавьж өгцгөөе” сэдэвт видео шторк хамтран хийж маш олон хүний хандалт авсан.

Байгууллагын ерөнхий сэтгэл ханамж сайн 79.2% сайн гэсэн үнэлгээтэй үнэлэгдсэн байна. Өмнөх онтой харьцуулахад 25%-аар өссөн үзүүлэлттэй байгаа нь иргэдийн сэтгэл ханамж сайн байгааг харуулж байна.



Судалгаанд оролцогч үйлчлүүлэгчийн санал хүсэлтээс дурдахад:

Ажиллаж буй эмч, эмнэлгийн ажилтнуудын тоог нэмэх, автомашины тоог нэмэх, харилцаа хандлагатай ажиллах, хурдан шуурхай байх, мэдлэг чадвар сайтай байх, хүний төлөө гэсэн сэтгэлтэй байх, олон нийтэд сургалт мэдээлэл сайн өгөх, хүлээгдэл чирэгдэлгүй болгох зэрэг саналууд тавьсан.

Түргэн тусламжийн үйлчилгээ хурдан шуурхай үйлчилсэн, эмнэлгийн тусламжийг сайн үзүүлсэн, зөв оношилсон, харилцаа хандлага сайн байсан зэрэг талархлыг санал асуулгад оролцогсад талархаж өгсөн байна.

Судалгаанд оролцогч эмч, эмнэлгийн ажилчдын санал хүсэлтээс дурдахад:

Эмч сувилагчийн харьцааг 1:1 болгох, сувилагчийн тоог нэмэгдүүлэх, цалин хөлсийг нэмэгдүүлэх, боловсон хүчнийг чадваржуулах, сувилагчийг орон тоогоор нь ажиллуулах, урамшууллыг үнэн зөвөөр олгож байх, ажлын үнэлэмжийг дээшлүүлэх, амьдрал ахуйг дээшлүүлэх зорилтот үйл ажиллагааг хэрэгжүүлэх Ажлын цагийг багасгах, яаралтай тусламжийн эм тарианы хангалтыг шинэчлэх зэрэг хүсэлтүүд ирсэн бөгөөд цаашид ирсэн саналуудыг удирдлагын зөвлөлд танилцуулан үйл ажиллагаандаа тусгаж ажиллана.

Тус төв нь өнөөдрийн байдлаар нийт 405 ажиллагсадтай, их эмч 160, сувилагч 34, жолооч 123 ажилладаг бөгөөд судалгаанд 301 буюу нийт ажиллагсдын 80,4% хамрагдлаа. Эмч, эмнэлгийн ажилчдаас хагас жилд 3, удаа, 7 бүлэг 56 асуултаар судалгааг бөглөдөг.

Судалгааны үр дүнд ерөнхий сэтгэл ханамж 2017 онд өнгөрсөн оны мөн үеэс 5%-иар нэмэгдсэн эерэг үзүүлэлттэй байна

САНХҮҮ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Тус төвийн 2018 оны төсөв 7,409.8 сая төгрөгөөр батлагдан доорх зардлуудад зориулалтын дагуу хуваарилагдан зарцуулж байна.


Эрүүл мэндийн тухай хуулиар эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийг МУ-ын иргэнд төр хариуцах болсон тул үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө тусгагдаагүй 100 хувь улсын төвлөрсөн төсвөөс санхүүжиж байна.

Үүнд:

Байгууллагын үйл ажиллагааны онцлогоос шалтгаалж:

- Төсвийн ажиллагсдын цалин хөлс, хоол унааны нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал, ажил олгогчоос төлөх НДШ-д нийт төсвийн 77.2 хувийг,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, харуул хамгаалалтын гэрээт ажлын зардалд 4.3 хувийг,
- Түлш шатахуун, аж ахуйн хангамж, интернет шуудан холбоо, бичиг хэрэг, маягт хэвлэлт, хог тээвэрлэлт, ариутгал цэвэрлэгээнд 14.1 хувийг,
- Ажилчдын ажлын өвөл, зуны хувцас хийлгэхэд 0,3 хувийг,
- Эм, ороох боох материал, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур зэрэгт 2.4 хувийг,
- Эд хогшил, урсгал засвар, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс авахад 1.2 хувийг,
- Тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах үзлэг, даатгал, татвар, бусад төлбөрт 0.3 хувийг эзэлж байна.

БАТЛАГДСАН ТӨСВИЙН ХУВААРИЛАЛТ (сая төгрөгөөр, хувиар)



“Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2017 оны 337 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөний дагуу дараах биелэлттэй байна.

Үүнд:

Нэг. Төсвийн сахилга хариуцлагыг чангатгах, төсвийг үр ашигтай зарцуулах замаар төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх ажлын хүрээнд:

- 1.1 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байхаар сарын төсвийг хуваарилан зарцуулахдаа өмнөх жилүүдэд тогтмол үүсэж байсан эмийн өр төлбөргүй мөн шатахууны үнийн өсөлтөөс үүссэн өрийг хагас жилд барагдуулахаар ажиллана.
- 1.2 Арилжааны банк дах бүх шатны төсвийн байгууллагын цалингийн болон жижиг мөнгөн сангийн данснаас бусад дансыг хааж, төрийн сангийн нэгдсэн дансанд шилжүүлэх, цаашид төрийн байгууллага арилжааны банканд шинээр данс нээхгүй байх хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Төрийн сан дахь үндсэн болон нэмэлт, ЖМС-ийн арилжааны данс, ажилчдын картын түр данснаас өөр данс нээхгүй төсвийн сахилга батыг хангуулна.

Хоёр. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

2.1 Улсын Их хурлаас 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль болон 2018 оноос хэрэгжиж эхлэх татварын хуулиудын хэрэгжилтийг зохион байгуулах хүрээнд татварын өөрчлөлтийг “Санхүүгийн бүртгэл, цалин бодолт”-ын програм хангамжид 2018.04 сард оруулж, өмнөх саруудын зөрүүг хуулийн дагуу нөхөж тооцсон.

2.2 Батлагдсан орон тоог хэтрүүлэхгүй, цалингийн сангийн өр үүсгэхгүй, зөвхөн Засгийн газрын тогтоол болон холбогдох шийдвэрээр батлагдсан нэмэгдлийг олгох хүрээнд батлагдсан орон тоонд багтаан хэтрүүлэлгүй ажиллаж байна.

2.3 Урсгал төсвийн хөрөнгөөр зохион байгуулах худалдан авах ажиллагааг байгууллагын худалдан авах ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөнд тусгах, зохих хууль, журмын дагуу зохион байгуулах хүрээнд батлагдсан урсгал төсвийн хөрөнгөөр 2 төсөл, арга хэмжээг төлөвлөн худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд тусган www.tender.gov.mn цахим системд оруулав.

Гурав. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд манай байгууллагад хамааралгүй болно.

Дөрөв. Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомж, тушаал шийдвэрийг хэрэгжилтийг хангах

4.1 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.4-т заасан төсөл, арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгавар, техник эдийн засгийн үндэслэлийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэх ажлын хүрээнд худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг маягтын дагуу гаргаж <https://edoc.ub.gov.mn/> ээр албан тоотоор болон цахим хаягаар холбогдох мэргэжилтэнд илгээв.

4.2 Төсвийн байгууллагууд 2017 оны худалдан авах ажиллагааны тайланг орон нутаг, байгууллагын түвшинд нэгтэн Сангийн яаманд хүргүүлэх ажлын хүрээнд 2017 оны худалдан авах ажиллагааны тайланг журмын 2-8 дугаар хавсралт маягтын дагуу гаргаж цаасаар болон цахимаар хугацаанд нь илгээж тайлагнав.

4.3 2018 оны худалдан авах ажиллагааг цахимаар зохион явуулж худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд (tender.gov.mn) оруулж нийтэд мэдээлж байх ажлын хүрээнд худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг 2 бараа, ажил үйлчилгээгээр цахим системд оруулж нээлттэй болон харьцуулалтын аргаар зохион явуулж амжилттай явуулж дуусгасан.

4.4 Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажлыг зохион байгуулахдаа Ерөнхий гэрээгээр худалдан авахаар захиалсан тодорхой нэрийн эмийн захиалгын дүнг хасаж худалдан авалтыг зохион байгуулах ажлын хүрээнд Ерөнхий гэрээнд ороогүй эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтыг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу босго үнээс даваагүй тул үнийн харьцуулалтын аргаар тендерийн үр дүнгээр нийлүүлэгч байгууллага шалгарах хүртэл “Эцэг тайж” ХХК, “Энто” ХХК /тендерийн тоо хэмжээ дууссан/, “Ашид буян” ХХК, “Медклийн” ХХК-уудтай гэрээ байгуулав.

- 4.5 Худалдан авах ажиллагааны чиглэлээр ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдыг мэргэшүүлэх ажлын хүрээнд 2017 онд 5 хүнийг АЗ сертификаттай сургалтад хамруулав.
- 4.6 Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2018 оны худалдан авах ажиллагааны хагас жил, жилийн эцсийн тайланг нэгтгэн Эрүүл мэндийн яаманд тайлагнах ажлын хүрээнд 2018 оны 06 дугаар сарын 05 нд тайлагнав.

Санхүүгийн ил тод байдал


МУ-ын 2014.07.01-ны өдрийн “Шилэн дансны тухай” хууль, МУ-ын Сангийн сайдын 2017.12.14-ны өдрийн 363 тушаалаар батлагдсан “ТБОНӨХБАҮХА ажиллагааг төлөвлөх, тайлагнах” журам, Нийслэлийн Засаг даргын 2018 оны 04 дугаар сарын 18 өдрийн А/333 дугаар захирамжаар “Худалдан авах ажиллагааны зохион байгуулалтын тухай” журам, мөн 2018 оны А/268 тушаалаар батлагдсан “Нийслэлийн шилэн тендерийн бүртгэл”-ийн системийн үйл ажиллагаа”-ны журам, Нийслэлийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 24 өдрийн А/335 дугаар захирамж “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 9.1.3-ын д/ бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа, 9.1.4-ын а/ байгууллагын ил тод байдлыг үнэлэх ажлын хүрээнд;

НЭГ. 2018 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ЦАХИМААР ЗОХИОН БАЙГУУЛАХ, ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО, ХЯНАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, ИЛ ТОДООР БОЛГОХ

Харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх тендерийн төсөвт өртгийг 50.7 сая төгрөгөөр, Тавилга, багаж хэрэгсэл худалдаж авах тендерийн төсөвт өртгийг 85.1 сая төгрөгөөр төлөвлөн тус тус нээлттэй болон харьцуулалтын аргаар шалгаруулсан <https://open.ulaanbaatar.mn/>, Сангийн яамны дэргэдэх худалдан авах ажиллагааны газрын <https://tender.gov.mn/> сайтуудад ил тодоор толилуулав

2.1 Байгууллагын санхүү, НББ-ийн үйл ажиллагааг цахим хуудаст, вэбсайтад, ил тод байдлын самбар, сайтад мэдээллүүдийг байршуулсан.

- Батлагдсан төсөв 2 удаа
- Төсвийн сар бүрийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан – 12 удаа
- 2017 оны бүтэн жил, 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн баланс, тайлан – 2 удаа
- 2018-2020 оны ойрын 3 жилийн төсвийн төлөвлөлтийн санал /хөрөнгө оруулалт, урсгал зардал/ – 1 удаа
- НЭМГ-ын харьяа байгууллагуудын Аудитын нэгдсэн дүгнэлт – 1 удаа
- Бусад мэдээлэл хэсэгт шилэн дансны хууль, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн ажлуудыг нэмэгдүүлэн ил тодоор мэдээлэв.



2.2 “Шилэн данс”-нд байршуулбал зохих нийт 23 тайлан, мэдээ, файлуудыг дараах байдлаар мэдээлсэн:

- Өмнөх болон тухайн оны бүтэн жилээр 11 тайлан, мэдээлэл оруулахаас 5-г PDF файл хэлбэрээр, 6-г зохих маягтаар
 - Хагас жилээр 4 тайлан, мэдээлэл оруулахаас 1-г PDF файл хэлбэрээр, 3-г зохих маягтаар
 - Улирлаар өмнөх оны 1, тухайн оны 3 мэдээллийг зохих маягтаар-4
 - Сараар байршуулах 3 мэдээллийг өмнөх болон тухайн оны 36 удаа мэдээллийг зохих маягтаар
- Тухай бүр тайлагнах 8 маягтаар өмнөх болон тухайн оны 8 мэдээллээс 96 удаа мэдээллийг холбогдох тушаал, шийдвэр, байгуулсан гэрээ материалыг PDF хэлбэрээр хавсарган толилуулсан.

᠔ ᠔	Шилэн дансны мэдээллийн бүлэг	Шилэн дансны мэдээллийн төрөл	Өм нөх он	1	2	3	4	5-12 сар	Мэ дээ лсэ н то о
1.	Байгууллагын батлагдсан төсөв	ТӨСӨВ / ГҮЙЦЭТ ГЭЛ	БҮТЭН ЖИЛЭЭР	01.16					1
2.	Дараа жилийн төсвийн төсөл								1
3.	Санхүүгийн тайлан			04.25					1
4.	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт			04.25					1
5.	Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	БУСАД						1	
6.	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт	ТӨСӨВ / ГҮЙЦЭТ ГЭЛ		04.25					1
7.	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл	ХӨРӨНГ Ө ОРУУЛА ЛТ, ТЕНДЕР, ХУДАЛД АН АВАЛТ		01.10					1

8.	Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан	ТӨСӨВ / ГҮЙЦЭТ ГЭЛ							04.25								1
9.	Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан								04.25								1
10.	Худалдан авах ажиллагааны тайлан	ХӨРӨНГ Ө ОРУУЛА ЛТ, ТЕНДЕР, ХУДАЛД АН АВАЛТ							01.15								1
11.	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө									01.10							1
12.	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт	ТӨСӨВ / ГҮЙЦЭТ ГЭЛ	Удирал						01.08				04.08		7,10 сард		4
13.	Санхүүгийн тайлан													2017 08.1 5			1
14.	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт													2017 08.1 5			1
15.	Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан	ТӨСӨВ / ГҮЙЦЭТ ГЭЛ	Хагас жилээр											2017 08.1 5			1
16.	Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан													2017 08.1 5			1
17.	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт	ТӨСӨВ / ГҮЙЦЭТ ГЭЛ	Сараар						01.08	02.08	03.08	04.08	05.08		6-11 сар		12

26.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл	БУСАД	01.08	02.08	03.08	04.08	05.08	6-11 сар	12
27.	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	БУСАД	01.08	02.08	03.08	04.08	05.08	6-11 сар	12
2 3	ДҮН		96 удаа /мэдээ, тайлан/						

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Нэг. НЗД-ын 2018.01.31-ны өдрийн А/35 дугаар захирамж, НӨХГ-ын 2018.02.15-ны өдрийн З/285 дугаар зөвшөөрөл, тус төвийн Захирлын 2018.04.03-ны өдрийн А/12 дугаар тушаалаар “Барилга байгууламжийг бүртгэлд авах тухай” холбогдох шийдвэрүүдийг үндэслэн тус төвийн Хан-Уул дах салбарын барилгыг 2,681,8 сая төгрөгөөр хөрөнгийн данс бүртгэлд орлогод авч элэгдлийг анх хүлээн авч ашигласан хугацаанд нөхөн элэгдүүлэн бүртгэв.

Хөрөнгө оруулалтын тайлан-Загвар 3

Төсөл арга хэмжээний нэр	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр		Гүйцэтгэгч байгууллага	Ашиглалтад хүлээж авсан огноо	Тайлбар /чанар ашиглалтын байдал/
	Улсын Төсөв	Төсөл хөтөлбөр			
Нийслэлийн түргэн тусламжийн төвийн Хан-Уул салбарын барилга	2,681,781,116		“Хүрэл ордон” ХХК	2015.02.26	Концессын гэрээгээр чанарын шаардлага хангасан

Хоёр. Захирлын дээд шатны захирагчтай байгуулсан 2018 оны “Үр дүнгийн гэрээ”-нд тусгагдан төлөвлөгдсөн хөрөнгө оруулалтын ажлууд дараах байдал, явцтай хэрэгжиж байна.

Үүнд:

Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан үйл ажиллагаанд тусгагдсан хөрөнгө оруулалтын ажлуудаас

1. Тус төвийн түргэн тусламжийн автомашинд GPS төхөөрөмж суулгах ажил худалдан авалтын тендер шалгаруулалт холбогдох газарт явагдаж “BENQTECH” ХХК шалгарч худалдан авах ажиллагаа хийгдсэн.
2. Тус төвийн Чингэлтэй салбарын барилга угсралтын ажлыг гүйцэтгэх ажил Чингэлтэйн 14 дугаар хорооны нутаг дэвсгэрийн Хайлаастын гудамжид барихаар “Комп трейд” ХХК холбогдох газарт шалгарч барилгын ажил баригдаж эхэлсэн. Уг барилгын суурь болон карказ хийгдэж, арматурын бэхэлгээний ажил явагдаж байна.




Гурав. Хөрөнгө оруулалтын хэтийн төлөвлөгөө, дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулах томоохон ажлын хүрээнд НЭМГ-ын харьяа байгууллагуудын өнөөгийн байдалд судалгаа гаргаж тулгамдаж буй асуудлуудаар дараах байдлаар тэргүүлэх төсөвчнөөр газар дээр нь хэмжилт хийн төсвийг боловсруулан төлөвлөж дээд шатны захирагчид тайлагнан хүргүүлэв.


дд	Объектын нэр	Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Тайлбар тодруулга
1	Түргэн тусламжийн Төвийн барилга	Төвийн барилга, байгууламж /Төвийн эзэмшил газарт шинээр барих/	Эскиз зургийн томсгосон төсөвт өртөг 8,640.0 сая төгрөг	Мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтүүдээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон тул шинээр барих санхүүгийн эх үүсвэрийг “Азийн хөгжлийн сан”-ийн төсөлд хамруулах болсон.
2	Сонгино хайрхан салбар төв	Дээврийн засварын ажлын төсөв	43.3 сая төгрөг	НМХГ-ын 2017.01.18 ны өдрийн №02-03-287/19 тоот “Зөрчил арилгуулах тухай” албан шаардлага гарсан.
3		Барилгын	60.7 сая	Барилгын гадна фасадны

		дулаалгатай гадна фасадны ажлын төсөв	төгрөг	ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглах хугацааг нэмэгдүүлж, өнгө үзэмжийг сайжруулах
4	Түргэн тусламжийн төвийн Автобааз	Барилгын гадна дулаалгатай фасадны засварын ажлын төсөв	143.9 сая төгрөг	Барилгын гадна фасадны ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглах хугацааг нэмэгдүүлж, өнгө үзэмжийг сайжруулах
5		Автомашин угаалгын цех	300.0 сая төгрөг	Автомашин угаалгын цехийн барилгын эрүүл ахуйн шаардлага хангах
6	Түргэн тусламжийн төвийн Баянзүрх салбар	Барилгын дулаалгатай гадна фасадны ажил	60.7 сая төгрөг	Барилгын гадна фасадны ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглах хугацааг нэмэгдүүлж, өнгө үзэмжийг сайжруулах
7		Дээврийн ажлын төсөв	43.3 сая төгрөг	Барилгын тухай хууль болон “Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага” MNS 6392:2013 стандартын хэрэгжилтийг хангах
8	Түргэн тусламжийн төвийн Хан –Уул салбар	Гадна бохир усны шугамыг нэгдсэн эмнэлгийн худагт холбох ажлын төсөв	21.1 сая төгрөг	Төвийн холболт хийлгэж төсвийн үр ашиг, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх
9		Гадна цэвэр усны шугамыг нэгдсэн эмнэлгийн худагт холбох ажлын төсөв	11.3 сая төгрөг	Төвийн холболт хийлгэж төсвийн үр ашиг, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх
10		Бохир усны шугамыг төв шугамын худагт холбох ажлын төсөв	38.1 сая төгрөг	Төвийн холболт хийлгэж төсвийн үр ашиг, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх
Нийт дүн			9,362.4 сая төгрөг	

Дөрөв. Дэлхийн зөн олон улсын байгууллагаас гамшгийн үед авран хамгаалах, бэлэн байдлыг хангах 7 төрлийн, 38 ширхэг хөрөнгийг бэлэглэлийн 3 жилийн гэрээгээр 18.9 сая төгрөгөөр 2018.05.30 нд хүлээлгэн өгөв






Тав. Барилга, байгууламжийн ашиглалтыг нэмэгдүүлж, сайжруулах чиглэлээр 2018 оны батлагдсан төсвийн хүрээнд дотоод нөөц боломж, ажиллах хүчийг ашиглан дараах объектуудын төсөл, арга хэмжээнүүдийг урсгал төсвөөр санхүүжүүлсэн.

№	Төсөл арга хэмжээний нэр	Санхүүжүүлсэн эх үүсвэр /мян төгрөг/		Тодруулга, зураг	
		Улсын урсгал төсөв	Гүйцэтгэгч байгууллага, ажилчид, хийгдсэн сар		
1	Автобаазын ахуйн хог хаягдлын сав /шинээр хийсэн/	400.0 мян төгрөг	Өөрсдийн ажилчид /гор, төмөр, будаг зэргийг авч шинээр бэлтгэсэн/	04 сар	 <p>“Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага” MNS 6392:2013 стандартын хэрэгжилт</p>

2	Автобаазын гаражийг оффисоос тусгаарласан металл хаалт /хүйтэн агаарыг хааж ажилчдын ажиллах нөхцөлийг сайжруулсан/ 3 хаалга	2,918.5 мян төгрөг	Немон ХХК	02 сард	
3	Автобаазын ногоон байгууламжийн ажил	230.8	Ойн Ирээдүй ХХК-аас суулгац авч Өөрсдийн ажилчид	05 сард	Шар хуас 60 ш, монос суулгац 10ш /НЗД-ын ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал шийдвэрлэхэд хувь нэмэр оруулав/
4	Цайны газрын урсгал засвар	1,916.7		06 сард	Засварын бэлтгэл ажил явагдаж эхэлсэн



5	Ариун цэврийн өрөөнүүдийн хаалт хашлагийн засвар /урсгал засварын материал авч шинээр хийсэн/	698.1 мянган төгрөг	Улаан товгор ХХК-наас /шахма гэх мэтл хавтан, прус, булан төмөр, булан тогтоогч, цавуу, бэхэлгээ төмөр, ДСП хавтан , замган түгжээ/ бэлтгэж	өөрсдийн ажилчдын хүчээр хийсэн.	
6	Хан-Уул салбарын үүдэн хэсэгт харуулын тек /урсгал засварын материал авч шинээр хийсэн/			04 сард	
7	Хан-Уул салбарын эмнэлгийн хог хаягдлын өрөө /өгсөх шатны доод зайг ашиглан 2 тасалгаатай шинээр хийсэн/			02 сар	Урсгал зардлын төсвөөр MNS 5260:2015 стандартад тавигдах шаардлагын дагуу өөрсдийн ажиллах хүчээр барилгын урсгал засварын ажил хийсэн.
					
8	Сангийн өрөөг шинээр өргөтгөл барьсан	Одоогоор тоосго 323.6 мян төгрөг	Өөрсдийн ажилчдын хүчээр	11-12 саруудад	Диспетчерын өрөөний зэрэгцээ байгууламж барьж сангийн ажилчдын ажлын байр барьсан.
9	Харуулын объектын засвар	316.3 мян төгрөг	Өөрсдийн ажилчдын хүчээр	10 сард	Дээвэр шинэчилсэн, мөөгөнцөртэй хана шалыг засварласан, гадна пасадны ажил хийсэн. Дулааны холболтыг шинэчилж халаагуурыг өөрчилсөн.

10	Салбарын 10 худаг дулаалсан	217.2 мян төгрөг	Өөрсдийн ажилчдын хүчээр	10 сард	Өвөлжилтийн бэлэн байдлыг хангасан
11	Гарашийн гадаах удирдлагатай автомат хаалга	3,873.5 мян төгрөг	Тоонот хаалга ХХК	12 сард	Гарашийн зогсоолын дулаан алдалтыг хааж өвөлжилтийн бэлэн байдлыг хангасан
12	Барилга байгууламжуудын сантехникийн урсгал засвар	1,971.6 мян төгрөг	БЦНТ ХХК-аас бэлтгэж Өөрсдийн ажилчид	01-06 саруудад	Салбар төвүүд, төв, автобаазын сантехникийн эвдрэл, гэмтлийг цаг тухайд нь засаж байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангасан
13	Барилга байгууламжуудын цахилгааны урсгал засвар	4142.0 мян төгрөг		01-06 саруудад	Салбар төвүүд, төв, автобаазын цахилгааны эвдрэл, гэмтлийг цаг тухайд нь засаж байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангасан
	ДҮН	17,008.3			

1. *Автомашин* үзлэг, оношлогоо, даатгал, татварт хамруулж автомашины бэлэн байдлыг бүрэн ханган ажиллалаа. Уг ажилд

- тээврийн хэрэгслийн татварт 3,751.8 мянган төгрөг,
- үзлэг оношилгоонд 2,833.0 мянган төгрөг,
- тээврийн хэрэгслийн даатгалд 16.638.0 мянган төгрөгийн нийт 23,222.8 мянган төгрөг зарцуулав.

2. *Байгууллагын бэлэн байдлыг хангах талаар* эмнэлэг үйлчилгээг тасралтгүй хангахад ажилчдын хоол хүнсийг цалингийн нэмэгдэл хэлбэрээр бодож, автомашины зарим бага үнийн дүнтэй сэлбэг хэрэгслийг богино хугацаанд засварлан санхүүжүүлсэн.

3. *Дотоод сургалтын томилолтын зардлын талаар:* Герман улсын Эссен хотоос ариутгал халдваргүйтгэлийн сургалт явуулахаар ирсэн 2 багшийн зардалд ХБГ-ээр 3,902.0 мянган төгрөгийг /50 хувийг шилжүүлсэн/, Арлын Япон улсад 1 эмчийг эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд 3,546.8 мян төгрөг НИЙТ 7,448.8 мян төгрөг зарцуулав.

4. *Ажилчдын хувцас хангамж, зөөлөн эдлэл бэлтгэх талаар:* Эмч, жолооч нарын ажлын өвөл зуны 263 хос иж бүрэн хувцас, тогооч нарын ажлын хувцас 12 ширхэг, өвлийн ажлын гутал 6 ширхэг, суудлын бүрээс 42 иж бүрдлийг, насылkiны бүрээс 21 ширхгийг, оффисын ажилчдын халаад 14 ширхгийг үнийн харьцуулалтын аргаар худалдан авалтын үйл ажиллагааг зохион явуулж 28,478.4 мянган төгрөгөөр хийлгэж шийдвэрлэсэн.

- САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮР ДҮН, ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД ХЯНАЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

МУ-ын 2014.07.01-ны өдрийн “Шилэн дансны тухай” хуулийн дагуу хугацаанд нь мэдээ, мэдээлэл, тайлангуудыг 79 удаа мэдээлсэн.

2018 оны худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулах, олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх, ил тодоор нээлттэй хэлбэрээр шалгаруулахаар <https://open.ulaanbaatar.mn/>, Сангийн яамны дэргэдэх худалдан авах ажиллагааны газрын <https://tender.gov.mn/> сайтуудад толилуулав.

Эмийн болон шатахууны нягтлан бодогч нарын жолоочийн тооцоо бодолт, салбар, төвийн эмийн санч нарын тайлан тулгалтын дотоод хяналтын ажлууд сар бүр тогтмол хийгдэж гарсан зөрчил, дутагдлыг сар бүрийн цалингийн тооцоо бодолтоор суутгагдан барагдуулж байна. Эмийн сангийн программ хангамжийг жигдрүүлж Санхүүгийн тооцоолох групптэй хамтран ажиллаж эхэлсэн.

Өмнөх жилийн санхүүгийн тайлан, баланст хийгдсэн хөндлөнгийн аудитын хяналт, шалгалтаар илэрсэн акт, зөвлөмжийг дараах байдлаар хэрэгжүүлэн ажиллаж байна.

Үүнд:


1. Ээлжийн амралтын эдлэх хоногоос илүү буюу дутуу амарсан ажилчдын жагсаалтыг гарган хүний нөөц, нэгж албадын дарга нартай хамтран уг ажилчдыг нөхөж амраах хугацааг сар тутамд тохирч баримтжуулж байна.
2. Техникийн албаны гаргасан ээлжийн ажилчдын хуваарийн дагуу замын хуудас, дагалдах хуудсыг үндэслэн олгож, хянаж сар бүр хэвшсэн. Уг гүйцэтгэлд давхар хяналт хийгдэж байна. Цаашид GPS систем автомашин бүрд суулган хяналтыг газар дээр шууд хянаж тооцох боломж бүрдсэн.
3. Аудитаар илэрсэн зөрчил нь эмийн нэр төрлийг захиалгын хуудсанд худалдааны нэршлээр (Сальбутамол эмийн нэрийг вентолин гэдэг нэрээр) нэрлэгдсэн ижил болгосон.

Төрийн болон орон нутгийн эмчийн эд хөрөнгийн дахин үнэлгээ хийх бэлтгэл хангах зохион байгуулалтын арга хэмжээг авч 5 объект барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээ, орчны тохижилт, эдэлбэр газрын үнэлгээ хийх ажлын гүйцэтгэл 95 хувьтай дуусаж байна.

2018 оны санхүүгийн хөндлөнгийн хяналт, шалгалтаар НАГ-аас хуваарилсан “Цэгц төв” аудитын байгууллагаар хянуулахаар гэрээ байгуулан ажиллаж эхэлсэн.


МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

1. EMERGENCY INFORMATION NETWORK /EIN/ ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВАХ НЭГДСЭН СИСТЕМ



Уг системийг “Холбоо, хяналт, мэдээллийн нэгдсэн сүлжээ” төсөл хэрэгжсэнээр 2010 оноос нэвтрүүлэн ажиллаж байна. Мэдээлэл шуурхай удирдлагын төвтэй шилэн кабелиар холбогдон дуудлага дамжуулан ажилладаг.

2. PHARMACY - ЭМИЙН САНГИЙН БҮРТГЭЛИЙН ПРОГРАМ



Байгууллагын хүний нөөцийн алба болон чанарын албанд нэвтрэх эрх нээсэн ба уг системийг ашиглаж ирсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэн ажиллаж байна.

6. ЦАХИМ ГАРЫН ҮСГИЙН “MONPASS” ПРОГРАМ.




7. БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАС ХӨГЖҮҮЛЭЛТИЙН “Joomla” НЭЭЛТТЭЙ ЭХИЙН ПРОГРАМ.



Тус программыг ашиглан байгууллагын цахим хуудсыг бүтээсэн ба мэдээ мэдээллээр байршуулан ажиллаж байна.

8. “ARCHIVE eDOC” – АРХИВЫН ПРОГРАМ




Байгууллагын албан хаагчдаас үүсэж буй цахим баримтыг тус програмд архивлан эмх цэгцтэй хадгалдаг ба өдөр тутам ашиглаж байна.

9. “ACOLOUS” – НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ПРОГРАМ

Байгууллагын нягтлан бодогчид өдөр тутмын үйл ажиллагааны анхан шатны мэдээллийг бүртгэх, санхүүгийн мэдээ, тайлан гаргахад зориулагдсан, хамтдаа болон тус тусдаа бие даан ажиллах боломжтой дэд хэсгүүдээс бүрддэг програм юм.

10. “PAYROLL” – ЦАЛИНГИЙН ПРОГРАМ




11. ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭЛ, ЭВЛҮҮЛЭГ, БОЛОН БУСАД ХЭРЭГЛЭЭНИЙ ПРОГРАМ ХАНГАМЖУУДЫГ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД АШИГЛАЖ БАЙНА.

- Adobe Master Collection
- Microsoft Office 2010
- Windows Server, Linux server, Windows OS
- After Effect
- Navicat 12 for MySQL – серверийн үйл ажиллагааг хянах програм
- NOD32 - Хорт кодын эсрэг програм
- Бусад програм хангамжууд

12. “GPS” – АВТО МАШИНЫ ХЯНАЛТЫН ЦОГЦ СИСТЕМ НЭВТРҮҮЛЛЭЭ.

Нийслэлийн засаг даргын А/88 дугаар захирамжийн дагуу нийслэлийн түргэн тусламжийн төвийн автомашинуудад хяналтын GPS систем нэвтрүүлэх зорилгоор Нийслэлийн эрүүл мэндийн газраас зарласан тендерт VanqTech ХХК сонгогдож нийт 75 сая төгрөгийн үнэтэй “GPS хяналтын цогц системийг” нэвтрүүлээ.

Уг байршил тодорхойлох систем нь Google Map-ийн газрын зураг дээр харуулдаг ба EIN /Emergency Information Network/ програмтай холбогдож ажилладаг. 2018 оны 11 сараас эхлэн хүлээн авч ажиллаж байна.



Нийт 85 автомашинд “Meitrack T366” загварын хяналтын GPS суурилуулсан ба мэдээллийг үүрэн холбооны сүлжээгээр хяналтын сервер рүү дамжуулан төв болон салбаруудад хяналт тавин ажиллаж байна.

Уг программыг 2018 оны 11 сараас эхлэн автомашины гаралт, буултыг бүртгэж, автомашиныг хянаж эхэлсэн.

GPS программыг нэвтрүүлснээр дотоод хяналт сайжирч, жолоочийн тооцоо, эмнэлэг үйлчилгээнд үйлчлэх автомашинуудын шуурхай байдал нэмэгдсэн.

Мөн засвар үйлчилгээ хийлгэсэн дэлгэрэнгүй тайлан, автомашины хувийн хэрэгт хөтлөгдөх жолоочийн авсан шатахуун, явсан км, үйлчилсэн дуудлагын тоо, хийгдсэн бүхий л засвар үйлчилгээнүүд зэрэг жолооч болон автомашины дэлгэрэнгүй бүртгэлийг хялбараар гаргах боломжтой болсон юм.

GPS – суурилуулсан автомашинууд:

1	0327 УНТ	26	2340 УБҮ	51	8975 УНТ
2	0342 УНТ	27	2340 УНЕ	52	8979 УНТ
3	0352 УНТ	28	2360 УБҮ	53	8984 УНТ
4	0362 УНТ	29	2447 УНТ	54	9019 УНТ
5	0382 УНТ	30	2560 УБҮ	55	9029 УНТ
6	0514 УНТ	31	2570 УБҮ	56	9039 УНТ
7	0524 УНТ	32	2580 УБҮ	57	9049 УНТ
8	0547 УНС	33	2734 УНД	58	9054 УНТ
9	0548 УНС	34	2799 УНЭ	59	9064 УНТ
10	0564 УНТ	35	4847 УНЕ	60	9074 УНТ
11	0574 УНТ	36	6556 УНӨ	61	9084 УНТ
12	0594 УНТ	37	8323 УНИ	62	9214 УНЧ
13	1063 УНТ	38	8343 УНИ	63	9314 УНЧ
14	2205 УБҮ	39	8348 УНИ	64	9324 УНЧ
15	2207 УНТ	40	8358 УНИ	65	9354 УНЧ
16	2210 УБҮ	41	8363 УНИ	66	9762 УНЧ
17	2230 УБҮ	42	8368 УНИ	67	9794 УНЧ
18	2240 УБҮ	43	8373 УНИ	68	9849 УНЧ
19	2250 УБҮ	44	8904 УНТ	69	9854 УНЧ
20	2260 УНТ	45	8937 УНТ	70	9879 УНЧ
21	2275 УБҮ	46	8954 УНТ	71	9882 УНЧ
22	2295 УБҮ	47	8957 УНТ		
23	2305 УБҮ	48	8959 УНТ		
24	2310 УБҮ	49	8962 УНТ		
25	2315 УБҮ	50	8964 УНТ		

- ДОТООД ГАДААД СҮЛЖЭЭНИЙ ТАСРАЛТГҮЙ БАЙДАЛ:

Үүнд: НТТТ-ийн хэмжээнд төв, авто бааз, 3 салбар бүгд дотоод сүлжээ болон гадаад интернетийн сүлжээнд холбогдсон. Байгууллагын дотоод сүлжээ байнга ашиглаж өөр хоорондоо сүлжээг ашиглан мэдээлэл, файл дамжуулан ашигладаг. Нийт дотоод сүлжээнд холбогдсон 105 төвд 28, Автобаазад 18, Баянзүрх салбарт 11, СХД салбарт 8, Хан-уул салбарт 5 байна.

Сүлжээний тасралтгүй байдал, аюулгүй байдлыг хангах зорилгоор сүлжээний “Firewall” төхөөрөмж суурилуулсан.

Түргэн тусламжийн авто машины GPS-системийг хянах зорилгоор төв болон салбаруудад нэмж сүлжээ татаж суурилуулсан.



- Сүлжээнд гарсан гэмтлийг түргэн шуурхай засварласан байдал:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байгаа гадаад болон дотоод сүлжээний гэмтлийг цаг тухай бүрд шуурхай засварлан ажилладаг. Түргэн тусламжийн төв нь 24 цагийн үйл ажиллагаатай тусгай төрөлжсөн байгууллага бөгөөд шилэн кабелиар дамжуулан дуудлага хүлээн авч салбар төвүүд рүү дамжуулдаг. Иймээс сүлжээний тасралтгүй байдал маш чухал үүрэгтэй. Гэмтэл гарсан тохиолдолд түргэн шуурхай засварладаг. Мөн Мэдээлэл шуурхай удирдлагын төвтэй хамтран ажилладаг.

- Сүлжээний тасралтын тоо:

2018 оны 02 сард Сонгинохайрхан салбарын шилэн кабелийн сүлжээ зам засварын ажил хийж байсан техникийн үйл ажиллагаанаас шалтгаалан тасарч гэмтлийг түргэн шуурхай тодруулан засварласан.

Гадаад ба дотоод сүлжээг 24 цаг ашигладаг ба төв болон салбарын сүлжээ тасралтгүй хэвийн ажиллаж байна.

- Компьютер тоног, төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний чанар:

Байгууллагын тоног төхөөрөмж, компьютер, сервер, сканер, принтер, болон бусад төхөөрөмжийг ашиглах журам боловсруулсан ба түүний дагуу хэвийн ашиглаж байна. Мөн засвар үйлчилгээг цаг бүрд нь хийдэг ба, солих шаардлагатай болсон төхөөрөмжийн шинээр авч суурилуулан засаж сэлбэдэг. Засвар үйлчилгээний тэмдэглэл карт хөтөлдөг ба ашиглалтын хугацаа, элэгдлийг тооцож төлөвлөдөг.

Үүнд:

1. Байгууллагын хэрэглэгчийн компьютерт хийгдсэн үзлэг, оношилгоо, засварын тоо, чанар

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж, компьютер, хэвлэх төхөөрөмжид эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд түргэн шуурхай засварладаг ба засвар авах боломжгүй тохиолдолд шинээр сольж суурилуулдаг. Тухайн жилд тогны хэлбэлзлээс болж DELL Optiplex 3020 загварын 4 ш компьютерийн эх хавтан, 5 ш тэжээлийн блок шатсан ба шинээр авч суурилуулан хэвийн ажиллагааг хангаж



ажилласан.

Үзлэг оношилгоог 7 хоног бүр хийдэг ба, үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа бүх компьютерүүдэд вирусийн эсрэг “NOD32” 1 жилийн лицензтэй програм суулгасан.

ЦАХИМ ХУУДАСНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Нийслэлийн засаг даргын 2012 оны 10 сарын 08-ны А/606 тоот захирамжийг үндэслэн байгууллагын цахим хуудас ажиллуулах журмыг боловсруулан Нийслэлийн түргэн тусламжийн төвийн захирлын 2012 оны 11 сарын 26-ний дугаар 118 тоот тушаалаар “Цахим хуудас ажиллуулах журам”-ыг батлуулсан.

Мэдээлэл байршуулах эрхтэй хэрэглэгчийн тоо 1.



Цахим хуудсанд байршуулсан мэдээллийн тоо:

Тухай жилд байгууллагын цахим хуудсанд 263 мэдээ, мэдээлэл, зөвлөгөө, зарлал, бусад мэдээлэл байршуулсан.

Үүнд: Байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл, онцлох мэдээ, эрүүл мэндийн зөвлөгөө, цаг үеийн мэдээлэл, зарлал гэх мэт.

- *Цахим хуудсыг иргэдэд сурталчилсан байдал:*

Байгууллагын цахим хуудсыг иргэдэд сурталчлах зорилгоор дуудлагын эмч нарт тараах материал боршур зэргийг өгч дуудлага өгсөн айлд өгч байгаа. Мөн Facebook-ээр мэдээ мэдээлэл байршуулан сурталчилж байна.

Facebook-т сүүлийн үед их хандалттай байгаа Mr.Do пэйжийн админтай хамтарч “Түргэн тусламжийн автомашинд зам тавьж өгцгөө” сэдэвт видео шторк хамтран хийж маш олон хүний хандалт авсан.


- *Байгууллагаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээ, үнэ төлбөрийн мэдээлэл байршсан эсэх:*



Цахим хуудасны –Танилцуулга-Төрийн үйлчилгээ-Үйлчилгээний үнэ тариф – цэсэд үнэ тарифтай холбоотой мэдээлэл байршуулсан.

- Өргөдөл гомдол хүлээн авах хүний нэр, албан тушаал, холбоо барих утасны дугаарыг байршуулсан эсэх,


Байгууллагын цахим хуудасны баруун хэсэгт өргөдөл гомдлын булан /Module/ нээж мэдээ мэдээллээр баяжуулж байна. Өргөдөл гомдол хүлээн авах ажилтны мэдээлэл байршуулсан.



- *Байгууллагын хаяг байршлыг ойлгомжтой байдлаар байршуулсан байдал:*

Байгууллагын хаяг болон байршлыг харуулсан газрын зурагтай, холбоо барих утас зэрэг дэлгэрэнгүй мэдээлэл “холбоо барих” цэсэд оруулсан.

Байгууллагын цахим хуудсыг төлөвлөгөөний дагуу шинэ, сүүлийн үеийн мэдээллээр тогтмол шинэчлэн ажиллуулж байна. Цахим хуудсанд байх шаардлагатай мэдээ мэдээлэл бүрэн багтсан.



2018 онд байгууллагын цахим хуудсыг тогтмол шинэчлэн ажилласан. Цахим хуудсанд байгууллагын ил тод байдлын мэдээ мэдээлэл, иргэд үйлчлүүлэгчдэд хандсан нийгмийн эрүүл мэндийн мэдээ, мэдээлэл, байгууллагын дотоодод болж буй мэдээлэл, чанарын булан, гадаад харилцаа, дуудлагын статистик мэдээлэл, сургалт сурталчилгаа, эрүүл мэнд, анхан шатны тусламжийн зөвлөгөө, сэрэмжлүүлэг, хууль эрх зүйн зөвлөмж бичих болон байгууллага, үйл ажиллагаагаа сурталчлах зорилгоор өөрийн байгууллагын танилцуулга, бүтэц зохион байгуулалт, үүсэл хөгжил гэх мэт мэдээ мэдээллээр баяжуулан ажиллаж байна.

- Цахим хуудасны шинэчлэлт:



Байгууллагын цахим хуудсыг 2018 оны 02 сард бүтцийн шинэчлэлт хийсэн. Хэрэглэгчдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар зарим цэсийг нүүр хуудсанд байх тохиргоог хийж, мэдээлэл авах холбоонуудыг ил болгож өгсөн.

Мөн байгууллагын ажилчдад зориулсан албан хэрэг хөтлөлтийн хичээл заавар болон ERP, албан хэрэг хөтлөлтийн системийн шууд орох холбоосыг байршуулж өгсөн.


Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2011 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллагын вэбсайтад тавих шаардлага” MNS 6285:2011 стандарт, Засгийн газрын 2009 оны “Ил тод байдлын шалгуур үзүүлэлт батлах тухай” 143 дугаар тогтоолын дагуу байгууллагын цахим хуудсанд мэдээ

мэдээлэл байршуулах журам боловсруулан батлуулж журмын дагуу ажиллаж байна.

Цахим хуудсанд тавигдаж байгаа эрүүл мэндийн мэдээлэл, зөвлөгөө, нийгмийн эрүүл мэндийн мэдээ, зөвлөмж, заавар, тушаал, зэрэг бүхий л мэдээллийг Юникод ашиглан үсгийн фонтын алдаагүй нийтэлдэг.

Байгууллагатай холбоотой ил тод байдлын мэдээ, ашиглахад хялбар, видео, дүрс зураг, сургалтын файл зэргийг хэрэглэгчдэд журам стандартын дагуу цахим хуудсанд байршуулдаг.

-Цахим хуудасны хандалтын тоолуур:



Хандалт: 2016 онд – 250.864
 2017 онд – 375.362
 2018 онд – 519.818 – байна.



МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерүүдэд 27 ш вирусийн эсрэг “Nod32” 1 жилийн



лицензтэй програм суулгасан.

Мэдээллийн аюулгүй байдал болон бусад эрсдэлийг харгалзаж ажилчдын хэрэгцээт файл болон зураг дүрс зэргийг CD, DVD-д бичиж архивладаг. Мөн хатуу дискэнд хуулж хадгалдаг.



Интернетийн социал сувгийг хаасан байдал:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 138 дугаар тогтоолыг тус тус үндэслэн:




Байгууллын мэдээллийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдлыг хангаж цахим халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор байгууллагын ажилтан албан хаагчдын ажлын хэрэгцээний компьютерийн интернетийн сүлжээнээс

олон нийтийн сүлжээний /Facebook, Twitter, Instagram, Youtube/ -ний сайтуудад нэвтрэх эрхэнд хязгаарлалт хийсэн. Ингэснээр цахим хорт код болон бусад спам, вирус, мэдээллийн аюулгүй байдал алдагдахаас сэргийлж байна.

ОЛОЛТ АМЖИЛТ:

- Нийслэлийн засаг даргын А/88 дугаар захирамжийн дагуу нийслэлийн түргэн тусламжийн төвийн автомашинуудад хяналтын GPS систем нэвтрүүлэх зорилгоор Нийслэлийн Эрүүл мэндийн газраас зарласан тендерт VanqTech ХХК сонгогдож нийт 75 сая төгрөгийн үнэтэй “GPS хяналтын цогц системийг” нэвтрүүлээ.

Уг байршил тодорхойлох систем нь Google Map-ийн газрын зураг дээр харуулдаг ба түргэн тусламжийн дуудлага хүлээн авдаг E1N /Emergency Information Network/ програмтай холбогдож ажилладаг. 2018 оны 11 сараас эхлэн хүлээн авч ажиллаж байна.



- Олон улсын эмч нарын баярын өдрийг тохиолдуулан нийт ажилчдын авьяасыг нээх, хөгжүүлэх, хамт олны идэвх, хамтын оролцоог нэмэгдүүлэх, чөлөөт

цагийг зөв зохистой өнгөрүүлэх, хамт олны бүтээлч, зэрэг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор “Урлагийн наадам”–ыг амжилттай зохион байгуулсан.

Урлагийн наадамд амжилттай оролцсон мэдээлэл технологийн инженер С.Бямбасүрэн, их эмч М.Цэрэнчимэд, жолооч А.Гансүх нарт Монголын Эрүүл мэндийн ажилтны Үйлдвэрчний эвлэлийн Холбооны дарга Б.Мягмар “МҮЭ-ийн “Соёлын тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагналаа.



- Идэвхтэй хөдөлгөөн эрүүл амьдралын төлөө цэвэр агаарт амралтаа зөв боловсон өнгөрөөх, нийтийн биеийн тамир, сонирхогчийн спортыг хөгжүүлэх зорилгоор "Цасны баяр-2018" өвлийн өдөрлөг 2018 оны 02-р сарын 24-ны өдөр "Мөнгөн Улаанбаатар" оролцож Нийслэлийн "Шилдэг биеийн тамирын баг" цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулсан.



- Эрүүл мэндийн байгууллагуудын дунд болсон DENKCUP тэмцээнд амжилттай оролцож шөвгийн 8-д шалгарсан.



- “Гамшигт тэсвэртэй Улаанбаатар” төслийн хүрээнд НТТТ-д эмнэлгийн яаралтай тусламжийн үеийн техник хэрэгсэл гардуулан өглөө. Дэлхийн зөн

Монгол Олон Улсын байгууллага нь НҮБ-ын Гамшгийг бууруулах Олон Улсын стратегийн байгууллагаас санаачилсан “Гамшигт тэсвэртэй Хотуудыг бий болгоё” уриан дор хот, суурин газрын гамшгийн эрсдэлийг бууруулах, түүнийг даван туулах чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэх “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах” үндэсний хөтөлбөрт хувь нэмэр оруулах үүднээс “Гамшигт тэсвэртэй Улаанбаатар” төслийг 2 жилийн хугацаатай хэрэгжүүлж байна.



- 2018 оны 3 дугаар сарын 29, 30, 31 нд 5 толгой цэргийн анги дээр терростийн эсрэг “Хаан-Шонхор” ажиллагаанд эмнэлгийн багийн их эмч, сувилалч, жолооч нар оролцсон.



- 2018 оны 04 дүгээр сарын 19-нд тус байгууллагын эмч ажилчдын чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, тэдний эрүүл мэнд, бие бялдрын хөгжил бэлтгэлийг дэмжин, сайжруулах 3 өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Спортын 4 төрлөөр зохион байгуулагдсан тэмцээнд нийт 100 гаруй ажилчид оролцлоо. Сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, шатар гэсэн 4 төрлөөр зохион байгуулагдан аварга баг, тамирчдаа тодруулж урамшууллаа.




- Олон улсын эмч нарын өдрийг угтан чанарын албанаас “Чанарын өдөрлөг” зохион байгуулж, 2018 оны 03 дугаар сарын 30-ны Олон улсын эмч нарын өдрийг тохиолдуулан хүндэтгэлийн үйл ажиллагаанд удирдлагын зөвлөл, авто баазын төлөөлөл, дуудлагын 90 эмч оролцлоо.

Тус төвийн шинээр ажилд орсон 25 их эмч тангараг өргөж, эмч мэргэжлээрээ бахархах, эмчийн ёс зүй, харьцаа хандлага сайжирч, ажилдаа идэвх зүтгэлтэй ажиллах урам зориг өгсөн үйл ажиллагаа болж өнгөрлөө.



- Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн Чингэлтэй дүүргийн 14-р хороо 702 мк газрыг чөлөөлөн СБ болон ЧД-ийн 14-25 хорооны иргэдэд түргэн тусламжийн үйлчилгээг шуурхай, хүлээгдэлгүй, чанартай үзүүлэх зорилгоор Нийслэлийн засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан барилгын зураг төслийг “Уран асар” ХХК, 15 хувийн гүйцэтгэлтэй байна..



- 2018 оны 04 дүгээр сарын 14-21-ний хооронд Герман улсын Эссэн хотын Анагаахын их сургуулийн доктор Walter Popp тус төвийн 32 эмч, сувилагч, жолооч нарыг багаар газар дээрх яаралтай тусламж хэрхэн үзүүлэх талаар сургалт явуулснаар сургалтад хамрагдсанаар гардан үйлдлийн ур чадвар нэмэгдсэн.



- 2018 оны 3 дугаар сарын 01-ны №2/189 Илтгэл ирүүлэх тухай Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 80 жилийн ойг угтан “Чанарыг сайжруулъя” онол практикийн хурлыг зохион байгуулж тус байгууллагын хэмжээнд 12 илтгэл оролцлоо. Үүний үр дүнд эмч нарын судалгаа хийх, илтгэл тавих чадвар нэмэгдсэн.



- Гамшиг, онцгой байдлын үеийн эмнэлгийн тусламж үзүүлэх үндэсний баг бэлтгэх сургалтын хөтөлбөрийн хүрээнд Япон улсын сургагч багш нар ирж 2018.04.23-04.26 хооронд ЭМЯман дээр 3 өдрийн сургалтыг зохион байгуулагдлаа. Тус сургалтад гамшгийн үед тусламж үзүүлэх эмнэлгийн багууд хамрагдсанаас нийслэлийн түргэн тусламжийн төвөөс 4 их эмч, 4 сувилагч хамрагдлаа. Үр дүн: энэхүү сургалт зохион байгуулснаар Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын гамшгийн үеийн тусламж үйлчилгээ болон хариу арга хэмжээ, гамшгийн үеийн түргэн тусламж, бэлэн байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлж, тусламж, үйлчилгээний чанар, чадавх дээшилнэ. Дэвшилтэд техник технологи, мэдээ мэдээллийг суралцаж, цаашдын яаралтай тусламжийн чиглэлийн харилцаа холбоотой ажиллахаар болсон.



- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, эх үрсийн баярыг тохиолдуулан байгууллагын ажилчдын хүүхдүүдэд бэлэг гардуулан өгсөн. Мөн авто баазын хашаанд хүүхдийн тоглоомын талбай засаж, хүүхдүүдийн дунд уралдаан тэмцээн зохион байгуулж шагнаж урамшуулсан.



- Мэдээлэл шуурхай удирдлагын төвөөс зохион байгуулсан цэргийн баярын нэрэмжит буудлагын тэмцээнд манай байгууллагаас нийт 5 тамирчин оролцсоноос эрэгтэй гар буу 25 м-т 1-р байр, эмэгтэй винтовоор 50 м 1-р байр эзэлж багаараа тэргүүн байранд шалгарлаа. Мөн эмч Алтанзагас 3-р байранд шалгарав.



- Спортын 4 төрлөөр зохион байгуулагдсан тэмцээнд нийт 100 гаруй ажилчид оролцлоо. Сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, шатар гэсэн 4 төрлөөр зохион байгуулагдсан тэмцээнд багийн дүнгээр 3-р ээлжийн эмч нарын баг түрүүлж, дэд байранд 2-р ээлжийн эмч нарын баг орлоо.



- 2018 оны 10 дугаар сарын 03-ны өдөр “Өргөө” амаржих газрын сургалтын танхимд Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа 24 байгууллагын 186 бүтээл оролцсон. 5 номинациар 3 шалгуур үзүүлэлтээр шалгаруулсан. Сайн туршлага-2018”-д 5-н бүтээл орж батламж авсан. Шилдэг 20 бүтээлд “Түргэн тусламжийн эмчийн жижиг цүнх” шалгарч гэрчилгээ авлаа.



- Хуурай эмийн уут: Түргэн тусламжийн үед хэрэглэгдэх хуурай эмийг гадны нөлөөллөөс бохирдох, гэмтэх, хадгалалтын горим алдагдахаас урьдчилан сэргийлж, ариун байдлыг хадгална.



- Жил бүр нийт ажилчдын дунд уламжлал болон зохион байгуулагдаж буй Үндэсний бөхийн бэсрэг наадмыг жолооч нарын 2-р ээлжийн хамт олон амжилттай зохион байгуулж жолооч Г.Анхныбаяр тэргүүн байр эзэллээ.



- Автобаазын засварын цехэд автомашин угаах ариутгалын цэг байгуулан, халдвар хамгааллаас сэргийлэн ажиллаж байна. Уг цэгийг байгуулахад нийт 273020 төгрөг зарцуулсан.



- Автобаазын гадна талбайд ногоон байгууламж байгуулах зорилгоор цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил хийж байна.



- Цагаан давааны цэг дээр амьдарч буй иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ хараахан авч чаддаггүй, харьяалалгүй иргэд байдаг. Тиймээс нийгэмд хүлээсэн үүргээ хариуцлагатайгаар ухамсарлаж тухайн иргэдэд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлсэн. Эрүүл мэндийн үзлэг, сайн үйлсийн аяны үйл ажиллагаанд нийт 38 насанд хүрэгчид, 3 хүүхэд хамрагдав. Техникийн албанаас эмч нарын үзлэг хийх майхныг барьж бэлтгэн, иргэдэд халуун аарц, чацаргана уулгаж, сэндвич тараалаа. Мөн сайн үйлсийн аяны хүрээнд байгууллагын ажилчдаас цуглуулсан 3 уут хуучин хувцсыг иргэдэд тараасан. “Сайн үйлс-2018” аяны хүрээнд иргэдэд тараах аарц, чацаргана, сэндвич хийх материал, 1 удаагийн аяга гэх мэт зардалд 150000 төгрөг зарцуулав. Техникийн албанаас сайн үйлсийн аянд ерөнхий инженерээр удирдуулсан ашиглалтын инженер, техникийн тоо бүртгэгч, эмнэлгийн тоног төхөөрөмжийн техникч, жолооч Б.Баяраа, Ү.Гантулга, Сан.Энхсайхан, Э.Төмөрбаатар нарын бүрэлдэхүүнтэй баг ажиллав.



- “Сайн үйлс-2018” аяны хүрээнд автобаазын хамт олон жолооч нарын дундаас амьдралын нөхцөл боломж тааруу гурван жолоочийг сонгон нийт 1460000 төгрөгийн буцалтгүй тусламж үзүүллээ. Уг тусламжид түлээ нүүрс, оршин суугаа гэрийн хашааг шинэчлэх, засварлах зэрэг ажлыг гурван ээлжийн жолооч нар ээлж хамт олноо зохион байгуулж, идэвхтэй оролцлоо.



ХЯНАСАН:
ЗАХИРАЛ

Ц.ПҮРЭВДАШ

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:
ДЭД ЗАХИРАЛ

С.АРИУНБОЛД